

Батлав:

БОАЖЯ-НЫ ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ:

БОАЖЯ-НЫ ШИНЖЭЭЧ:



ГЭНХМӨНХ

О.Амгаалас

**ДОРНОД АЙМГИЙН, ХЭРЛЭН СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ
“ДОРНОД БУСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ” ТӨХК-ИЙН
“ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ
НӨЛӨӨЛЛИЙН НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ НЭМЭЛТ
ТОДОТГОЛЫН ТАЙЛАН**

ТАЙЛАН БОЛОВСРУУЛСАН:

“Эко Ти Эс Би” ХХК-ний захирал

А.САНЖААЖАМЦ



ТАНИЛЦСАН:

“Дорнод бусийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн
захирал

Г.ОТГОНБААТАР



АГУУЛГА

ТАЙЛАНГИЙН ТЕХНИКИЙН БУС ХУРААНГУЙ.....	5
ОРШИЛ.....	15
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭ	16
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ	28
1.1 Төслийн ерөнхий мэдээлэл.....	28
1.2 Төсөл хэрэгжүүлэгчийн товч танилцуулга	30
1.3 Бүтэц зохион байгуулалт, хүний нөөц.....	30
1.4 Төслийн хүчин чадал.....	31
1.5 Төслийн төлөвлөлт	32
1.6 ДЦС-ын үндсэн ба туслах тоноглол	33
1.7 Түлшний хангамж, дамжуулах тоноглол	41
1.8 Техникийн усан хангамж	45
ХОЁРДУГААР БҮЛЭГ: ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ	49
2.1 Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл.....	49
2.2 Газрын гадарагад үзүүлэх гол ба болзошгүй нөлөөлөл	52
2.3 Агаарын чанарт үзүүлэх гол ба болзошгүй нөлөөлөл.....	55
2.4 Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх гол болон болзошгүй нөлөөлөл.....	67
2.5 Ургамлан нөмрөгт үзүүлэх гол болон болзошгүй нөлөөлөл.....	70
2.6 Амьтны аймагт үзүүлэх гол болон болзошгүй нөлөөлөл	72
2.7 Гадаргын болон газрын доорх усанд үзүүлэх гол болон болзошгүй нөлөөлөл.....	74
2.8 Нийгэм эдийн засагт үзүүлэх гол болон болзошгүй нөлөөлөл	77
2.9 Хуримтлагдах нөлөөлөл	78
ГУРАВДУГААР БҮЛЭГ: СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ, АРИЛГАХ, АРГА ХЭМЖЭЭ	79
3.1 Аливаа барилгын ажлын үед үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах аргазүй, зөвлөмж	79
3.2 Газрын гадарга, хэвлэйд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	79
3.3 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ.....	80
3.4 Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ.....	87
3.5 Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	90
3.6 Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	91
3.7 Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах зөвлөмж	92
3.8 Ногоон байгууламж байгуулах зөвлөмж	93
3.9 Ногоон технологи ашиглах тухай зөвлөмж	97



3.10 Химиин хорт болон аюултай бодис тээвэрлэх үеийн сөрөг нөлөөллөөс сэргийлэх арга хэмжээний зөвлөмж	98
3.11 Химиин хорт болон аюултай бодис хадгалах үеийн сөрөг нөлөөллөөс сэргийлэх арга хэмжээний зөвлөмж	99
3.12 Химиин бодисын сав, баглаа боодлын хог хаягдлын талаар авч хэрэгжүүлэх зөвлөмж..	100
3.13 Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээний зөвлөмж.....	100
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ: ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ, МЕНЕЖМЕНТ	103
4.1 Эрсдлийн үнэлгээг хийсэн аргачлал.....	103
4.2 Төслийн хүрээнд импортлох, ханган нийлүүлэх химиин бодис, материалуудын хор, аюулын ангилал	105
4.3 Хүний эрүүл мэндэд учруулах эрсдлийн үнэлгээ	108
4.4. Байгаль орчинд үзүүлэх эрсдэлийн үнэлгээ.....	113
4.5 Физик аюулын эрсдлийн үнэлгээ.....	114
4.6 Эрсдлийг бууруулах арга хэмжээний зөвлөмж	115
ТАВДУГААР БҮЛЭГ: ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ.....	126
5.1 Дулааны цахилгаан станц төслийн үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлын эх үүсвэрүүд	126
5.2 Хог хаягдлын тооцоо.....	127
5.3 Хог хаягдлын менежментийн стратеги.....	130
5.4 Хог хаягдлыг бууруулах.....	130
5.5 Хог хаягдлыг ангилан ялгах	130
5.6 Хаягдлыг дахин ашиглах, дахин боловсруулах.....	132
5.7 Хаягдлыг зайлцуулах, устгах	133
5.8 Ахуйн болон тусгай ангиллын хог хаягдлын ангилан ялгалт хийх зөвлөмж.....	134
НЭГДСЭН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ.....	137
АШИГЛАСАН МЭДЭЭЛЭЛ, ЭХ СУРВАЛЖ.....	140



ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1 Хууль	16
Хүснэгт 2 Төслийн үйл ажиллагаатай холбоотой стандартууд	25
Хүснэгт 3 Станцын хүчин чадал	31
Хүснэгт 4 Уурын зуухны техникийн үзүүлэлт	33
Хүснэгт 5 Уурын турбины техникийн үзүүлэлт	34
Хүснэгт 6 Генераторын техникийн үзүүлэлт	34
Хүснэгт 7 Уурын зуухны техникийн үзүүлэлт	35
Хүснэгт 8 ДЦС-ын жилд хэрэглэх нүүрсний хэрэглээ	41
Хүснэгт 9 Гүний худгийн мэдээлэл	45
Хүснэгт 10 Үйлдвэрлэсэн эрчим хүч ба усны хэрэглээ	46
Хүснэгт 11 Матриц	50
Хүснэгт 12 Нөлөөллийн үнэлгээг хийсэн аргачлал	51
Хүснэгт 13 Нөлөөллийн үнэлгээний систем	51
Хүснэгт 14 Нөлөөллийн зэрэг	52
Хүснэгт 15 Магадлан жагсаалт	54
Хүснэгт 16 Агаарын хэмжилт	55
Хүснэгт 17 Гаалийн талбай дээр нүүрс буулгах ачихад ялгараах тоосны хаягдлын фактор	57
Хүснэгт 18. Хангамжийн талбайд нүүрс буулгахад ялгараах тоосны хэмжээ	58
Хүснэгт 19. Бульдозерын нэг цагт болон жилийн хугацаанд ажиллах үед ялгараах тоосны хаягдлын хэмжээ	58
Хүснэгт 20 ЕМЕР/ЕЕА-ын цахилгаан станцын зуухны ялгарлын фактор	59
Хүснэгт 21 Дулааны станц ялгараах агаар бохирдуулагч бодисын ялгарын хэмжээ, тн/жил	60
Хүснэгт 22 Хөрсний шинжилгээ	69
Хүснэгт 23 Магадлан жагсаалт 1	70
Хүснэгт 24 Магадлан жагсаалт 2	72
Хүснэгт 25 Магадлан жагсаалт 3	73
Хүснэгт 26 Магадлан жагсаалт 4	77
Хүснэгт 27 Болзошгүй хуримтлагдах нөлөөлел	78
Хүснэгт 28 Усалгааны систем	95
Хүснэгт 29 Усалгааны систем	96
Хүснэгт 30 Усалгааны дундаж норм, услах тоо	97
Хүснэгт 31 Төслийн хүрээнд импортлох, хадгалах, худалдаалах химийн бодис, материалуудын хор, аюулын ангилал	106
Хүснэгт 32 Төсөлд хэрэглэгдэх химийн бодис, материалуудын хор, аюулын нэгдсэн дүн	108
Хүснэгт 33 Хүний эрүүл мэндэд учруулах хор, аюулын тодорхойлолт	109
Хүснэгт 34 Хурц хоруу чанарын зэрэглэлийн элементүүд	110
Хүснэгт 35 Нүдийг ноцтойгоор гэмтээх/нүд цочроох зэрэглэлийн элементүүд	111
Хүснэгт 36 Арьс түлэх/цочроох зэрэглэлийн элементүүд	111
Хүснэгт 37 Үр хөврөл, эс, генийн өөрчлөлт бий болгох зэрэглэлийн элементүүд	111
Хүснэгт 38 Хорт хавдар үүсгэх зэрэглэлийн элементүүд	112
Хүснэгт 39 Нөхөн үржихүйд нөлөөлөх зэрэглэлийн элементүүд	112
Хүснэгт 40 Нэг удаагийн хордолтоор тодорхой эрхтнийг байлж хордуулах зэрэглэл	113
Хүснэгт 41 Давтан хордолтоор тодорхой эрхтнийг байлж хордуулах зэрэглэл	113
Хүснэгт 42 Усан орчинд нөлөөлөх зэрэглэлийн элементүүд	114
Хүснэгт 43 Физикийн аюулын тодорхойлолт	114
Хүснэгт 44 Шатамхай шингэнүүдийн зэрэглэлийн элементүүд	114
Хүснэгт 45 GHS/CLP –аюулын тэмдэглэгээнүүд	116
Хүснэгт 46 GHS/CLP –Анхааруулах тэмдэглэгээ	118
Хүснэгт 47 Дүрс тэмдэглэгээнүүд	121
Хүснэгт 48 Бие хамгаалах хэрэгсэл	122
Хүснэгт 49 Нэг литр хэмжээтэй, шингэн хүчлүүд ба шүлтийг саармагжуулахад үүсэх шингэн хаягдлын тооцоо	123
Хүснэгт 50 Химийн бодисуудыг агуулахад ангилж хадгалах "JT BAKER" өнгөний код	124
Хүснэгт 51 Хог хаягдлын код	126
Хүснэгт 52 Хатуу хог хаягдлын тооцоо	128
Хүснэгт 53 Энгийн хог хаягдлын жагсаалт	131
Хүснэгт 54 Аюултай, хяналттай хог хаягдлын жагсаалт	132



Хүснэгт 55 Хог хаягдал ангилах	134
Хүснэгт 56 Хог хаягдлыг дахин боловсруулах ашиглах чиглэлээр авах арга хэмжээ	136

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1 Төслийн талбай	28
Зураг 2 Төслийн байршил.....	29
Зураг 3 Технологийн схем	32
Зураг 4 ДЦС-ыг өргөтгэх талбай.....	32
Зураг 5 ДЦС-ын өргөтгөл хийх талбарт өргөтгөлийн байшин, зуух ба турбин, яндан, нүүрс нөөцлөх талбайн (өргөлийн штабель) байршлыг үзүүлсэн зураг	33
Зураг 6 Шинэ яндангийн болон багер, үнс зайлцуулах шугамын байрлал.....	35
Зураг 7 Уутат шүүлтуүрийн технологи.....	36
Зураг 8 ДЦС-ын үнсэн сангийн ерөнхий байдал.....	37
Зураг 9 Үнсэн санггуудын байршил	37
Зураг 10 Тунгаасан усны насос станцын байршил	38
Зураг 11 Урын турбин тоноглолын байршлын зураг.....	39
Зураг 12 Хөргөх цамхгийг байгуулах байршил	40
Зураг 13 Адуунчулуун ордоос нүүрс тээвэрлэх замын зураг	42
Зураг 14 Түлш дамжуулах цехийн ажиллагааны бүдүүвч зураглал.....	43
Зураг 15 ДЦС-ын 50 МВт-ын өргөтгөлийн түлш дамжуулах байгууламжийн байршлын тойм зураг	43
Зураг 16 Мазут аж ахуйн байршил ба өргөтгөлийн зуухыг шингэн түлшинд холбох шугамын тойм зураг	45
Зураг 17 Шинээр гаргах худгийн байршил.....	47
Зураг 18 Үнсэн сан	52
Зураг 19 Газар ашиглалт	53
Зураг 20 Агаарын хэмжилт.....	55
Зураг 21 Дулааны станцаас ялгараах хүхэрлэг хийн тархалт (жилийн дундаж), мкг/м ³	61
Зураг 22 Дулааны станцаас ялгараах азотын ислүүдийн тархалт (жилийн дундаж) ,мкг/м ³	62
Зураг 23 Дулааны станцаас ялгараах нүүрстөрөгчийн дутуу ислийн тархалт (8 цаг дундаж), мкг/м ³	62
Зураг 24 Дулааны станцаас ялгараах PM2.5 тоосонцрын тархалт (жилийн дундаж).....	63
Зураг 25 Нүүрс буулгах талбайн үйл ажиллагаанаас ялгараах TSP тоосонцрын тархалт (жилийн дундаж).....	63
Зураг 26 Нүүрс буулгах талбайн үйл ажиллагаанаас ялгараах PM10 тоосонцрын тархалт (жилийн дундаж).....	64
Зураг 27 Хөрсөн бүрхэвч	68
Зураг 28 Ургамлан нөмрөг	71
Зураг 29 ДЦС-ын одоо ашиглаж байгаа эргэлтийн усан сан	76
Зураг 30 Тороор хучих арга.....	83
Зураг 31 Салхины хаалтын үр дүн.....	84
Зураг 32 Салхины хаалт хэрэглэж буй жишээ.....	84
Зураг 33 Шувуу үргээх төхөөрөмж	92
Зураг 34 Дуслын усалгааны системийн схем	96
Зураг 35 Химийн бодисын эрсдлийн дүр зураг.....	103
Зураг 36 Ахуйн хог хаягдал ангилан хийх сав	135
Зураг 37 Хог хаягдал хуримтлуулан зайлцуулах сав	135



ТАЙЛАНГИЙН ТЕХНИКИЙН БУС ХУРААНГУЙ

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг Монгол улсын Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, байгаль орчны эрх зүйн баримт бичгүүд, Байгаль Орчин, Ногоон Хөгжлийн яамны Сайдын 2014 оны 04 сарын 10-ны өдрийн А-117 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх аргачлал”, Байгаль орчин ,аялал жуулчлалын яамны ерөнхий үнэлгээний дүгнэлт зэрэгт тулгуурлан байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд өргөн хэрэглэгддэг матриц, магадлан жагсаах, давхцуулан зураглах, загварчлалын арга, харьцуулсан судалгааны аргуудыг ашиглан хийж гүйцэтгэлээ.

БОЕҮ-ний дүгнэлтээр өгсөн анхааруулгууд:

Дулааны цахилгаан станц төслийн ерөнхий үнэлгээний дүгнэлтийг БОАЖЯамны холбогдох мэргэжилтэн 2022 оны 06 сарын 28-ны өдөр гаргаж 13/1624 тоот албан бичгээр төсөл хэрэгжүүлэгчид хүргүүлсэн ба төслийн ерөнхий үнэлгээний гүйцэтгэлээр уг төсөлд шинээр батлагдсан аргачлалын дагуу Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэх шаардлагатай гэж үзээд дараах асуудлуудыг онцгойлон анхаарахыг чухалчилсан байна. Ерөнхий үнэлгээний дүгнэлтэнд заасан онцгойлон анхаарах асуудлуудыг БОННҮ-ний тайланд дараах байдлаар авч үзэн болно.

№	Ерөнхий үнэлгээний дүгнэлтийн шаардлагууд	БОННҮ-нд авч үзэн байдал
1	Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг батлагдсан аргачлалын дагуу боловсруулах, тухайн багийн ИНХ-аар хэлэлцүүлэх	Байгаль Орчин, Ногоон Хөгжлийн яамны Сайдын 2014 оны 04 сарын 10-ны өдрийн А-117 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг боловсруулсан. Дорнод аймгийн Хэрлэн сумын 1 дүгээр багийн иргэдийн хурлын тэргүүлэгчдийн тогтоол, тэмдэглэл 2022 оны 10 сарын 06 өдрийн 03 дугаар
2	Дулааны цахилгаан станцын хаягдлын сангаас үүсэх нөлөөллийг нарийвчилан тооцож тайланд тусгах	Хаягдлын сангаас үүсэх нөлөөллийг нарийвчилан тооцож, түүнийг бууруулах арга хэмжээний зөвлөмжийг тайланд тусгасан.
3	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэгт “Төсөл хэрэгжүүлэгч нь холбогдох эрх бүхий байгууллагаар баталгаажсан техник-эдийн застгийн үндэслэл..” -ийг бүрдүүлнэ гэсний дагуу ТЭЗҮ боловсруулж баталгаажуулан, БОННҮ-нд хавсаргах	Батлагдсан ТЭЗҮ-ийн шийдвэр болон нүүрийг тайланд хавсаргав.
4	Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх аливаа сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг тусгасан Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулж, түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг нарийвчлан гаргах	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” Монгол Улсын хууль, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10-р сарын 29-ны өдрийн А/618 тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, Байгаль орчин аялал жуулчлалын яамнаас гаргасан ерөнхий үнэлгээний дүгнэлтэд заасан шаардлагын дагуу боловсруулсан.



5	Төслийн үйл ажиллагааны явцад унд ахуйд ашиглах цэвэр усны хэрэглээний хэмжээг эх үүсвэртэй уялдуулан, түүнээс гарах ахуйн бохир усыг тус тус нарийвчилан тооцох, түүнчлэн хог хаягдлын менежментийн асуудлыг бүлэг болгон байгаль орчинд халгүйгээр зайлцуулах аргыг нарийвчилан тодорхойлох	Төслийн усан хангамжийн эх үүсвэр, усны хэрэглээг тооцоолж тайланд тусгасан. Хог хаягдлын менежментийн асуудлыг бүлэг болгон тайланд тусгасан.
6	БОННУ-нд байгаль орчинд ээлтэй, олон улсын стандартад нийцсэн технологийг ашиглах талаар заавар, зөвлөмжийг боловсруулах	Холбогдох заавар, зөвлөмжийг боловсруулан тайлангийн 3-р бүлэгт оруулсан.
7	Төслийн үйл ажиллагааны явцад баримтлах хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгаа, ажиллагсадын эрүүл мэнд, ажлын байрны эрүүл ахуйн талаар зөвлөмж , дүгнэлт боловсруулах	Тайлангийн 3-р бүлэгт зөвлөмж боловсруулан тусгасан.
8	Нарийвчилсан үнэлгээ хийх явцад төслөөс байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлж болзошгүй серөг нөлөөллийг тогтоон , түүнээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний талаар зөвлөмж боловсруулан тайланд тусгах	Тайлангийн 2 болон 5-р бүлэгт зөвлөмж боловсруулан тусгасан.
9	Байгаль орчныг хамгаалах тухай” хуулийн 10 ⁻ р зүйлд заасны дагуу байгаль орчны төлөвлөгөөт аудитыг 2 жил тутамд төслийн үйл ажиллагаанд хийх асуудлыг холбогдох зардлын хамт тайланд тусгах	Тайлангийн 3-р бүлэг болон Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасан.
10	Төслийн хүрээнд баригдах дэд бүтцийн барилга, байгууламжийн батлагдсан зураг таслийг тайланд хавсаргах бөгөөд ариун цэврийн байгууламжийн шийдлийг зайлшгүй тусгах шаардлагатай ба халаалтын асуудлыг байгаль орчинд ээлтэй аргаар шийдвэрлүүлэн тусгах шаардлагатай	Батлагдсан зураг төслийг тайланд хавсаргасан.
11	“Тэрбум мод” хөтөлбөрийн хүрээнд төслийн хүчин чадалтай уялдуулан тарих модны тоо, төрөл зүйлийг тайланд тодорхой тусгах	Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг БОМТ-ний орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө хэсэгт тусгасан.
12	Төслийн үйл ажиллагаанаас сууриншилийн бүсэд нөлөөлж байгаа эсэхийг нарийвчилан тооцож тайланд тусгах	Тайлангийн 2-р бүлэгт серөг нөлөөллийг тодорхойлж, 3-р бүлэгт зөвлөмж боловсруулан тусгасан.
13	“Химийн хорт болон аюултай бодисын тухай” хуулийн 8,9,10,12,13,14,17,18 дугаар зүйл, заалтуудыг тогтмол мөрдөж ажиллах	Тайлангийн 3 болон 4-р бүлэгт химийн бодис ашиглахтай холбоотой зөвлөмжийг тусгасан.
14	Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журмын 2.3, 3.1 дэх заалтыг тайланд тусгах	Тайлангийн 3-р бүлэгт тусгасан.
15	“Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулхын /Ерөнхий шаардлага MNS 6458:2014 стандартыг/ баримтлах, тайланд тусгах	Тайлангийн 3-р бүлэгт тусгасан.
16	БОНХ-н сайд Эрүүл мэндийн сайд, Онцгой байдлын ерөнхий газрын даргын хамтарсан	Эрсдэлийн үнэлгээг Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд, Эрүүл мэндийн сайд, Онцгой



	2012 оны А-50/378/565 дугаар тушаалаар батлагдсан аргачлалын дагуу Химиин бодисын эрсдэлийн үнэлгээг хийх	байдлын өрөнхий газрын даргын хамтарсан 2012 оны 10 р сарын 25-ны өдрийн №А-50/378/565-р тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Химиин хорт болон аюултай бодисын эрсдэлийн үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу боловсруулсан.
17	Хог хаягдлын тухай хууль , тогтоомжийг мөрдөх	Тайлангийн 5-р бүлэгт тусгасан.

Төслийн товч танилцуулга:

Монгол улсын Засгийн газар Зүүн бүс нутгийн эрчимтэй хөгжлийг хангах, Чойбалсан хотыг аж үйлдвэржүүлэн хөгжүүлэх зорилгоор 1967 оны 06 дугаар сарын 17-ны өдөр тус цахилгаан станцын суурийг тавьж, 1967-1970 онд ЗСБНХУ-ын (хуучин нэрээр) техник эдийн засгийн тусламжаар 12МВт-ын суурилагдсан хүчин чадалтай Дулааны цахилгаан станц баригдан ашиглалтанд орж, 1979-1982 онд Дулааны цахилгаан станцыг БКЗ-75-39/ФБ маркийн 3 зуух, ПТ12-35/10М маркийн 2 турбогенератораар өргөтгөж станцын хүчин чадал 36 МВт болж нэмэгдсэн.

Үндсэн үйл ажиллагааны хувьд тус компани цахилгаан дулаан үйлдвэрлэх түгээх зохицуулалттай хангах, цахилгаан импортлох эрчим хүчний тоноглолд засвар туршилт хийх, цахилгаан эрчим хүч дулааны эрчим хүчний тоолуур гүйдлийн трансформатор суурилуулах засварлах зэрэг 9 тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг. Зүүн бүс нутгийн 36 сум суурин газрын 26346 айл өрх, 2161 аж ахуйн нэгж, байгууллага, 15 уул уурхай, газрын тос олборлолтын компаниудыг 0.4, 6, 10, 15, 35, 110кв-ын 3493.1 км агаарын болон кабель цахилгаан дамжуулах шугам, 507 ком дэд станцыг ашиглан цахилгаанаар хангаж байна. Мөн Чойбалсан хотын 878 аж ахуйн нэгж, 6658 айл өрхийн хэрэглэгчдийг 26,5 хос км далд болон ил шугамаар дамжуулан дулаанаар ханган ажиллаж байна.

Дорнод бүсийн эрчим хүчний системийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний урт 2011 онд 3125.34 км байсан бол 2017 онд 3492.9 км болж 12%-иар өсөж, үйлдвэрлэлийн суурилагдсан хүчин чадал ашиглалт цахилгаанаар их ачааллын үед 100%-аас давж, 2015-2016 оноос эхлээд өвлийн их ачааллын хугацаанд ЦЭХ-ний хэрэглээг бүрэн хангах боломжгүй болсон тул Сүхбаатар аймгийн хэрэглэгчдийг ТБЭХС-д шилжүүлж, станцын үндсэн тоноглолтууд бэлтгэлгүйгээр ажиллаж эхэлжээ. Цахилгааны оргил ачаалал суурилагдсан хүчин чадлаас давж 2017 онд 38.6 МВт хүрсэн ба цаашид бүс нутгийн ЦЭХ-ний өсөлтийг тогтвортой хангах боломжгүй болсон байна.

Энэхүү эрчим хүчний хэрэглээний огцом өсөлтийг хангах, эрчим хүчний найдвартай эх үүсвэрээр хэрэглэгчдийг хангах нь Зүүн бүс нутгийн эрчим хүчний хангамжийн тулгамдсан асуудал болж байна. Иймээс Монгол Улсын Засгийн газраас мөрийн хөтөлбөртөө эхний ээлжид богино хугацаанд хэрэгжих боломжтой хувилбар болох Чойбалсангийн ДЦС-ыг 50 МВт-аар өргөтгөх төслийг хэрэгжүүлэхээр техник эдийн засгийн үндэслэл боловсруулан Эрчим хүчний яамны Шинжлэх ухаан технологийн зөвлөлөөр хэлэлцүүлж дэмжигдсэн байна.

Төсөл хэрэгжсих газрын байгаль орчны толов байдал:

Физик газарзүйн нохцол: “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн Дулааны цахилгаан станц төсөл нь Дорнод аймаг, Хэрлэн сумын нутагт хэрэгжиж байна. Байгалийн бүс бүслүүрийн хувьд хуурай хээрийн бүсэд оршино. Байрзүйн зургийн М50-134 планшет дээр байрлана. Дорнод аймгийн Хэрлэн сумын нутаг дэвсгэрт, Дорнод аймгийн Засаг даргын 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/599 тоот шийдвэрийг үндэслэн , нэгж талбарын 2106000271 дугаар бүхий 258150 м2 /25.8 га/ газрыг 12 жилийн хугацаатай Албан контор, үйлдвэрлэлийн зориулалтаар эзэмшүүлэхээр



2018 оны 01 дугээр сарын 18-ны өдөр Аж ахуйн нэгж, байгууллагын газар эзэмших эрхийн 000299033 тоот гэрчилгээг олгосон байна.

Уур амьсгал: Монгол орон Ази тивийн төв хэсэгт дундад өргөгийн сэргүүн бүсэд орших ба эх газрын эрс тэс уур амьсгалтай. Тус аймгийн нутгийн ихэнх нь хээрийн бүсэд орших учир эх газрын эрс, тэс хуурайвтар уур амьсгалтай тал хээрийн шинж ноёрхсон байдаг. Далайн түвшнээс дээш 900.0-1500.0 м өндөр өргөгдсөн Их Хянганы нуруугаар зүүн, зүүн урд талаасаа судалгааны бүс нутаг нь хаагдаж хүрээлэгдсэн тул Номхон далайн чийглэг зөөлөн уур амьсгалын өвөрмөц онцлог байдал бараг нөлөөлөл үзүүлдэггүй. Иймд дэлхийн томоохон далай, тэнгисээс нэлээд хол зайд алслагдсан байдал, тухайн орчны гадаргын тогтцын өвөрмөц онцлог, газрын гадаргын өндөршилт, агаарын орчил хөдөлгөөний ерөнхий урсгал зэрэг байгалийн тодорхой хүчин зүйлсээс шууд шалтгаалан тухайн бүс нутагт зөвхөн Төв Азийн эх газрын эрс тэс уур амьсгал зонхилдог. Судалгааны бүс нутгийн хэмжээнд хоног ба жилийн доторх агаарын температурын хэлбэлзлийн маш их далайц, цаг агаарын огцом өөрчлөлт болон зарим жилүүдэд уур амьсгалын гол үзүүлэлтүүд олон жилийн дунджаас ихээхэн хэлбэлздэг байдал нэлээд түгээмэл ажиглагддаг. Хаврын улиралд агаарын урсгалын эсрэг орчил хөдөлгөөн задардаг учраас ихээхэн хүчтэй салхи, шороон шуурга байнга гардаг.

Агаарын чанар: Нийт 3 цэгээс агаарын дээж авч лабораторид шинжлүүлэхэд нийт тоосонцор (TSP) 4-135 мкг/м³, агууламжтай, хүхэрлэг хийн хэмжээ 1-9 мкг/м³, азотын давхар ислийн хэмжээ 11-50 мкг/м³ агууламжтай байна. АЧИ-ээр цэвэр ангилалд хамаарч байна.

Физик бохирдол: Дуу шуугианы хэмжилтийн үр дүнгээр 2 болон 5 цэгийн хэмжилтийн дундаж үзүүлэлт нь МҮ-ын агаарын чанарын стандарт MNS 4585:2016 өдрийн цагийн хэмжээнээс давсан бусад цэгийн дундаж үзүүлэлт стандартаас даваагүй байна. Цацрагийн хэмжилтийн дүнгээс харахад агаар 0.09-0.10 мкЗв/ц, хөрсөнд 0.10-0.12 мкЗв/ц байна.

Геологийн тогтоц ба геоморфологи: Бүс нутгийн хэмжээнд дээд юрагийн настай гүний шургамал чулуулгийн массив (J3), доод цэрдийн настай Цагаанцаывын давхаргадасны (K1cc) тунамал-бялхмал чулуулгийн зузаалаг болон дөрөвдөгчийн үеийн сэвсгэр хурдас (Q) зонхилон тархжээ. Төсөл хэрэгжих талбай нь Монгол орны Геоморфологийн мужлалаар Монголын Дорнодийн их мужийн Улз-Хэрлэнгийн дэд мужид хамаарана.

Гадаргын ус:

Тус аймгийн нутаг нь ус зүйн сүлжээний хувьд бүхэлдээ Номхон далайн ай савд, Монгол орны Хэрлэн голын сав газарт хамаарна. Судалгааны ажил явуулах бүс нутгийн дэвсгэр талбайн хэмжээнд хамгийн том гадаргын усан сүлжээ бол Монгол орны томоохон голуудын нэг болох Хэрлэн гол болно.

Газрын доорх ус: Хээрийн судалгааны ажлын хүрээнд үнсэн сангийн тунгаасан ус, ундны ус, технологийн ус гэсэн 3 цэгээс дээж авч, гэрэл зургаар баримтжуулан, бичиглэл хийсэн. Хээрийн судалгааны үед усны температур, цахилгаан дамжуулах чанар, нийт ууссан хатуу бодисын хэмжээг хэмжсэн. Лабораторийн шинжилгээний дүнгээр цайны газраас авсан дээж нь Химиин бүрэлдэхүүнээрээ Гидрокарбонатын анги, кальцийн бүлэг, I төрлийн цэнгэг буюу дунд зэргийн эрдээжилтэй, бага хатуулагтай ус байна. Үнсэн сангийн тунгаасан ус нь MNS 4943:2015 “Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага” стандартай харьцуулахад pH болон жинлэгдэгч бодисын үзүүлэлт давсан ба бусад үзүүлэлт даваагүй байна.

Хөрсөн бүрхэвч: Монгол орны хөрс – газарзүйн мужлалтаар Хангайн их мужийн Монголын Дорнод муж, хар хүрэн, хүрэн хөрсний дэд бүсийн Өндөрхаан-Түмэнцогтын тойрог, Хэнтийн мужийн Хэнтийн зүүн тойргуудад тус тус хамаарна.



Төслийн талбайд зүсэлт хийж дээж авсан цэгүүдийн хөрсний механик бүрэлдэхүүнийг тодорхойлоход голчлон элсэнцэр хөрс байв. Элсэнцэр хөрсний онцлог нь ялзмагийн хэмжээ бага, чийг багтаамж муу, усыг амархан доош нэвчүүлдэг, дулаан болон хүйтэн чанаараа амархан алдлаг, агших, тэлэх чадвар муу, бүтэцгүй. Ийм хөрс нь ХАА-д ашиг муутай, элэгдэл, эвдрэлд өртөмтгийг байна. Төслийн талбайн дийлэнх нь техникийн болон хүний ўл ажиллагаанаас нөлөөлөлд өртсөн байна.

Ургамлан номрог: Монгол орны ургамал – газарзүйн мужлалтаар Евроазийн шилмүүст ой, нуга хээрийн их мужийн, Дорнод Азийн мужийн Дэгээ-Нэмрэгийн тойрог, Евроазийн хээрийн их мужийн, Дорнод Азийн мужийн Улз-Хэрлэнгийн тойрог, Халх голын тойрог, Төв Азийн мужийн, Матад-Тамсагийн тойроогт тус тус хамаарна.

Ургамалжилтын судалгаагаар нийт 9 овог 17 төрөлд хамаарах 23 зүйл гуурст дээд ургамал бүртгэгдсэн. Ургамлын насны хувьд нэг наст ургамлууд 17%, олон наст ургамлууд 83%-ийг эзэлж байн. Амьдралын хэлбэрийн хувьд сөөгөнцөр ургамлууд 9%, олон наст өвслөг ургамлууд 91%-ийг эзэлж байна.

Бүртгэгдсэн нийт ургамлыг ургалтын хэлбэрээр нь ангилахад 5% улалж, 4% буурцагтан, 4% шарилж, 35% үетэн, 52% алаг өвс байна.

Хээрийн судалгааны явцад 3 цэгт ургамлан бичиглэл хийсэн бөгөөд ургамалжилтын нөхцөл тааруу, ургамлан бүрхэвч 30-60%, хагдан бүрхэвч 10-20%, халцгай газар 20-40%-ийг эзэлж байна.

Судалгааны талбай нь хүн болоод техникийн нөлөөгөөр ихээхэн эвдэрч доройтсон байна. Мөн ургамлын бүрхэц сийрэгдүү (30-40%), ургамлын зүйлүүдийн авви таруу (Sp); бэлчээрийн доройтлыг илэрхийлэгч ургамлуудаас Шүлхий шарилж (*Artemisia pectinata*) элбэг (Cop2) тархацтай буюу зонхицж; Ширэг улалж (*Carex duriuscula*) таруу аввитай (Sp) ургасан байна.

Амьтны аймаг: Хянганы ба Хэнтийн нурууны зах, хаяа нам уулын тайгархаг ой, уулын ойт хээр, хээр, голын хөндийн татамын нуга гэсэн байгалийн олон янз төрх байдал хосолсон энэ аймаг нь олон зүйлийн ан амьтан, загас, шувуудтай. Эрээний нуруу, Соёлз уул орчмоор-хандгай, буга, бор гөрөөс, зэрлэг гахай зэрэг Сибирийн ой тайгын амьтдын зүйлүүд, тал хээрт-цагаан зээр, үнэг, чоно, хярс, мануул, илбэнх, тарвага, олон зүйл мэрэгч, нуур усанд-олон зүйл загас, дэлхийн болон Монголын улаан номонд бичигдсэн олон зүйл ховор шувуудтай. Монгол орны шувууны-газарзүйн мужлалтаар Дорнод Монголын тэгш талын мужид, хөхтний-газарзүйн мужлалтаар Монгол-Түвдийн мужийн Монголын хээр ба ойт хээрийн дэд мужийн Хянганы тойроогт, Монгол Дагуурын тойроогт тус тус хамаарна.

Төслийн гол болон болзошгүй сорог ногоонд:

Газрын гадарагад үзүүлэх гол ба болзошгүй нөлөөлөл:

- ✓ Станцын өргөтгөл нь газар ашиглалтын хэмжээг 36.0 га-аар нэмэгдүүлэх, газрын нөөцийг багасгах
- ✓ Өргөтгөлийн ажилд ашиглагдах тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд зориулж шинээр зам засаж сайжруулсны улмаас газрын гадарга эвдрэлд өртөх
- ✓ Нүүрс буулгах, тээвэрлэх хэсэгт нүүрсний нарийн ширхэгт тоос тоосонцор салхинд хийсч орчны газрын гадаргыг бохирдуулах
- ✓ 36.0 га талбайн шимт хөрсийг хуулсанаар газрын гадарга эвдрэлд өртөх
- ✓ Цахилгаан станцад ашиглагдах химийн бодисын ашиглалтын явцад ажилчдын санамсар болгоомжгүй үйлдэл, үйлдвэрлэлийн ослын үед үүссэн алдагдал, асгаралт, дэлбэрэлтээс болж газрын гадарга, хэвлэй бохирдохя
- ✓ ЭБД шаталттай зуухнаас гарах дэгдэмхий үнс, шааргыг тээвэрлэх явцад алдагдал асгаралт үүсч, газрын гадарга хэвлэй бохирдуулах



- ✓ Цахилгаан станцын ашиглалтын үед ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын менежментэд доголдол үүссэн тохиолдолд хог хаягдал ил задгай хаягдаж, газрын гадаргыг бохирдуулах
- ✓ Барилгын ажил болон ашиглалтын үед ашиглах тээврийн хэрэгсэлд эвдрэл бий болсноос шатах тослох материал алдагдаж, газрын гадаргыг бохирдуулах

Агаарын чанарт үзүүлэх гол ба болзошгүй нөлөөлөл:

- ✓ Барилга байгууламжийг барих үйл ажиллагаатай холбоотой хөрс хуулалтаас үүсэх тоосжилт болон тээвэрлэлтийн үед үүсэх тоосжилт
- ✓ Төслийн хүрээнд ашиглагдах тээврийн хэрэгслүүдийг шатахуунаар цэнэглэх үед мөн мотор эд ангиас агаар бохирдуулах бодис уурших, тээврийн хэрэгслийн яндангаас агаар бохирдуулагч бодис ялгарах /нүүрстөрөгчийн исэл, хүхэрлэг хий, азотын исэл, нүүрстөрөгчийн давхар исэл, тортог /
- ✓ Төслийн барилга байгууламж барих болон үйл ажиллагааны үе шат мөн тээврийн хэрэгслээс үүсэх дуу шуугиан
- ✓ Нүүрсний шаталтаас үүсэх хийн хаягдал
- ✓ Үнсэн сангийн талбайгаас босох тоос
- ✓ Төслийн үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдалыг удаан хугацаанд буруу хадгалснаас тухайн хаягдлаас нүүрсхүчлийн хий агаарт хаягдах
- ✓ Хадгалалтын горим зөрчигдсөний улмаас химиин нэгдлүүд дулааны задралд орж хий байдалтай нэгдлүүд үүсэх

Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх гол болон болзошгүй нөлөөлөл:

- ✓ Өргөтгөл хийх талбайд барилга байгууламжийг барих үйл ажиллагаа болон тээвэрлэлтийн үед төслийн талбай болон ойр орчмын хөрсөн бүрхэвч талхлагдах, эвдрэх, олон салаа замууд үүсэх
- ✓ Өргөтгөл хийх 36 га талбайн шимт хөрс хуулагдах
- ✓ Төслийн үйл ажиллагааны явцад машин механизмаас мөн хүний санамсаргүй үйл ажиллагаанаас шалтгаалан ямар нэгэн шатах, тослох материал хөрсонд ил задгай асгарч хөрс бохирдуулах
- ✓ Хог хаягдлын менежментийг хангалтгүй хэрэгжүүлсэн тохиолдолд хатуу шингэн хог хаягдааар хөрс бохирдох
- ✓ Төслийн үйл ажиллагааны явцад салхи ихтэй үед нүүрсний агуулах болон үнс хадгалах байгууламжуудаас тоосонцор, нарийн дэгдэмхий үнс зөөгдөн газрын гадаргууд унаж хөрсөн дэх хүнд элементийн агууламжийн нэмэгдүүлэх

Ургамлан нөмрөгт үзүүлэх гол болон болзошгүй нөлөөлөл:

- ✓ Өргөтгөлийн талбайд барилга байгууламжуудыг барих үйл явцад түүний орчмын талбайн ургамлан нөмрөг талхлагдах, устах
- ✓ Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний улмаас олон салаа замууд үүсэж ургамлан нөмрөг талхлагдах
- ✓ Төслийн үйл ажиллагаанаас үүсэх хатуу, шингэн хог хаягдалын нөлөөгөөр ургамлан нөмрөг хордох, устах
- ✓ Үнсэн сангас үүсэх тоосжилтоос үүдэн ургамлан нөмрөгийн ургах орчин, физиологийн процессууд алдагдаж, доройтож болзошгүй юм.
- ✓ Хуурайшилт ихтэй үед ажилчдын анхаарал болгоомжгүй байдлаас хээрийн түймэр гарч болзошгүй.



Гадаргын болон газрын доорх усанд үзүүлэх гол болон болзошгүй нөлөөлөл:

- ✓ ДЦС-ыг өргөтгөснөөр цахилгаан, дулаан үйлдвэрлэл, ажиллах хүний тоо нэмэгдэн ашиглах усны хэмжээ ихсэж газрын доорх усны нөөцдөд нөлөөлнө.
- ✓ Хүрээлэн буй орчинд нийлүүлэх хаягдал ус нь MNS 4943:2015 стандартын шаардлага хангаагүй тохиолдолд Хэрлэн голын усны чанарт нөлөөлж болзошгүй.
- ✓ Өвлийн улиралд эргэлтийн усан сангийн уур ойролцоо газарт цан мөс үүсгэж, хаврын улиралд хайлан Хэрлэн гол руу урсдаг. Эргэлтийн усан сангийн ус нь MNS 4943:2015 стандартын шаардлагад нийцэгүй тохиолдолд Хэрлэн голын усны чанарт нөлөөлж болзошгүй.
- ✓ Шинээр барих үнсэн сангийн хаягдал ус нэвчиж газрын доорх усыг бохирдуулж болзошгүй.

Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх бууруулах арга хэмжээ:

Төслийн үйл ажиллагаанаас үүсэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, тэдгээрийг бууруулах болон арилгахад дараах зөвлөмж, арга хэмжээ, стандартын шаардлагыг мөрдлөг болгон ажиллах, цаг тухайд нь хэрэгжүүлэхийг төсөл хэрэгжүүлэгчид зөвлөж байна.

Газрын гадарга, хэвлэйд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ:

- ✓ Цахилгаан станцыг барьж байгуулахдаа төлөвлөгдсөн зураг төслийн дагуу барилгын ажлыг гүйцэтгэж, эвдэрсэн газруудын техникийн нөхөн сэргээлтийг хийх шаардлагатай. Нөхөн сэргээлт хийхдээ газрын гадаргад үүссэн овоолгуудыг тарааж тухайн газрын гадаргын хэлбэртэй дүйцүүлэх хэрэгтэй.
- ✓ Бүтээн байгуулалтаар хуулсан шимт хөрсний нөөцийг тусгайлан овоолж үнсэн санг хучиж ургамалжуулахад зориулж хадгалах бөгөөд шимт хөрсний овоолгын өндөр нь 5 м-ээс ихгүй байна.
- ✓ Барилгын ажлын үед олон салаа зам гаргахгүй байх тал дээр анхаарч ажиллах ба замын ашиглалт дууссаны дараагаар нөхөн сэргээлт хийж, тэмдэгжүүлэх шаардлагатай.
- ✓ Ашиглалтын үед засвар үйлчилгээ хийх засвар, үйлчилгээний ажлыг хийхдээ тогтсон нэг замаар зорчиж байх, хөдөлгөөнийг хязгаарлах
- ✓ Нүүрс тээвэрлэх, буулгах ажлыг салхины хурд багатай үед, эсвэл битүү орчинд буулгах, буулгах үед тоос дарах арга хэмжээ авах шаардлагатай.

Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ:

- ✓ Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүсэх тоосжилтын хэмжээг бууруулах зорилгоор хурдны хязгаар тогтоох, замын усалгаа чийгшүүлэлтийг хийх, шороон замыг дагтаршуулах, хайргаар хучих, тоос дарагч бодисоор шүрших зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх.
- ✓ Тээврийн хэрэгслийг сонгоходо шатахуун зарцуулалт багатай, ашигт үйлийн коэффициент өндөртэй техник хэрэгсэл сонгох.
- ✓ Нүүрс ачсан ачааны автомашинуудын тэвшийг хучиж, нүүрс салхинд хийсэж, алдагдахаас сэргийлэх,
- ✓ Нүүрс овоолох, нүүрс асгах явцад зохистойгоор шаардлагатай тохиолдолд ус шүршин тоосжилтыг багасгах замаар орчны агаарын чанарыг хамгаалах,
- ✓ Нүүрсний овоолгын тоосыг багасгахад усаар чийгшүүлэх нь ашиглалтын зардлыг ихэсгэдэг, мөн өвлийн улиралд боломжгүй тул хадгалах нүүрсний хэмжээг тээвэрлэлтийн тасралтгүй үйл ажиллагааны горим, нүүрс хадгалалтын хэмжээг оновчтой тогтоох,
- ✓ Нүүрсийг зориулалтын салхины хамгаалалттай хашаа бүхий талбайд буулгах, хадгалах, дамжуулах ба талбайн эргэн тойронд салхи тоосноос хамгаалах ургамал нөмрөг бий болгох



замаар салхины хурд хүчийг сааруулах, өнгөн хөрсний шороо, тоос хийсэхийг багасгах боломжтой эсэхийг судлах,

- ✓ Агаарын чанарын хяналтыг тогтмол графикийн дагуу хийж агаарын чанарын стандартын шаардлагыг хангаж ажиллах, заасан хүлцэх хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд хэтрэхэд нөлөөлсөн эх үүсвэрт тохирох арга хэмжээг авч ажиллах хэрэгтэй.

Усан орчинд үзүүлэх сорог нөлөөллийн урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ:

- ✓ Усыг ашиглах боломжит нөөцийн хүрээнд хэмнэлттэй, үр ашигтай, эргүүлэн ашиглах (Усны тухай хууль, 4.3)
- ✓ Ус ашиглауулах дүгнэлт, холбогдох зөвшөөрөлгүйгээр ус ашиглахгүй, цооног гаргахгүй байх (Усны тухай хууль, 28.18)
- ✓ Ус ашиглах зөвшөөрөлд заасан хэмжээнээс илүү ашиглахгүй байх (Усны тухай хууль, 30.1.1)
- ✓ Шинээр гаргах худгуудын мэдээллийг Дорнод аймгийн байгаль орчны албаны усны мэдээллийн санд бүртгүүлж, худгийн паспорт авах (Усны тухай хууль, 27.3)
- ✓ Шинээр гаргах худгуудын дэргэд усны түвшний ажиглалтыг пъезометрийн 2 цооногоор тогтмол хянах, хэмжилтийн үр дүнд анализ хийх

Хорсон бүрхэвчинд үзүүлэх сорог нөлөөллийн урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ:

- ✓ Барилга байгууламжуудыг барихаас өмнө эвдрэх талбайн үржил шимт хөрсийг “MNS 5916:2008 Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт” стандартын дагуу хуулан шимт хөрсний овоолгод байршуулах.
- ✓ Барилгын материал, тоног техөөрөмж, нүүрс тээвэрлэж буй тээврийн хэрэгслүүд төсөл хэрэгжүүлэгчээс зөвшөөрсөн авто замын маршрутаар зорчих, автозамын хэсгүүдийг засварлах
- ✓ Нүүрс буулгах талбайг хатуу хүчилттай болгон бетондох, засварлах
- ✓ Цахилгаан станц барих талбайн орчимд улирлаас хамааран салхины хурд, чиглэл өөр боловч ихэвчлэн баруун, баруун хойноос зонхилон салхилдаг. Иймд шимт хөрсний овоолгуудыг зонхилох салхины дагуу хэлбэршүүлэн 5 метр хүртэл өндөртэйгөөр байгуулна.
- ✓ Шимт хөрсний овоолгоог машин техникийн хөдөлгөөнд саад болохгүй, барилгын хог хаягдлаар бохирдоооргүй талбайг сонгон байршуулна.
- ✓ Шимт хөрсний овоолгын гадаргууг хэлбэржүүлэн усанд урсах, салхиар зөөгдөх эрсдэлийг бууруулна.

Эрсдэлийн үзлээ:

Төслийн эрсдлийн үнэлгээг гүйцэтгэхдээ Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд, Эрүүл мэндийн сайд, Онцгой байдлын ерөнхий байдлын газрын даргын 2012 оны A50/378/565 хамтарсан тушаалаар батлагдсан “Химийн хорт болон аюултай бодисын эрсдлийн үнэлгээ хийх аргачлал”, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн A/356/396 хамтарсан тушаалаар батлагдсан “Химийн хорт болон аюултай бодисын ангилаал батлах тухай” журмуудыг баримтлан химийн бодисын эрсдлийн үнэлгээг гүйцэтгэсэн.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, хяналт шинжилгээний хөтөлбөр:

Төслийн хүрээнд төсөл хэрэгжүүлэгчийн мөрдөн ажиллах байгаль орчны менежментийн төлөвлөгөөг “Байгаль орчинд нөлөөлех байдлын үнэлгээний тухай” Монгол Улсын хууль, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10-р сарын 29-ны өдрийн A/618 тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, Байгаль



орчин аялал жуулчлалын яамнаас гаргасан ерөнхий үнэлгээний дүгнэлтэд заасан шаардлагын дагуу боловсруулсан.

Нэгдсэн дүгнэлт, зөвлөмж:

Матрицын аргаар үнэлсэн дүнгээс авч үзэхэд нийт нөлөөлийн дүнгээс төслийн төлөвлөлт 25 буюу 19.8%, нүүрсний агуулах, тээвэрлэлт 25 буюу 19.8%, үнсэн сан 22 буюу 17.4 %, хатуу хог хаягдал 20 буюу 15.8% -ийг эзэлэж байна. Нөлөөллийн эрчмийн хувьд төслийн барилга байгууламж барих үйл явц болон нүүрс хадгалах талбай, үсэн сангаас үүсэх нөлөөлөл илүү эрчимтэй нөлөөлөхеөр байна.

Байгалийн бүрэлдэхүүн хэсэг болох хөрсөн бүрхэвчинд 15%, агаарын чанарт 17.5%, ургамлан нөмрөгт 15%, хүний эрүүл мэндэд 15% сөрөг нөлөөлөл үзүүлэхээр байна.

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн ДЦС төслийн БОННҮ-ний тайлангийн ажлын хүрээнд хийгдсэн судалгаа, шинжилгээний ажлын үр дүнд тулгууралсан дараах зөвлөмжүүдийг үйл ажиллагаанд тусган ажиллах шаардлагатай. Үүнд:

- ✓ Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. эрүүл ахуй. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага, Хөдөлмөрийн хамгаалах хэрэгсэлд тавих ерөнхий шаардлага, Хамгаалалтын хувцас ерөнхий шаардлага, Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Ажлын байрны гэрэлтүүлгийн норм, хэмжих аргад тавигдах ерөнхий шаардлага гэх мэт хөдөлмөр хамгааллын хууль, дүрэм журам, стандартуудыг баримталж ажиллах хэрэгтэй.
- ✓ БОННҮ-ний ажилд тусгагдсан байгаль орчныг хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах, болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр өгөгдсөн заавар зөвлөмжийг мөрдөн ажиллах
- ✓ Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан байгаль орчныг хамгаалах чиглэлээр гүйцэтгэх ажлуудад шаардагдах хөрөнгө зардлыг жил бүрийн санхүүгийн төлөвлөгөөнд тусган зарцуулалтад хяналт тавих
- ✓ Хөрс, ус, агаарын мониторингийг орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт байнга тусган шинжилгээг тогтмол явуулснаар урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүсэж болох эрсдэлийг бууруулах бүрэн боломжтой.
- ✓ Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10¹-т заасны дагуу Байгаль орчны төлөвлөгөөт аудитыг 2 жил тутамд хийлгэж байх хэрэгтэй.
- ✓ Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх журамын дагуу Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг 5 жил тутамд хийлгэж байх хэрэгтэй.
- ✓ Цахилгааны зарцуулалт хамгийн багатай тоног төхөөрөмжүүдийг сонгож ашиглах, хөдөлгөөн мэдэрч асдаг гэрэлтүүлэг, лед гэрэл болон нарны толин гэрэлтүүлгийг боломжит хэсгүүдэд суурилуулж ашиглах, мөн нарны эрчим хүчийг ашиглах бусад боломжуудыг судлах
- ✓ Хог хаягдал ил задгай шатаахгүй байх, хориглосон, анхааруулсан самбар, хаяг хийж зохих газруудад байршуулах
- ✓ Ахуйн гаралтай хатуу хог хаягдлыг зориулалтын сав, цэгт хадгалах, зохих цэвэрлэгээ, халдвартгүйжүүлэлт хийх, барилгын гаралтай хог хаягдлыг орон нутгийн ЗДТГ-тай гэрээ байгуулан зайлуулах.
- ✓ Хог хаягдлыг ангилан ялгаж, дахин ашиглах буюу дахин ашигладаг хувь хүн, албан байгууллагуудад нийлүүлэх
- ✓ Төслийн барилга байгууламж, зам талбайг тогтоосон зураг төслийн дагуу барьж байгуулах, тээврийн хэрэгслийн тогтоосон замаар явуулах
- ✓ Авто тээврийн хэрэгсэл болон явган хүний зориулалтын зорчих зам, зогсоол байгуулах, олон салаа зам гаргахаас сэргийлэх, анхааруулсан тэмдэг, тэмдэглэгээ байршуулах



- ✓ Шугам хоолойг байнга шалгаж байх, эвдэрч гэмтсэн тохиолдолд нэн даруй засах арга хэмжээ авах
- ✓ Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн хуулийн хугацаа нь 5 жил /2023-2027/ бөгөөд цаашид хүчин чадал нэмэгдэх, технологи шинэчлэгдэх нөхцөлд уг тайланд дахин нэмэлт тодотголын ажил хийлгэх шаардлагатай.
- ✓ Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журмыг баримталж ажиллах

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланда тусгасан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зөвлөмж, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу ажиллавал тус төслийг хэрэгжүүлэх боломжтой гэж үзэж байна.



ОРШИЛ

Дорнод аймгийн Хэрлэн сумын нутагт хэрэгжих Дулааны цахилгаан станц төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг “Дорнод бүсийн эрчим хүчиний систем” ТӨХК-тай байгуулсан гэрээний дагуу “Эко Ти Эс Би” ХХК-д боловсруулав. Төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний ажлыг Монгол улсын Байгаль орчин аялал жуулчлалын яамнаас гаргасан Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний дүгнэлтэд заасан чиглэл хуваарийн дагуу хийж гүйцэтгэв.

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний гол зорилго:

БОННҮ-ний гол зорилго нь байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний дүгнэлтэд заасан чиглэл, хуваарийн дагуу төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, нийгэм, эдийн засагт үзүүлэх зерэг болон серөг нөлөөллийг тодорхойлох, хүний эрүүл мэнд, байгаль орчин, эдийн засгийн үр ашигт учруулах эрсдэлийг тодорхойлох, серөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг тодорхойлоход оршино.

Нарийвчилсан үнэлгээний хүрээнд гүйцэтгэгдсэн ажлууд:

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг тодорхойлж, үнэлгээ өгөх, оновчтой хувилбаруудыг боловсруулах, сөрөг нөлөөллийг бууруулах зохистой арга хэмжээ, түүний менежментийг төлөвлөх, мониторингийн үзүүлэлтийг тодорхойлох, тайлан боловсруулах, тайланг тухайн орон нутгийн иргэдийн нийтийн хуралаар хэлэлцүүлэх зэрэг дарааллын дагуу энхүү байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний ажлыг гүйцэтгэсэн болно.

Мөн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний явцад, төслийн техник технологийн шийдэл, хүчин чадал, онцлог, нөгөө талаас байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд, хүний эрүүл мэнд, нийгэм-эдийн засаг, хууль эрх зүйн асуудлыг хамарсан бөгөөд эдгээрийг цогц байдлаар нэгтгэн үзэж, дүн шинжилгээ хийсний үндсэн дээр байгаль орчин болон хүний эрүүл мэндэд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг илрүүлэн тодорхойлов.

Төсөл хэрэгжүүлэгч, орон нутаг болон шийдвэр гаргах түвшинд анхаарах асуудал:

- Газрын тухай хууль болон газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх журмын дагуу газрын төлөв байдал чанарын хянан баталгаа мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх,
- Төсөл хэрэгжүүлэгч жил бүрийн 11 дугаар сарын 1-ны дотор тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтийн тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, дараа оны БОМТ-ний төсөлтэй хамтатган ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагад ирүүлэх.
- Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд тусгагдсан сөрөг нөлөөллийг урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ мөн дүйцүүлэн хамгаалах, нөхөн сэргээлт, байгаль орчны мониторингийн ажлуудыг тайланд тусгагдсаны дагуу заавал гүйцэтгэх,
- Монгол Улсын “Байгаль орчин хамгаалах тухай” хуулийн 10^1 -р зүйлийн дагуу БОННҮ батлагдсан хугацаанаас хойш 2 жил тутамд байгаль орчны аудитыг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, үл нийцлийн хэрэгжилтийн тайланг орон нутгийн байгаль орчны газарт хүргүүлэх шаардлагатай.



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭ

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн Дулааны цахилгаан станц төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг дор дурьдсан хууль эрхзүйн баримт бичгүүдийг хэрэглэсэн бөгөөд эдгээр нь зөвхөн нарийвчилсан үнэлгээ хийх явцад ашиглаад зогсохгүй тус төслийн цаашдын үйл ажиллагааны өдөр тутмын хэрэгцээний тулгуур баримт бичгүүд болно.

Хүснэгт I Хууль

№	Хуулийн нэр	Батлагдсан огноо
1	Монгол улсын үндсэн хууль	1992-01-13
2	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль	2012-05-17
Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 2 дахь заалтыг хэрэгжүүлэх, байгаль орчныг хамгаалах, хүний үйл ажиллагааны улмаас байгаль орчны тэнцвэрт байдал алдагдахаас сэргийлэх, байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатайгаар байгалийн нөөц ашиглалт явуулах, бус нутаг, салбарын хэмжээнд баримтлах бодлого, хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөө болон аливаа төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлыг үнэлэх, хэрэгжүүлэх эсэх талаар дүгнэлт, шийдвэр гаргах, оролцогч талуудын харилцааг зохицуулахад оршино.		
3	Байгаль орчныг хамгаалах тухай хууль	1995-03-30
Энэ хуулийн зорилт нь хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, нийгэм, эдийн засгийн хөгжлийг байгаль орчны тэнцэлтэй уялдуулах, өнөө болон ирээдүйн үеийнхний ашиг сонирхлын үүднээс байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, жам ёсны боломжтойг нь нөхөн сэргээхтэй холбогдож төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.		
4	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль	2012-05-17
Энэ хуулийн зорилт нь хөрсийг доройтлоос хамгаалах, нөхөн сэргээх, цөлжилтөөс сэргийлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.		
5	Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль	2010-06-24
Энэ хуулийн зорилт нь агаар бохирдуулагч этгээдэд агаарын бохирдлын төлбөр ногдуулах, төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.		
6	Агаарын тухай хууль /Шинэчилсэн найруулга/	2012-05-17
Энэ хуулийн зорилт нь хүрээлэн байгаа агаарыг хамгаалах, бохирдооос урьдчилан сэргийлэх, агаар бохирдуулах бодисын хаягдлыг бууруулж хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.		
7	Усны тухай хууль /Шинэчилсэн найруулга/	2012-05-17
Энэ хуулийн зорилт нь усны неөц, түүний сав газрыг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршин		
8	Газрын тухай хууль /Шинэчилсэн найруулга/	2002-06-07
Энэ хуулийн зорилт нь газрыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх, ашиглуулах болон түүнтэй холбогдсон бусад харилцааг зохицуулахад оршино.		
9	Газрын хэвллийн тухай хууль	1988-11-29
Газрын хэвллийн тухай Монгол Улсын хуулийн зорилт нь өнөөгийн болон хойч үеийнхний ашиг сонирхолд нийцүүлэн газрын хэвллийг ашиглах, хамгаалахтай холбогдсон нийгмийн харилцааг зохицуулахад оршино.		
10	Газрын төлбөрийн тухай хууль	1997-04-24
Энэ хуулийн зорилт нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад төрийн өмчийн газрыг эзэмшиж, ашигласны төлөө төлбөр ногдуулах, уг төлбөрийг төсөвт төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.		
11	Ургамал хамгаалах тухай хууль	2007-11-15



Энэ хуулийн зорилт нь бэлчээрийн болон таримал ургамлыг ургамлын өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамлаас хамгаалах, түүнтэй тэмцэх, хорио цээр тогтоох, хяналт тавих үйл ажиллагаатай холбогдон төр, иргэн, хуулийн этгээдийн хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.		
12	Амьтны тухай хууль	2012-05-17
	Энэ хуулийн зорилт нь амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх, түүний нөөцийг зохистой ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.	
13	Химиин хорт болон аюултай бодисын тухай хууль	2006-05-25
	Энэ хуулийн зорилт нь химиин хорт болон аюултай бодисыг экспортлох, импортлох, Монгол Улсын хилээр дамжуулан тээвэрлэх болон үйлдвэрлэх, хадгалах, худалдах, тээвэрлэх, ашиглах, устгах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.	
14	Хог хаягдлын тухай хууль	2017-05-12
	Энэ хуулийн зорилт нь хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх серөг нөлөөллийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх, хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулж, байгалийн нөөц баялгийг хэмнэх, иргэдийн хог хаягдлын талаархи боловсролыг дээшлүүлэх зорилгоор хог хаягдлыг бууруулах, ангилах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, экспортлох болон аюултай хог хаягдлыг импортлох, хил дамжуулан тээвэрлэхийг хориглохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.	
15	Эрчим хүчиний тухай хууль	2001-02-01
	Энэ хуулийн зорилт нь эрчим хүчиний нөөцийг ашиглан эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, диспетчерийн зохицуулалт хийх, хангах үйл ажиллагаа эрхлэх, эрчим хүчиний барилга байгууламж барих болон эрчим хүчийг хэрэглэхтэй холбогdon үүссэн харилцааг зохицуулахад оршино.	
16	Эрүүл мэндийн тухай хууль	2011-05-05
	Энэ хуулийн зорилт нь эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого, үндсэн зарчмыг тодорхойлж, иргэний эрүүл мэндээ хамгаалуулах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах эрхийг хангахад аж ахуйн нэгж байгууллага, албан тушаалтан, иргэний гүйцэтгэх үүрэг, эрүүл мэндийн байгууллага, ажилтын үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.	
17	Эрүүл ахуйн тухай хууль	2016-02-04
	Энэ хуулийн зорилт нь хүний эрүүл, аюулгүй амьдрах таатай орчин, нехцэлийг бүрдүүлэх, хүрээлэн байгаа орчны хүний эрүүл мэндэд үзүүлэх серөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах, арилгахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.	
18	Хүнсний бүтээгдхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль	2012-12-20
	Энэ хуулийн зорилт нь хүнсний судлээний бүх үе шатанд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.	
19	Галын аюулгүй байдлын тухай хууль	2015-07-02
	Энэ хуулийн зорилт нь галын аюулгүй байдлыг хангах, галын аюулгүй байдлын хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагын эрх зүйн үндсийг тогтоох, галын аюулгүй байдлыг хангах талаархи нутгийн захиргааны болон аж ахуйн нэгж, байгууллага, иргэний эрх, үүрэг, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.	
20	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль	2008-05-22
	Энэ хуулийн зорилт нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаархи төрийн бодлого, үндсэн зарчмыг тодорхойлж, төрийн байгууллагын удирдлага, хяналтын тогтолцоо, ажлын байранд тавигдах хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандартыг хангах, ажилтан, хөдөлмөр эрхлэгч иргэнийг эрүүл, аюулгүй орчинд ажиллах нехцэлийг бүрдүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.	
21	Авто замын тухай хууль	2017-05-11
	Энэ хуулийн зорилт нь авто замыг төлөвлөх, барих, санхүүжүүлэх, эзэмших, ашиглахтай холбоотой байгууллага, иргэний хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.	
22	Автотээврийн тухай хууль	1999-06-04



Энэ хуулийн зорилт нь автотээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэх үйл ажиллагаа болон автотээврийн хэрэгсэлд тавигдах нөхцөл, шаардлагыг тодорхойлох, автотээвэрлэлт болон автотээврийн хэрэгслийг ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

23 Гамшгаас хамгаалах тухай хууль

2017-02-02

Энэ хуулийн зорилт нь гамшгаас хамгаалах үйл ажиллагааг шуурхай, үр дүнтэй зохион байгуулах, онцгой байдлын байгууллага болон гамшгаас хамгаалах удирдлагын тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Төслийн үйл ажиллагаатай холбоотой хууль эрхэзүйн хязгаарлалтууд:

Байгаль орчныг хамгаалах тухай хууль:

Энэ хуулийн зорилт нь хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, нийгэм, эдийн засгийн хөгжлийг байгаль орчны тэнцэлтэй уялдуулах, өнөө болон ирээдүйн үеийнхний ашиг сонирхлын үүднээс байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, жам ёсны боломжтойг нь нөхөн сэргээхтэй холбогдож төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

7.1 Байгаль орчны унаган төрхийг хадгалах, түүний тэнцэл алдагдахаас сэргийлэх арга хэмжээ боловсруулж хэрэгжүүлэх, байгалийн баялгийн ашиглалтыг зохицуулах зорилгоор байгалийн баялгийн нөөцийн үнэлгээ болон байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг тус тус хийнэ.

10.1 Байгаль орчны аудитыг байгалийн нөөц, баялгийг ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллага нь хоёр жилийн хийгээж, холбогдох дүгнэлт, зөвлөмж гаргуулан хэрэгжүүлэх бөгөөд зөвлөмжид заасан хугацаанд тайлангаа аймаг, нийслэлийн байгаль орчны албанад хургуулна.

31.3 Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх явцад байгаль орчинд гаргаж байгаа хорт бодис, физикийн хортой нөлөөлөл, хог хаягдлын хэмжээг бүртгэж, тэдгээрийг багасгах, цэвэрлэх талаар авсан арга хэмжээ, хянах тохооромжийн ажиллагааны тухай тайлан мэдээг хугацаанд нь гаргаж холбогдох байгууллагад огог;

31.4 Байгаль орчинд сорог нөлөөлөл бүхий үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагааныхаа сөрөг нөлөөллийг бууруулах, зогсоо болон байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг жилийн бүр төсөөтөө тусган хэрэгжүүлэх;

Агаарын тухай хууль:

Энэ хуулийн зорилт нь хүрээлэн байгаа агаарыг хамгаалах, бохирдооос урьдчилан сэргийлэх, агаар бохирдуулах бодисын хаягдлыг бууруулж хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

9.1.2. Агаар хамгаалахтай холбогдсон дүрэм, журам, бохирдуулах бодисын хаягдлын стандарт, хэм хэмжээний шаардлагыг хангах;

9.1.3. Агаарын бохирдолын томоохон суурин эх үүсвэр ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхтэхдээ тухайн эх үүсвэрийн хаягдал, нөлөөллийг хянах дотоод хяналтын багаж хэрэгслээр тоноглох;

9.1.4. Аж ахуйн нэгж, байгууллага нь байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд тусгасан орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийн дагуу дотоод хяналтыг явуулах;

9.1.5. Аж ахуйн нэгж, байгууллага нь агаарын бохирдолын эх үүсвэрийн дотоод хяналтын болон холбогдох бусад тайлан, мэдээг энэ хуулийн 12.5-д заасан журмын дагуу мэргэжлийн албаны орон нутаг дахь салбарыг гаргаж огог;

20.6. Зориулалтын бус газарт хог хаягдал хаях, ил задгай шатаах болон хог хаягдал устгах стандартын шаардлага хангагүй аливаа үйл ажиллагааг хориглоно.



Агаарын бохирдлын толборийн тухай хууль:

Энэ хуулийн зорилт нь агаар бохирдуулагч этгээдэд агаарын бохирдлын төлбөр ногдуулах, төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

- 4.1.4. Автомээврийн болон өөрөө явагч хэрэгсэл эзэмшигч;
- 4.1.6. Агаарт бохирдол гаргах эх үүсвэр хэрэглэж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага.
- 5.6. Агаарын бохирдлын нохон толбөрийг холбогдох аж ахуйн нэгж, байгууллага, иргэн Байгаль орчин, уур амьсгалын санд төлнө.
- 9.3. Төлбөр төлөгч нь автомээврийн болон өөрөө явагч хэрэгсэлд ногдох жилийн толбөрийг жилд нэг удаа тухайн жилийн 6 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө харьяалах татварын албанад төлөх бөгөөд автомээврийн болон өөрөө явагч хэрэгслийн техникийн үзлэгийн гэрчилгээ нь агаарын бохирдлын толбөр толсөн тухай тэмдэглэлтэй байна.

Байгалийн нөөц ашигласны толборийн тухай хууль:

Энэ хуулийн зорилт нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад байгалийн нөөц ашигласны төлбөрийг ногдуулах, түүнийг төсөвт төвлөрүүлэх, тайлагнах, байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нохон сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь, хэмжээг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

- 6.1.1. Хүн амын унд, ахуйн болон үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан ус;
- 10.1.2. Хүн амын унд, ахуйн болон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйлдвэрлэл, үйлчилгээ, аж ахуйн зориулалтаар ашигласан усыг шоо метрээр;
- 15.1. Усны нөөц ашигласны толборийн хувь, хэмжээг энэ хуулийн 10.1-д заасан толбор тооцох узүүлэлтийн нэгжид дараах хязгаарт багтаан тогтооно:

Толбөр ногдох ус	Толбөрийн хязгаар / экологи-эдийн засгийн үнэлгээний хувиар/			
	Гадаргын усанд		Газрын доорх усанд	
	доод	дээд	доод	дээд
1.Хүн амын унд, ахуйн зориулалтаар ашигласан усны шоометр тутамд	1	10	5	20
5.Хөнгөн үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан усны шоометр тутамд	10	30	10	40
6.Хүнсний үйлдвэрлэлд ашигласан усны шоометр тутамд: a/ Архи, пиво, согтууруулах ундаа	10	40	20	40
b/ Ундаа, цэвэр ус	10	30	10	20
c/ Талх, чихэр, нарийн боов, бусад	1	10	1	20
10.Ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага, иргэний ашигласан усны шоометр тутамд	10	30	15	50

Байгаль орчинд нэлэвлих байдлын үнэлгээний тухай хууль:

Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 2 дахь заалтыг хэрэгжүүлэх, байгаль орчныг хамгаалах, хүний үйл ажиллагааны улмаас байгаль орчны тэнцвэрт байдал алдагдахаас сэргийлэх, байгаль орчинд сөрөг нелөөлөл багатайгаар байгалийн нөөц ашиглалт явуулах, бүс нутаг, салбарын хэмжээнд баримтлах бодлого, хэрэгжүүлэх хөгжлийн



хөтөлбер, төлөвлөгөө болон аливаа төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлыг үнэлэх, хэрэгжүүлэх эсэх талаар дүгнэлт, шийдвэр гаргах, оролцогч талуудын харилцааг зохицуулахад оршино.

7.2 Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээг байгалийн нөөцийг ашиглах, газрын тос болон ашигт малтмал хайх, ашиглах, аж ахуйн зориулалтаар газар эзэмших, ашиглах эрх авах болон төсөл хэрэгжүүлэхээс омнө хийнэ.

7.3. Төсөл хэрэгжүүлэгч нь холбогдох эрх бүхий байгууллагаар баталгаажсан техник-эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчны өнөөгийн төлөв байдлын тодорхойлолт, тухайн сум, дүүргийн Засаг даргын санал болон холбогдох бусад баримт бичгийг бүрдүүлэн энэ хуулийн хавсралтад заасан ангилын дагуу байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл байгаль орчны албан дайчдаг байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийлгэнэ.

7.4. Шинээр байгуулах болон одоо ажшилаж байгаа үйлдвэр, үйлчилгээ, барилга байгууламж, тэдгээрийг шинэчлэх, өргөтгөх, байгалийн нөөц ашиглах төсөлд байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээг үнэлгээний шинжээч ажлын 14 хоногт багтаан хийж дараах дүгнэлт гаргана

8.2. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг энэ хуулийн 12 дугаар зүйлд заасны дагуу эрх авсан дотоодын аж ахуйн нэгж гүйцэтгэнэ.

8.3. Энэ хуулийн 8.2-т заасан эрх бүхий аж ахуйн нэгж нь байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүнгээр тайлан бэлтгэж, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулна.

8.4.8. Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэдийн нийтийн хурлын санал, тэмдэглэл;

10.5. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг төсөл хэрэгжүүлэгч, үнэлгээ хийсэн мэргэжлийн байгууллага хамтран төслийн нөлөөлөлд өртөх орон нутгийн оршин суугчадад танилцуулах ажлыг зохион байгуулна.

9.8. Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага төсөл хэрэгжүүлэгчийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжсилтийн тайланг жил бүрийн 12 дугаар сард багтаан хүлээн авч дараа оны толовлогөө болон түүнийг хэрэгжүүлэхэд шаардлагдах хөрөнгө, зардлын хэмжээг батална.

14.1.2. Байгаль орчны менежментийн толовлогөөний биеэлэлтийг нутгийн оршин суугчид, орон нутгийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөгч талууд холбогдох төрийн захиргааны төв байгууллагад тогтоосон хугацаанд мэдээлж, тайлагнах;

Газрын тухай хууль:

Энэ хуулийн зорилт нь газрыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх, ашигуулах болон түүнтэй холбогдсон бусад харилцааг зохицуулахад оршино.

7.1. Газар эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага Газрын төлбөрийн тухай хуулийн дагуу газрын төлбөр төлнө.

50.1.1. Газрын төлов байдал, чанарыг хадгалах, байгалийн аясаар болон хүний үйл ажиллагааны улмаас хөрсний үргжил шим буурах, газрын ургамлын бүрхэвч талхлагдах, хорс элэгдэх, эвдрэх, хуурайших, намагжих, давсжих, бохирдох, хордохоос сэргийтэх арга хэмжээг өөрийн зардлаар хариуцах;

58.7. Газар эзэмшигч, ашиглагч нь газрынхаа төлов байдал, чанарын улсын хянан баталгааг өөрийн хөрөнгөөр, аих удаа иргэн аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшиг, ашиглалтад



олгож байгаа болон бусад газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг улсын буюу орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.

58.5. Газрын нэгдмэл сангийн бүх ангилын газрыг 5 жилд нэг удаа газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаанд заавал хамруулах бөгөөд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газар эзэмших, ашиглах эрх дуусгавар болоход энэхүү баталгааг гаргана.

Газрын төлбөрийн тухай хууль:

Энэ хуулийн зорилт нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад төрийн өмчийн газрыг эзэмшиж, ашигласны төлөө төлбөр ногдуулах, уг төлбөрийг төсөвт төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

9.2. Газрын төлбөрийн асуудал эрхэлсэн байгууллага /албан тушаалтан/ энэ хуулийн 4 дүгээр зүйлд заасан газрын жилийн төлбөрийг ногдуулж тухайн оны 02 дугаар сарын 10-ны дотор татварын албанад хүргүүлнэ.

Усны тухай хууль:

Энэ хуулийн зорилт нь усны нөөц, түүний сав газрыг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

22.2 Усны нөөц, чанарыг хамгаалахын тулд ус ашиглагч нь экологийн тэнцлийг хангахад шаардагдах хэмжээний нөөцийг байгальд заавал улдээх уурэг хүлээхийн зэрэгцээ усны эх, ундарга, усны сан бүхий газрын эргээс 50 метрээс доошгүй зайд болон гол мөрний татамд онцгой хамгаалалтын бус тогтооно.

22.1.2 Тэсэлгээ хийх, газар тариалан эрхлэх, ашигт малтмал хайх, олборлох, зэгс, шагшуурга, мод огтлох, элс, хайрга, чулуу авах, байгалийн ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар түүж бэлтгэх, мал угаах болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэх цэг байгуулахыг хориглоно.

22.3 Мөн Усны сан бүхий газрын эргээс 200 метрээс доошгүй зайд энгийн хамгаалалтын бус, ус хангамжийн эх үүсвэрээс 100 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн бус тогтооно.

3.1.32 “Ус бохирдуулсны төлбөр” гэж хаягдал усны стандартад нийцсэн агууламж бүхий ус зайтуулсан, хаясан тохиолдолд төлбөрийг

3.1.33 “Ус бохирдуулсаны нөхөн төлбөр” гэж хаягдал усны стандарттаас хэтэрсэн агууламж бүхий ус зайтуулсан, хаясан тохиолдолд толох төлбөрийг





ААНБ УС АШИГЛАХ ЗӨВШӨӨРӨЛ АВАХ ДЭС
ДАРААЛАЛ



Ус бохирдуулсаны төлбөрийн тухай хууль:

Энэ хуулийн зорилт нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад ус бохирдуулсны төлбөр ногдуулах, төлбөрийг төсөвт төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

4.1. Ус, рашааны нөөцийг ашиглан хаягдал ус гаргаж, усны найрлага, чанарт нөлөөлж байгаа ус бохирдуулагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага ус бохирдуулсны төлбөр төлөгч байна.

7.1. Төлбөрийн хэмжээг хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээнд үндэслэн дараах хязгаарт багтаан Засгийн газар тогтооно:

Бохирдуулах бодис	Хэмжих нэгж	Төлбөрийн хязгаар /төгрөгөөр/	
		доод	дээд
Жинлэгдэх бодис	килограмм	50	1000
Органик бодис	килограмм	50	1000
Эрдэс бодис	килограмм	20	400
Хүнд металл	килограмм	500	10000
Аюултай бохирдуулах бодис	грамм	1000	10000

9.1. Төлбөр төлөгч нь тухайн улираад байгаль орчинд шууд хаясан болон ариутгах татуургын байгууламжид нийлүүлсэн хаягдал усан дахь бохирдуулах бодист ногдох төлбөрийг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор харьяалах татварын албанад төлино.



**Сум, дүүргийн Засаг дарга нь нутаг
дэвсгэртээс хаядал ус зайлцуулах црг
тогтоон.**

Ус бохирдуулагчийг ус бохирдуулсын
төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх
жагсаалтыг гаргана.

Ус бохирдуулагчийн хаядал ус хаях,
зайлцуулах зөвшөөрлийг цуцална.

Ус ашиглуулагчийн, болон ус бохирдуулагчийн
эрх, үүрэг

Ус бохирдуулагч нь Сав газрын захиргааныаас
мэргжлийн, арга зүйн зөвлөгөө авах, хаядал ус хаях,
зайлцуулах црг тогтооюлох, ногдуулсан ус
бохирдуулсны төлбөр-болов нөхөн төлбөрийн
хэмжээг үндэслэлээгүй гэж үзэг дээд шатны
байгууллагад томдол гаргах эрхтэй,

Ус бохирдуулагч нь үйл ажиллагаанд
энэхүү гэрээ болон холбогдох хууль,
тогтоомж, дүрэм, журам, стандарт, норм
норматив, ТЭЗҮ, зураг төсөл, байгаль
орчны менежментийн төлөвлөгөөг мөрдеж
ажиллана.

Ус бохирдуулагч нь хаядал усны
эзлэхүүнийг тодорхойлох хэмжих хэрэгсэл
(тоолуур)-ийг "Ус ашиглалт, хэрэглээг
тоолууржуулах журам"-д заасны дагуу
суурилнуулна.

УС БОХИРДУУЛСНЫ НӨХӨН ТӨЛБӨРИЙГ ШАТЛАН ӨСГӨХ ХЭЛБЭРЭЭР НОГДУУЛАХ ЖУРАМ

Бохирдуулах бодисын хэмжээ	Нөхөн төлбөр
3DX≤2	Ус бохирдуулсны төлбөрийг 2 дахин нэмж тооцно
2<3DX≤5	Ус бохирдуулсны төлбөрийг 3 дахин нэмж тооцно
3DX>5	Ус бохирдуулсны төлбөрийг 5 дахин нэмж тооцно

Стандартын шаардлагад нийцуулсан
тохиолдод ус бохирдуулсны төлбөр, эс
тохиолдод нөхөн төлбөрийг бохирдуулах
бодисын хэмжээнийн дунг эхийн
шатлан өсгөх халбэрээр тооцож төлнө;

1. ДҮТНЭЛТ ГАРГУУЛАХ

5. ТӨЛБӨР, НӨХӨН ТӨЛБӨР ТӨЛНӨ

4 ХАЯГДАЛ УСНЫ ШИНЖИЛГЭЭ ХИЙЛГЭНЭ

УС БОХИРДУУЛАГЧ

- Хоногт 50 шоометрээс их, зуултай бохирдуулах
бодис агуулсан бол БОАЖЯ дүгнэлт гаргана.
- Хоногт 50 шоометрээс бага бол СГЗ дүгнэлт
гаргана.

2. ХАЯГДАЛ УС ХАЯХ ЗАЙЛЦУУЛАХ ЗӨВШӨӨРӨЛ АВНА

- Хаядал ус хаях, зайлцуулах
зөвшөөрлийг БОАЖЯ-ны
дүгнэлтийг үндэслэн СГЗ,
- СГЗ-ны дүгнэлтийг үндэслэн
сум, дүүргийн Засаг дарга
олгоно. 1 жилээр

3. ТӨЛБӨРИЙН ГЭРЭЗ БАЙГУУЛНА

- Хаядал ус, хаях зайлцуулах
зөвшөөрлийг хүн, хуулийн
этгээдтэй СГЗ, Сум дүүргийн
Засаг дарга төлбөрийн гэрээ
байгуулна.
- байгальд шудаа нийлүүлж
байгаа тохиолдод MNS
4943:2015

Итгэмжлэгдээн
лабораториор хийлгээн
шинжилгээний дунг эхийн
улирал тутамд Сав газрын
захиргаанд хургуулна



Хог хаягдлын тухай хууль:

Төсөл хэрэгжүүлэгч нь энэ хуулийн дагуу хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх хортой нөлөөллийг арилгах, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор хог хаягдлыг бууруулах, ангилах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах, эргүүлэн ашиглах, устгах, экспортлох болон хог хаягдлыг импортлох, хил дамжуулан тээвэрлэхийг хориглохтой холбогдсон харилцааг дагаж мөрдөнө.

- 10.2.1. Энэ хуулийн 9.1.3-т заасан журмын дагуу энгийн хог хаягдлаа ангилан ялах;
- 10.2.2. Энэ хуулийн 15 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан хогийн савтай байх;
- 10.2.3. Аж ахуйн нэгж, байгууллага нь хог хаягдал цуглуулах, тээвэрлэх эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай хог тээврийн үйлчилгээний гэрээ байгуулах;
- 10.2.4. Хог хаягдлаа зориулалтын хогийн сав болон цэгт хаях эсхүл хог хаягдал цуглуулж тээвэрлэх эрх бүхий байгууллагад шилжүүлэх;
- 10.2.5. Үүссэн аюултай хог хаягдлаа эрх бүхий байгууллагад, эсхүл тогтоосон тусгай цэгт хүлээлгэн өгөх;
- 10.2.6. Нийтийг хамарсан цэвэрлэгээ, иргэдийн бүлгээс зохион байгуулсан үйл ажиллагаанд оролцох;
- 10.2.7. Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг тогтоосон хугацаанд төлөх;
- 10.2.8. Хог хаягдлыг бууруулах, ангилах, дахин ашиглах, зүй зохистой хаях дадал зуршилыг хэвшүүлэх;
- 10.2.9. Эзэмшилийн барилга, байгууламжийн гадна хана, хашаа, хайсан дээр хог хаягдал болохоор зар сурталчилгаа байршиуулахгүй байх;
- 10.2.10. Энэ хуулийн 9.4.12-т заасан нийтийн эдэлбэр газрын хог хаягдал, цас, мөсийг цэвэрлэх;
- 10.2.11. Барилга барих, буулгах, засварлах үйл ажиллагаанаас гарах хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах, булилах эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад шилжүүлж, үйлчилгээний хөлсийг хариуцах;

Химиин хорт болон аюултай бодисын тухай хууль:

10 дугаар зүйл. Химиин хорт болон аюултай бодис хадгалахад тавих үндсэн шаардлага

10.1.Химиин хорт болон аюултай бодис хадгалах агуулахын байршилыг холбогдох мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн зохих шатны Засаг дарга тогтооно.

10.2.Химиин хорт болон аюултай бодисыг түүний онцлог шинж чанарыг нь харгалзан зориулалтын тусгай агуулахад энэ хуулийн 6.1.2-т заасны дагуу батлагдсан журмыг баримтлан хадгалина.

10.3.Хадгалж байгаа химиин хорт болон аюултай бодисын сав, баглаа боодол нь тухайн бодисын нэр, анхааруулах тэмдэг, аюулын шинж чанарыг тод, томоор бичсэн шошготой байна.

Химиин хорт болон аюултай бодис алдагдсан тохиолдолд түүнийг эзэмшигч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь цагдаа, тагнуулын болон холбогдох бусад байгууллагад 24 цагийн дотор мэдэгдээж, эрэн сурвалжлах арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд бүх талын туслацаа үзүүлэх үүрэгтэй.

12 дугаар зүйл. Химиин хорт болон аюултай бодис тээвэрлэхэд тавих үндсэн шаардлага

12.1. Химиин хорт болон аюултай бодисыг энэ хуулийн 6.1.2-т заасны дагуу батлагдсан журмыг баримтлан техникийн болон аюулгүйн шаардлага хангасан тээврийн хэрэгслээр тээвэрлэх бөгөөд уг тээврийн хэрэгслэд анхааруулах тэмдэг, аюулын шинж чанарын тухай санамж байрлууна .



12.2. Химиин хорт болон аюултай бодис тээвэрлэсний дараа тээврийн хэрэгслийг хоргуулж аюулгүй болгоно.

12.3. Химиин хорт болон аюултай бодисыг хүн, мал, амьтан болон бараа бүтээгдэхүүнтэй хамт тээвэрлэхийг хориглоно.

12.4. Химиин хорт болон аюултай бодисыг шуудангаар илгээх, нийтийн тээврийн хэрэгслээр болон ердийн хөсгөөр тээвэрлэхийг хориглоно.

Төслийн үйл ажиллагаатай холбоотой стандартууд:

Хүснэгт 2 Төслийн үйл ажиллагаатай холбоотой стандартууд

№	Стандартын тэмдэглэгээ	Стандартын нэр
1	MNS 5365:2004	Агаарын чанарын ерөнхий асуудлууд. Тоосны нарийн ширхэгийн хэмжээг тодорхойлох арга
2	MNS 4585:2016	Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
3	MNS 5885:2008	Агаарын бохирдлыг үүсгэгч бодисын агууламж. Техникийн ерөнхий шаардлага
4	MNS 0900:2018	Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Үндны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ
5	MNS 5916:2008	Байгаль орчин. Газар шорооны ажлын үеийн үржил шимт хөрсний хуулалт, хадгалалт Техникийн шаардлага
6	MNS 5918:2008	Байгаль орчин. Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн шаардлага
7	MNS 4919:2000	Эвдэрсэн газарт хучилт хийх хөрс. Техникийн шаардлага
8	MNS 5668:2006	Усны биологийн шинж чанарын шинжилгээ. Бохир усны микробиологийн шинжилгээний арга.
9	MNS 4943 - 2015	Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага
10	MNS 4990:2015	Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагаа. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага.
11	MNS 4244:94	Галын аюулгүй байдал, ерөнхий шаардлага
12	MNS 4284:95	Галын аюултай бодис, материал ангилал
13	MNS 5566:2020	Аж ахуй нэгж, байгуулага барилга байгууламжинд гал унтраах, анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага норм
14	MNS 5390:2004	Цахилгааны аюулгүй байдал, ерөнхий шаардлага
15	MNS 5146:2002	Цахилгааны аюулгүй ажиллагаа, хамгаалах газардуулга тэглэлт
16	MNS 5151:2002	Цахилгааны аюулгүй ажиллагаа. Нэр томъёо, тодорхойлолт
17	MNS 5914:2008	Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томъёо, тодорхойлолт
18	MNS 5918:2008	Байгаль орчин. Эвдэрсэн газрыг дахин ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага
19	MNS 5344: 2011	Ахуйн хог хаягдал тээвэрлэлт. ангилал. Ерөнхий шаардлага
20	MNS 5850: 2019	Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх хэмжээ
21	MNS 5342: 2007	Автомашины зогсоол, ангилал, ерөнхий шаардлага
22	MNS 6734:2018	Дахин ашиглах цэвэрлэсэн ус. Техникийн ерөнхий шаардлага
23	MNS 4597:2014	Авто замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага.
24	MNS ISO 16075-1:2018	Цэвэрлэсэн хаягдал усыг усалгаанд ашиглах гарын авлага. I—р хэсэг. Ус дахин ашиглах төслийн үндсэн шаардлага
25	MNS 6768:2019	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй. Ажлын байран дахь шуугианы өртөлтийн хэмжилт зөвшөөрөх дээд хэмжээ , ажилтны сонсгол хамгаалахад тавих ерөнхий шаардлага



26	MNS 6807: 2019	Авто замын чанарын хяналтын үнэлгээний арга
27	MNS 6808: 2019	Явган хүний зам, талбайн төлөвлөлт, техникийн шаардлага
28	MNS BS 8515:2019	Борооны ус хуримтлуулах систем. Хэрэглээний дүрэм
29	MNS 6260: 2020	Зүлэгжүүлэх талбай бэлтгэх, үр тарих, арчлах
30	MNS 0899: 2020	Үнд ахуйн зориулалттай төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрийг сонгох журам ба эрүүл ахуй, техникийн шаардлага
31	MNS 6845: 2020	Барилгын гаднах ажлын байрны гэрэлтүүлэг. Техникийн шаардлага
32	MNS 6458:2014	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага
33	MNS 5029:2011	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодисын шошго, анхааруулах тэмдэг
34	MNS 4992:2000	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт бодисын ангилал ба аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага

Олон улсын гэрээ, конвенциуд:

Олон улсын гэрээгээр улс орнууд тухайн гэрээнд заагдсаны дагуу тодорхой үйлдэл, үйл ажиллагааг явуулах, эсвэл үйл ажиллагаанаас татгалзах үүргийг хүлээдэг. Олон улсын гэрээ хэлэлцээрт заагдсан үүргийг дотооддоо хэрэгжүүлэх тохиолдолд Засгийн газар нь олон улсын гэрээний нөхцөлүүдийг хэрэгжүүлэх үндэсний хуулиудыг батлан гаргах ёстой. Монгол Улсын Засгийн газраас олон улсын гэрээ хэлэлцээрүүдийг хэрэгжүүлэх зорилгоор батлагдсан тодорхой хуулиудыг олон нийтэд таниулдаг. Харин “Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ хэлэлцээрүүдийн заалттай үндэсний хууль тогтоомж зөрчилдвэл олон улсын гэрээ хэлэлцээрийн заалтуудыг мөрдөнө” гэсэн зарчмыг хуульд тусгаж өгсөн.

Иймд уг төсөлд хамааралтай, төслийн хүрээнд үйлчлэх Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенциудын талаар дор товч дурдав.

- Цөлжилттэй тэмцэх олон улсын конвенци** - 1996 оны 12-р сарын 26-ны өдрөөс Монгол улсад хүчин төгөлдөр болсон. Энэхүү конвенцийн зорилго нь ноцтой хуурайшилт буюу цөлжилттэй тулгараад байгаа улс орнуудад бүхий л түвшинд үр дүнтэй арга хэмжээг авч олон улсын хамтын ажиллагааны дэмжлэг туслалцаатайгаар цөлжилттэй тэмцэх, хуурайшилтын үр нөлөөг бууруулахад оршино.
- Биологийн төрөл зүйлийн олон янз байдлын тухай конвенци** - 1993 оны 9-р сарын 30-наас Монгол улсад хүчин төгөлдөр болсон. Биологийн төрөл зүйлийн олон янз байдлын тухай Конвенци нь тогтвортой хөгжлийг дэмжин дараах гурван үндсэн зорилгыг өмнөө тавьдаг. Энэ нь:
 - биологийн төрөл зүйлийн олон янз байдлыг хамгаалах,
 - тэдгээрийн тогтвортой ашиглалт
 - генетикийн нөөцийг ашигласнаас олох орлогыг тэгш шударгаар хуваарилах зэрэг болно.
- Уур амьсгалын өөрчлөлтийн тухай Нэгдсэн Үндэсний Байгууллагын суурь конвенци** - 1994 оны 3-р сарын 21-ний өдрөөс Монгол улсад хүчин төгөлдөр болсон. Энэ конвенцийн зорилго нь агаар мандал дахь хүлэмжийн хийн агууламжийг дэлхийн уур амьсгалд ноцтой нөлөөлөл үзүүлэхгүй байх хэмжээнд байлгахад оршино.
- Киотогийн протокол** - 2005 оны 2-р сарын 16-наас Монгол улсад хүчин төгөлдөр болсон. Киотогийн протокол нь аж үйлдвэр өндөр хөгжсөн 37 оронд (Монгол улс багтаагүй) болон Европын Холбоонд хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулах заавал биелүүлэх зорилтыг тавьсан. Үүнд, хүлэмжийн хийн ялгаруулалтыг багасгахад
 - ялгаруулалтын худалдаа
 - цэвэр хөгжлийн механизм
 - хамтын хэрэгжүүлэлт гэсэн гурван туслах механизм багтсан.



Холбогдох сайдын тушаал, журам:

- ✓ Ахуйн бохир усны цооногийг доторлох, ашиглах журам. БО-ны ЭМ-ийн сайдын 1995 оны 169/171-р тушаал
- ✓ Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам. БОНХ-ийн сайдын 2013 оны А-156 тушаал
- ✓ Энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бусийн дэглэмийг мөрдөх журам (БОНХАЖЯ, Барилга, хот байгуулалтын сайдын 2015 оны А-230/127 тушаал)
- ✓ Ус ашиглуулах дүгнэлт гаргах үйлчилгээний хөлс, ус ашиглах эрхийн бичиг, гэрээний загвар батлах тухай. БОНХ-ийн сайдын 2013 оны А-157 тушаал.
- ✓ Ус ашиглуулах дүгнэлт гаргах үйлчилгээний хөлсийг шинэчлэн батлах тухай БОНХАЖ-ын сайдын 2016 оны А/33 тушаал
- ✓ “Нэгж бүтээгдхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм батлах тухай” Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/301 дугаар тушаал
- ✓ Аргачлал батлах тухай. Байгаль орчны хохирлын үнэлгээ, нөхөн төлбөр тооцох аргачлал. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2010 оны А-156 тушаал
- ✓ Усны нөөцийг бохирдоос хамгаалах дүрэм (БО, ЭМНХ-ын сайдын 1997 оны 143/A/352 тоот хамтарсан тушаал)
- ✓ Байгаль орчинд нэлөөллийн нарийвчилсан үнэлгээний аргачлал батлах тухай. БОНХ-ийн сайдын 2004 оны А-117 тушаал.
- ✓ Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны 12-р сарын 01-ны өдрийн А/331 “Аргачлалд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” тушаал
- ✓ Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10-р сарын 29-ны өдрийн А/618 тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”,
- ✓ Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайд, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2009 оны 2 дугаар сарын 03-ны өдрийн 28/40/29 дугаар хамтарсан тушаалын 1 дүгээр хавсралт “Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам”
- ✓ Засгийн газрын 2018 оны 116 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам



НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1.1 Төслийн срохийн мэдээлэл

Төслийн нэр:	Дулааны цахилгаан станц
Төсөл хэрэгжүүлэгч:	“Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК
Улсын бүртгэлийн дугаар:	712001001
Регистрийн дугаар:	2628651
Хаяг, байршил:	Дорнод аймаг, Хэрлэн сум, 1-р баг, өөрийн байр
Гүйцэтгэх захирал:	Г.Отгонбаатар
Холбоо барих:	Байгаль орчин, эрүүл ахуйн хяналтын инженер С.Бямбаахүү 99028798 sbyambaa_8798@yahoo.com



Зураг 1 Төслийн талбай



Төслийн байршил




Танхик тэмдэг
■ Төслийн байршил

“Дорнод бүсийн эрчим хүчиний систем” ТӨХК
1:4,000
Coordinate system: WGS 1984 UTM Zone 45N
Projection: Transverse Mercator
Datum: WGS 1984



200 Метр

“Эко Ти Эс Би” ХХК-д боловсруулав



Зураг 2 Төслийн байршил

1.2 Төсөл хэрэгжүүлэгчийн товч танилцуулга

Монгол улсын Засгийн газар Зүүн бүс нутгийн эрчимтэй хөгжлийг хангах, Чойбалсан хотыг аж үйлдвэржүүлэн хөгжүүлэх зорилгоор 1967 оны 06 дугаар сарын 17-ны өдөр тус цахилгаан станцын суурийг тавьж, 1967-1970 онд ЗСБНХУ-ын (хуучин нэрээр) техник эдийн засгийн тусламжаар 12МВт-ын суурилагдсан хүчин чадалтай Дулааны цахилгаан станц баригдан ашиглалтанд орж, 1979-1982 онд Дулааны цахилгаан станцыг БКЗ-75-39/ФБ маркийн 3 зуух, ПТ12-35/10М маркийн 2 турбогенератораар өргөтгөж станцын хүчин чадал 36 МВт болж нэмэгдсэн.

Үндсэн үйл ажиллагааны хувьд тус компани цахилгаан дулаан үйлдвэрлэх түгээх зохицуулалттай хангах, цахилгаан импортлох эрчим хүчиний тоноглолд засвар туршилт хийх, цахилгаан эрчим хүчин дулааны эрчим хүчиний тоолуур гүйдлийн трансформатор суурилуулах засварлах зэрэг 9 тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг. Зүүн бүс нутгийн 36 сум суурин газрын 26346 айл өрх, 2161 аж ахуйн нэгж, байгууллага, 15 уул уурхай, газрын тос олборлолтын компаниудыг 0,4, 6, 10, 15, 35, 110кв-ын 3493.1 км агаарын болон кабель цахилгаан дамжуулах шугам, 507 ком дэд станцыг ашиглан цахилгаанаар хангаж байна. Мөн Чойбалсан хотын 878 аж ахуйн нэгж, 6658 айл өрхийн хэрэглэгчдийг 26,5 хос км далд болон ил шугамаар дамжуулан дулаанаар ханган ажиллаж байна.

Дорнод бүсийн эрчим хүчиний системийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний урт 2011 онд 3125.34 км байсан бол 2017 онд 3492.9 км болж 12 %-иар өсөж, үйлдвэрлэлийн суурилагдсан хүчин чадал ашиглалт цахилгаанаар их ачааллын үед 100%-аас давж, 2015-2016 оноос эхлээд өвлүүлж их ачааллын хугацаанд ЦЭХ-ний хэрэглээг бүрэн хангах боломжгүй болсон тул Сүхбаатар аймгийн хэрэглэгчдийг ТБЭХС-д шилжүүлж, станцын үндсэн тоноглолтууд бэлтгэлгүйгээр ажиллаж эхэлжээ. Цахилгааны оргил ачаалал суурилагдсан хүчин чадлаас давж 2017 онд 38.6 МВт хүрсэн ба цаашид бүс нутгийн ЦЭХ-ний өсөлтийг тогтвортой хангах боломжгүй болсон байна.

Энэхүү эрчим хүчиний хэрэглээний огцом өсөлтийг хангах, эрчим хүчиний найдвартай эх үүсвэрээр хэрэглэгчдийг хангах нь Зүүн бүс нутгийн эрчим хүчиний хангамжийн тулгамдсан асуудал болж байна. Иймээс Монгол Улсын Засгийн газраас мөрийн хөтөлбөртөө эхний ээлжид богино хугацаанд хэрэгжих боломжтой хувилбар болох Чойбалсангийн ДЦС-ыг 50 МВт-аар өргөтгөх төслийг хэрэгжүүлэхээр техник эдийн засгийн үндэслэл боловсруулан Эрчим хүчиний яамны Шинжлэх ухаан технологийн зөвлөлөөр хэлэлцүүлж дэмжигдсэн байна.

1.3 Бүтэц зохион байгуулалт, хүний нөөц

Засгийн газрын 2001 оны 07 дугаар сарын 09 ний өдрийн 164 дүгээр тогтоолоор “Дорнод бүсийн эрчим хүчиний систем” төрийн өмчит хувьцаат компани болон үйл ажиллагаа нь өргөжин тэлж, эрчим хүчиний хангамжийн үйлчлэх хүрээ Монгол улсын Зүүн бүс нутгийг хамрах болов. “ДБЭХС” ТӨХК-ийн 70 хувийг Эрчим хүчиний яам, 30 хувийг Төрийн өмчийн Бодлого зохицуулалтын газар тус тус эзэмшдэг.

Тус компани нь Дорнод, Сүхбаатар 2 салбар, Захиргаа удирдлага, Хангамж үйлчилгээ, Санхүү бүртгэлийн 3 хэлтэс, Төлөвлөлтийн 1 хэсэг, Дотоод хяналтын, Техник хяналтын, Инженерийн, Хамгаалалтын 4 алба, Түлш дамжуулах, Зуух, Турбин-Хими, Цахилгаан, Компьютер-дулааны хэмжүүр автоматик, Механик засвар, Цахилгаан шугам сүлжээ, Дулааны шугам сүлжээний нийт 8 цех, нэгжүүдийн зохион байгуулалттай, үйл ажиллагааны холимог бүтэцтэй ажил үйлчилгээ явуулдаг. Компанийн хүний нөөцийн хувьд удирдлага 10, ИТА 123, ажилтан 469 нийт 615 хүний батлагдсан орон тоотой ба магистр 3, бакалавр 161, тусгай дунд 14, бүрэн дунд 395, бүрэн бус дунд 23 байгаагаас Монгол улсын зөвлөх инженер 2, мэргэшсэн инженер 7, мэргэшсэн нягтлан бодогч 2,



мэргэшсэн төсөвчин 2 хүн тус тус ажиллаж байна. ДЦС-ыг өргөтгөсний дараа орон тоо 90 хүнээр нэмэгдэнэ гэж тооцож байна.

1.4 Төслийн хүчин чадал

“Дорнод бүсийн эрчим хүчин систем” ТӨХК нь 36 МВт чадалтай цахилгаан-дулааныг хослон үйлдвэрлэдэг Дулааны цахилгаан станц буюу Дулаан цахилгааны төв, Чойбалсан хотыг дулаанаар хангах дулааны шугам сүлжээ, цахилгаан эрчим хүч дамжуулах түгээх сүлжээ бүхий эрчим хүчиний үйлдвэрлэл, түгээлт явуулдаг компани болно. Эрчим хүчиний зохицуулах хорооноос олгосон цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэх, түгээх, зохицуулалттай хангах, импортлох, эрчим хүч барилга угсралтын 8 тусгай зөвшөөрлийн хүрээнд:

- Дорнод, Сүхбаатар аймгийн 36 сум, багийн 24710 айл өрх, 3133 аж ахуйн нэгж, албан байгууллага, уул уурхайн 13 ордын баяжуулах, олборлох үйлдвэрүүдийг,
- 0.4, 6, 10, 15, 35, 110 кВ-ын 3455.1 км агаарын болон кабель шугам, 507 иж бүрдэл дэд станцыг ашиглан цахилгаан эрчим хүчээр,
- Чойбалсан хотын 822 аж ахуйн нэгж, 6117 айл өрхийн хэрэглэгчдийг 26.5 хос/км далд болон ил шугамаар дамжуулан дулааны эрчим хүчээр тус тус хангах үйл ажиллагаа эрхэлж байна.


Эрчим хүчиний хэрэглээний огцом өсөлтийг хангах, эрчим хүчиний найдвартай эх үүсвэрээр хэрэглэгчдийг хангахын тулд 36 МВт хүчин чадалтай станцыг 50 МВт-аар өргөтгөхөөр болсон.

Хүснэгт 3 Станцын хүчин чадал

Үзүүлэлт	Нэгж	36 МВт	50 МВт	86 МВт
		Төслөөр	Өргөтгөл	Теслөөр
Суурисан хүчин чадал цахилгаанаар	МВт	36	50	86
Жилд үйлдвэрлэх цахилгаан	сая кВт·ц	131.0	300	431.0
ДХЦЭХ	мян кВт·ц	22.6	37.5	60.1
	%	17.25	12.5	-
Түгээх цахилгаан	сая кВт·ц	108.4	262.5	370.5
Суурисан хүчин чадал (дулаанаар)	усаар	Гкал/ц	91.6	191.6
	уураар	тн/ц	81.9	280
	усаар	мян. Гкал	336.0	504.0
Жилд үйлдвэрлэх дулаан	уураар	мян. Гкал	210.0	-
Түгээх ДЭХ	мян. Гкал	289.4	-	-
Түлшний хувийн зарцуулалт	цахилгаан	гр/кВт·ц	256	386.8
	дулаан	кт/Гкал	185	176.9
Нүүрний зарцуулалт	мян. тн	-	526.3	1,026.58



ТЕХНОЛОГИЙН СХЕМ



Зураг 3 Технологийн схем

1.5 Төслийн төлөвлөлт

Чойбалсангийн ДЦС нь Чойбалсан хотын зүүн хэсэгт Хэрлэн голын хойно харьцангуй тэгш тохойд далайн түвшнээс 747.35-750.17 м өндөрлөгт нийт 25.76 га газрыг албан ёсоор эзэмших эрхтэй бөгөөд үүнээс 15.06 га газрыг одоогоор ашиглаж байна. Үлдсэн 10.7 га газрыг ашиглаагүй нөөц талбайтай байна.


ДЦС-ын үйлдвэрийн барилга нь анхны төслөөр баригдахдаа дахин өргөтгөл хийх боломжтой байх хувилбарыг тооцоолон үйлдвэрийн зүүн хана нь капитал биш түр ханатай баригдсан байдал. Өөрөөр хэлбэл зүүн тийш нь өргөтгөх зайд талбайг тооцож баригдсан байдал.

Чойбалсангийн ДЦС-ын зүүн талд өргөтгөлийн барилга байгууламж барих хангалттай нөөц газар байгаа тул шинээр баригдах өндөр даралтын 50 МВт станцыг хуучин ДЦС-ын барилгыг зүүн тийш өргөтгөн залгуулж барих юм.



Зураг 4 ДЦС-ыг өргөтгөх талбай





Зураг 5 ДЦС-ын орготгол хийх талбарт орготголийн байшин, зуух ба турбин, яндан, нүүрс нөөцлөх талбайн (өргтгөлийн штабель) байршилыг үзүүлсэн зураг

1.6 ДЦС-ын үндсэн ба туслах тоноглол

Үндсэн 36 МВт хүчин чадалтай ДЦС-ын тоноглол:

Уурын зуух:

Хүснэгт 4 Уурын зуухны техникийн үзүүлэлт

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Уурын зуух					
		№	1	2	3	4	5
Ашиглалтад орсон	он	1969	1969	1971	1979	1980	1982
Маяг	-		ТП-35У			БКЗ-75-39/ФБ	
Уурын зарцуулалт	тн/ц		35			75	
Хурц уурын даралт	ата		39			39	
Хурц уурын халуун	оC		440			440	
Тэжээлийн усны халуун	оC		145			145	
Түлшний зарцуулалт	тн/ц		12.1			25.3	
АҮИ	%		80			86	



Үүрэн турбин:

Хүснэгт 5 Үүрэн турбины техникийн үзүүлэлт

Үзүүлэлт	Хэмжих иэгж	Үүрэн турбин			
		№	1	2	3
Ашиглалтад орсон хугацаа	он	1969	1969	1980	1982
Хэв загвар		АП-6-35/5		ПТ-12-35/10М	
Хурц уурын даралт	ата	35		35	
Хурц уурын халуун	0С	435		435	
Үйлдвэрийн авлагын зарцуулалт	тн/ц	40		50	
Үйлдвэрийн авлагын даралт	ата	6		8/13	
Дулаачуулгын авлагын зарцуулалт	тн/ц	-		40	
Дулаачуулгын авлагын даралт	ата	-		1.2	
Турбинд орох уурын зарцуулалт	тн/ц	55.8		108.8	
Конденсатор дахь вакум	%	95		91	
Суурилагдсан генераторын чадал	Вт	6		12	

Генератор:

Хүснэгт 6 Генераторын техникийн үзүүлэлт

Үзүүлэлт	Хэмжих иэгж	Генератор			
		1	2	3	4
Тип, марк		T-6-2	T-6-2	T-12-2	T-12-2
Актив чадал	кВт	6000	6000	12000	12000
Бүрэн чадал	кВА	7500	7500	15000	15000
Статорын хүчдэл	кВ	6.3	6.3	6.3	6.3
Статорын гүйдэл	А	688	688	1376	1376
Давтамж	Гц	50	50	50	50
Эргэлтийн тоо	эрг/мин	3000	3000	3000	3000
Чадлын коэффициент		0.8	0.8	0.9	0.8
АҮИ	%			97.7	97.6
Роторын гүйдэл	А	216	216	248	248

Өргөтголийн 50 МВт хүчин чадалтай ДЦС-ын тоноглол:

Зуухны сонголт:

Монгол улсын эрчим хүчиний системд ажиллаж буй ДЦС-уудад ашиглаж буй зуухны үндсэн үзүүлэлтүүд нь ОХУ-ын Барнаулын зуухны үйлдвэрлэсэн (Барнаульский котельный завод) зуухнууд байдаг. Иймд шинээр өргөтгөх 50 МВт-ын турбогенераторыг ажиллуулахад шаардагдах 250 т/ц -с их уур үйлдвэрлэх хүчин чадалтай 540оС хурц уур үйлдвэрлэх 9.8 МПа (100



кгс/см²) даралттай болон түүнээс илүү үзүүлэлттэй, Адуунчулууны хүрэн нүүрс шатаахад зориулагдсан зуух байх шаардлагатай болно.

Эдгээр хүчин зүйлсийг судлан манай улсад түгээмэл хэрэглэж буй тоосон нүүрсний дөлт шаталтын эзлэхүүн, галын хотолтой зуухнаас ачааллын хувьсах горимд ажиллах чадвартай эргэлдэх буцлах давхаргад шаталтын технологи (ЭБДШ)-той зуухыг сонгож байна. Адуунчулууны ордын илчлэг бага, чийглэг ихтэй үндсэндээ чанар муу хүрэн нүүрсийг ЭБДШ зууханд шатаахад илүү үр ашигтай байх болно.

Зуухны төрөл: Эргэлдэх буцлах давхаргад шаталтын технологи

Ажиллагааны горим: Тогтмол ба хувьсах ачаалал

Үндсэн түли: Адуунчулууны ордын Б1 маркын хүрэн нүүрс

Туслах түли: Зуурыг галлах, зогсоох үед хэрэглэх шингэн түлш

Хүснэгт 7 Уурын зуухны технологийн үзүүлэлт

Үзүүлэлт	Нэгж	Тоо хэмжээ
Уурын бүтээмж	тн/цаг	250-аас их
Боломжит бага ачаалал	тн/цаг	70-100
Тогооны даралт	МПа (кгс/см ²)	11 (112)
Хурц уурын даралт	МПа (кгс/см ²)	9.8 (100)
Хурц уурын халуун	°C	540
Тэжээлийн усны халуун	°C	215
Утааны хийн халуун	°C	130
Зууханд шатаах нүүрсний нунтагралт	мм	10-15
Зуухны өндөр	метр	44.3

Оргөтгелөөр сонгогдсон зуух нь дараах туслах тоноглолтой байна. Үүнд:

Утааны яндан: ДЦС-ын 50 МВт хүчин чадлаар өргөтгөх төслийн судалгаагаар зуухны хамгийн оргил ачааллын гормын үед цагт зарцуулах нүүрсний хэмжээ 236 тн байхаар байна. Иймд зуухны бүрэн хүчин чадлаар ажиллахад ойролцоогоор 150 м өндөртэй, амерын голч Ø5.4м диаметртэй утааны яндан байх шаардлагатай байна. Шинэ утааны яндангийн багер, үns зайлцуулах шугамын байрлыг зурагт үзүүлэв.



Зураг 6 Шинэ яндангийн болон багер, үns зайлцуулах шугамын байрлал



Утааны хий цэвэрлэх тоноглол: Шинээр төлөвлөж буй утааны янданд утааны хийн үнсийг шүүх цэвэрлэгээний төхөрөмжөөр тоноглоно. Орчин үеийн шаардлагад тулгуурлан дулааны цахилгаан станцын өргөтгөлд уутат шүүлтүүр сууринуулахаар төлөвлөх нь зүйтэй. Уутат үнс барих тоноглолын үнс барилтын АҮК өндөр, стандартад заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс бага байх нөхцөлийг бүрдүүлдэг. Уутат шүүлтүүрийн хэмжээ, бүтээмжийг тулшиний цагийн зарцуулалт, түүний шаталтаас үүсч утаатай тээвэрлэгдэн гарах дэгдэмхий үнсний хэмжээг тодорхойлох тооцооны үр дүнд тулгуурлан сонгоно.

Уутат үнс баригч нь утааны хийтэй хамт тээвэрлэгдэх нарийн үнс, тоосонцрыг хуурай аргаар шүүж ялгах зориулалттай бөгөөд ба уутат шүүлтүүрийн гадна талаас утааны хий дотогш нэвтрэн өнгөрөхөд үнсний ширхэглэгүүд шүүгч уутанд баригдан үлдэнэ. Үнс баригч нь үнс тоос цуглуулах (утааны хийнээс үнсийг салгах) болон тогтмол хугацаанд үнс зайлуулах (утан шүүлтүүрт хуримтлагдсан үнс, тоосонцрыг цэвэрлэх) гэсэн дэс дарааллаар ажилладаг.

Үнс, тоосонцор цуглуулах процессын үндсэн шаардлагууд:

- Үнс, тоосонцор нь уутат шүүлтүүрийн гадаргуутай (эсвэл уутны гадна хуримтлагдсан үнс тоосонцортой) мөргөлдөх ёстой.
- Үнс, тоосонцрыг нь уутны гадаргууд (эсвэл уутны материалд наалдсан үнс тоосонцортой хамт) хуримтлуулагддаг.



Зураг 7 Уутат шүүлтүүрийн технологи

Үнс зайлуулах систем: Үнсийг хуурай болон нойтон гэсэн хоёр аргаар зайлуулдаг. Хуучин ДЦС-ын зуухнаас гарч буй үнсийг усаар зайлуулдаг. Багерын аж ахуйтай. Иймд шинээр барих ДЦС-ын зуухнаас гарч буй үнсийг усаар зайлуулахаар тооцсон.


Үнсэн сан: Чойбалсангийн ДЦС-ыг 1970 онд 2 үнсэн сантай ашиглалтанд оруулсан. Эдгээр үнсэн сангүүд нийт 87.6 мян. м² талбайд 353.1 мян. м³ багтаамжтай үнс агуулах бөгөөд 1-р үнсэн сан 166.4 мян. м³, 2-р үнсэн сан 186.7 мян. м³ багтаамжтай байгуулсан. Ашиглалтын хугацаанд 2 дугаар үнсэн сангүүд үнсээр дүүрсэн тул хөрсжүүлэн саармагжуулалт хийгдсэн.

Өнөөдрийн байдлаар 1980 онд ашиглалтанд оруулсан 166.4 мян. м³ үнс агуулах багтаамжтай 1-р үнсэн санг ашиглаж байна.

ДЦС-ыг 50 МВт хүчин чадлаар өргөтгөхөд 900 мян. м³ үнс агуулах багтаамжтай 4-р үнсэн санг шинээр байгуулах шаардлагатай байна. Дорнод аймгийн Засаг даргын захирамжаар 1, 2, 3 –р үнсэн сантай зэрэгцээ талбайд 4-р үнсэн сан байгуулаад зориулан 20.5 га газрыг “ДБЭХС” ТӨХК –д



эзэмшүүлсэн байдаг. 4-р үнсэн сангийн талбайд 80-90 мян.м² талбайтай 2 үнсэн сан шинээр барих боломжтой. /Газар эзэмших гэрчилгээг тайланд хавсаргав./



Зураг 8 ДЦС-ын үнсэн сангийн ерөнхий байдал



Зураг 9 Үнсэн сангудын байршил

Шинээр барих үнсэн сангийн ус хөрсөнд шингэхээс сэргийлж үнсэн санг ус чийг нэвтрүүлдээгүй зориулалттай тусгай материалыар доторлох шаардлагатай.

Тунгаасан усны насос станц: ДЦС-ын өргөтгөлд ашиглагдах шинэ үнсэн сангийн дэргэд тунгаасан усны насос станц байгуулах шаардлагатай. Тунгасан усны насос станц нь ДЦС-аас 0.8 км зайд байрлуулах боломжтой байна. Тунгаасан усыг техникийн зориулалтаар буюу үнсний канал үнс шааргыг хөөж урсгахад хэрэглэдэг.





Зураг 10 Тунгаасан усны насос станцын байриши

Тунгаасан усны насос станц нь жилд 1 сая орчим м³ усыг эргүүлэн ашиглах техникийн даалгаврыг биелүүлэхэд 2 насос сууринуулах шаардлагатай.

Уурын турбины сонголт:

ДЦС нь зуух, турбин гэсэн үндсэн 2 цех болон хими, цахилгаан, автоматик, түлш дамжуулах, механик зэрэг туслах цех, нэгжүүдээс бүрддэг. Цех, нэгжүүд нь хоорондоо харилцан уялдаатай, тасралтгүй үйл ажиллагаатай ажиллаж дулаан, цахилгааны энергийг хослон үйлдвэрлэдэг.

Уурын турбины ажиллах технологийн ажиллагаа, зарчмыг дараах хоёр хэсэгт ангиладаг. Үүнд:

- Дулаанжуулалтын турбин
 - Уурын тохируулгын авлагатай турбин
 - Эсрэг даралтын турбин
- Конденсацын турбин

Уурын турбины сонголтыг хийхдээ дараах үзүүлэлтүүдийг авч үзэв. Үүнд:

- Нэгж дулаан зарцуулалт
- Төслийн цахилгааны чадал
- Цахилгаан, дулаан хослон үйлдвэрлэх байдал
- Зуны ба өвлийн горим
- Зах зээлд нэвтрэсэн байдал
- Үнэ, өртөг зэрэг болно.


ДЦС-ын өргөтгөлд цахилгаан, дулаан хослон үйлдвэрлэдэг дулаанжуулалт болон конденсацийн горимоор ажилладаг уурын турбин байх нь тохиромжтой.

Чойбалсан хотын аж үйлдвэрийн хөгжлийн төлөвлөлтийн тэсөөллөөр 36 МВт хүчин чадалтай ДЦС-ын ПТ-12-35/10м маркын уурын турбин 50т/ц, П-6-35/5 маркын уурын турбин 40 тн/ц уур үйлдвэрлэн үйлдвэр, аж ахуйн нэгжид уур түгээдэг байсан. Энэхүү хэрэглэгдэж байсан үйлдвэрийн уурын авлагын шугамыг ашиглан усаар дулаан түгээх боломжтой.



Төлөвлөж буй 50 МВт-ын хүчин чадалтай ДЦС нь цахилгаан үйлдвэрлэхийн зэрэгцээ усаар дулаан түгээх зориулалттай байх юм. Хуучин ДЦС-ын уур, усаар дулаан дамжуулах шугам хоолой тоног төхөөрөмжүүд элдэлдэлд орж хуучирсан тул Чойбалсан хотын хэрэглэгчдийг дулаанаар (усаар) хангах асуудлыг ачааллын суурь горимд ажиллах шинэ 50 МВт-ын өргөтгөлийн ДЦС-аас дулааны сүлжээний цогц систем суурилуулах замаар төлөвлөв.

Өргөтгөлийн ДЦС-ын уурын турбин тоноглолын байршилын зургийг дор үзүүлэв.



Зураг 11 Уурын турбин тоноглолын байршилын зураг

Уурын турбин нь дараах туслах тоноглолуудтай байна. Үүнд:

Тэжээлийн усны деаэратор: Тэжээлийн усын деаэратор 2 ширхэг байхаар төлөвлөв. Деаэратор нь тэжээлийн усанд агуулагдаж буй хорт хийг арилгах, тэжээлийн усыг тодорхой температур хүртэл халаах, тэжээлийн усыг нөөцлөх зэрэг үүрэгтэй. Уснаас хий зайлцуулах ажиллагаа деаэрацын клонкод явагддаг. Тэжээлийн усны деаэраторын бүтээмж нь 350 тн/ц байх шаардлагатай.

Тэжээлийн усны насос: Тэжээлийн усны насос нь деаэратороос гарах цэвэршүүлсэн усыг өндөр даралтын халаагчаар дайруулан зуухыг тэжээлийн усаар тасралтгүй хангах үүрэгтэй. Тэжээлийн усны насосыг 270 м3 /ц бүтээмжтэй хувьсах зарцуулалтын 2 ширхэг насостой байна.

Хөргөлтийн цамхаг: ДЦС-ын шинэ өргөтгөлд уурын турбинийг ажиллуулсан хурц уурыг конденсатороор дамжуулан хөргөлтийн усыг хөргөх шаардлагатай тул хөргөлтийн усан цамхаг шинээр барихаар төлөвлөв. Төмөр бетонон хийцтэй хөргөлтийн цамхаг ашиглах нь зүйтэй.

Хуучин ДЦС-ын АП-6-35/5 маркийн 2, ПТ-12-35/10м маркийн 4 ширхэг турбины нийт уурын зарцуулалтыг конденсациар дамжуулан 6000-8000м3 /ц усыг шинээр барих ДЦС-ын 50 МВт-ын уурын турбины уурын зарцуулалтыг конденсацилгахдаа 9000 м3 /ц усыг нэмж тооцоолон хөргөх усны цамхагийн хүчин чадлыг тодорхойлох шаардлагатай.

Шинэ хөргөлтийн цамхаг нийт 15000-17000 м3/ц ус хөргөх хүчин чадалтай ажиллахаар байна. Хэрэв шинээр барих хөргөлтийн цамхгийг зогсоох, засвар үйлчилгээ хийхэд хуучин ДЦС-ын одоогийн ашиглаж байгаа хөргөлтийн системээ ашиглаж болохоор төлөвлөв. Өргөтгөл хийх явцад хуучин станцын хөргөлтийн усны шугамыг цаашид холболт хийх боломжтой байдлаар схем гаргах шаардлагатай.





Зураг 12 Хөргөх цамхгийн байгуулах байршил

Хөргөх цамхгийн байршилыг өргөтгөл хийх гэж байгаа байршилын зүүн урд талд $136 \times 70 = 9520\text{m}^2$ талбайд байршуулахаар төлөвлөсөн.

Эргэлтийн усны насос: Эргэлтийн усны насос нь уурын турбины конденсаторын хөргөлтийн усыг хөргөх цамхаг, конденсатороор дайруулан шахаж байх үүрэгтэй. Эргэлтийн усны 2 ширхэг насос ажиллана.

Дулааны шугам сүлжээний халаагуур: Дулааны шугам сүлжээ нь 1412-1800 м³/ц усыг 70/130оС температур хүргэл халаана. Халаагуур нь уурын турбины тохицуулгатай отбороос уур авч ажиллахаас гадна Чойбалсан хотын дулааны төв шугамын параметртэй зохицон ажиллах боломжтой байна.

Дулааны шугам сүлжээний усны насос: Дулааны шугам сүлжээний усыг түгээх цахилгаан насос нь сүлжээний анхдагч параметртэй усыг бойлеруудаар дайруулан халааж хэрэглэгчдийн халаалтын системүүдэд шахаж егнэ. Шугам сүлжээний усны 2 ширхэг насос байх шаардлагатай байна. Шугам сүлжээний усны насос нь хувьсах зарцуулалтанд ажилладаг хөдөлгүүрээр тоноглогдсон байна.

Шугам сүлжээний усны деаэратор: Шугам сүлжээний усны деаэратор нь дулааны шугам сүлжээний алдагдлыг нөхөх, сүлжээний усны хорт нэгдлүүдийг шүүх, дулааны шугам сүлжээний халаагуурын сүлжээний усны насосны сорох талд тасралтгүй өгөх зориулалттай тоног төхөөрөмж болно.

Генераторын сонголт:

ДЦС-ын өргөтгөлд цахилгаан энерги үйлдвэрлэх генератор нь дараах үзүүлэлтийг хангасан байна.
Үүнд: Цахилгаан генераторын техникийн үзүүлэлт

Төрөл: Гурван фазын 50Гц-ийн хувьсах гүйдлийн синхрон генератор

- Хүчин чадлын үзүүлэлтүүд:
 - Генераторын хэвийн чадал 50,000 кВт
 - Генераторын дээд чадал 60,000 кВт
- Хэвийн эргэлтийн хурд: 3000 эрг/мин
- Сүлжээний давтамж: 50 Гц



- Хүчдэл 6.3 кВ
- Өдөөлт Щётокгүй, статик

Цахилгаан генератор тавигдах шаардлага:

- Цахилгаан ачаалал тохируулах төхөөрөмжтэй байх;
- Хүчдэл тохируулах автомат төхөөрөмжтэй байх;
- Гүйдлийн фазын өнцгийг хянах төхөөрөмжтэй байх.
- Генератор ба трансформаторт микро-процессорын хамгаалалт хэрэглэнэ.

Генератор ба трансформаторын хамгаалалтад микро-процессорт тулгуурласан хамгаалалт хэрэглэх ба нам хүчдлийн болон өндөр хүчдлийн цахилгаан хөдөлгүүрүүд зэрэгт микро-процессорт тулгуурласан иж бүрэн хамгаалалт, хяналтын төхөөрөмж хэрэглэнэ.

Хуваарилах байгууламжийн хамгаалалт, гэмтлийн бичилтийг хийх, удирдлагын төвд мэдээлэх төхөөрөмжийг суурилуулна.

1.7 Түлшний хангамж, дамжуулах тоноглол

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” Түлш дамжуулах цех нь Адуунчулувун нүүрсний ордоос хүрэн нүүрсийг хүлээн авах, нүүрсний чанар, тоо хэмжээнд хяналт тавих, неөцлөх, цаг тухайд нь зохих боловсруулалт хийж ДЦС-ын зуухнуудыг тасралтгүй нүүрсээр хангах үйл ажиллагаа эрхлэдэг. [№ХА/2021/04 дугаар Нүүрс худалдах, худалдан авах гэрээ](#)

Нүүрсний хэрэглээний тооцоо:

Шинэ өргөтгөлд сонгосон хоёр ЭБДШ зуухны нэгийг бэлтгэлд нөгөөг жилд ойролцоогоор 6000 цаг ажиллахаар тооцоход цагт 280 тн хурц уур үйлдвэрлэхэд 80-90 тн нүүрс хэрэглэхээр байна. Жилийн цахилгаан ба дулааны ачааллын горимыг цаг, өдөр, сараар тооцох замаар жилийн нүүрсний хэрэглээг тооцоолон хүснэгтээр үзүүллээ. Шинэ, хуучин ДЦС-ыг зэрэгцээ ажиллуулахад жилд нийт 1,026.8 мян. тн нүүрс хэрэглэхээр байна.

Хүснэгт 8 ДЦС-ын жилд хэрэглэх нүүрсний хэрэглээ

Үзүүлэлт	Нэгж	Одоо байгаа	Өргөтгөл	Нийт
Ажиллах зуухны тоо	ш	5	1	6
Станцын хоногийн нүүрсний зарцуулалт	тн	1390	1442	2832
Зуухнуудын жилийн нүүрсний зарцуулалт	тн	500,552.0	526,300.0	1,026.852
Дамжуулах тоноглолын суурилагдсан хүчин чадал	т/ц	101	200	301
Хоногт дамжуулах нүүрс	тн	1440	1500	2940
Сард дамжуулах нүүрс	тн	43200	45025	84500
Жилд дамжуулах нүүрс	тн	518,400.0	540,300.0	1,058.700

Адуунчулувун ордын нүүрсний тооцоо:

ДЦС-ын түлшний үндсэн нөөц нь Адуунчулувун нүүрсний орд болно. Адуунчулувун нүүрсний орд нь Дорнод аймгийн төв Чойбалсан хотоос зүүн хойш 8 км орчим газар байдаг. Адуунчулувун нүүрсний ордын газар зүйн байрлал нь зүүн урагш, баруун хойшоо аажмаар намссан сул дов толгод бүхий довторхог налуу гадаргуутай тал газар оршдог. Хэрлэн гол нь нүүрсний орд газраас 8 км орчим зайд урсдаг.

Адуунчулувун нүүрсний ордыг эзэмших эрх бүхий Адуунчулувун ХК, Найнг ХХК, Дорнод МАК ХХК гэсэн 3 компани олборлох үйл ажиллагаа эрхлэдэг.



“Дорнод бүсийн эрчим хүчиний систем” ТӨХК нь Адуунчулуун ХХК-ийн нүүрсний уурхайгаас 7.4 км, “Дорнод МАК” ХХК-ийн нүүрсний уурхайгаас 8.2 км зйтай оршдог ба нүүрс тээвэрлэлтийг 2 уурхайгаас тээвэрлэх боломжтой.




Зураг 13 Адуунчулуун ордоос нүүрс тээвэрлэх замын зураг

ДЦС-ын нүүрс нөөцлөх, дамжуулах тоноглол:

36МВт хүчин чадалтай ДЦС-ын түлш дамжуулах цехэд 185-205 тн/ц хүчин чадалтай нүүрс бутлах 2 ш бутлагч, 65-105 тн/ц хүчин чадалтай 0-25 мм нүүрсийг бутлах 2 ш бутлагч, цагт 105-130 тн нүүрс дамжуулах нийт 10 ш конвейертэй. Конвейерүүд нь 800-650 мм өргөн туузтай, 17-30 кВт чадалтай цахилгаан хөдөлгүүрээр тоноглогдсон. Нүүрс түрэх зориулалтай Т-170 маркын 5 ш бульдозертой үйл ажиллагаа явуулж байна.

Түлш дамжуулах цехийн тоноглолын ажиллагааны схемийг доорх зурагт схемчлэн үзүүлэв.




Зураг 14 Түлийн дамжуулалтад цехийн ажшиглагдааны бүдүүвч зураглал

ДЦС-ын орготголийн түлш хангамж:

Түлш дамжуулах цех нь хүчин чадлынхаа 70 орчим хувийг ашиглан 2017 онд 518,400.0 тн нүүрс дамжуулсан байна. Тооцоо судалгааны үр дүнд шинээр төлөвлөж буй ДЦС-ын ЭБДШ зуухны нүүрсний жилийн хэрэгцээ 526,300.0 тн байх бөгөөд жилд 540,300.0 тн нүүрс дамжуулах тоног төхөөрөмжийг шинээр сууринуулах шаардлагатай байна.

Түлш дамжуулах цехийн одоогийн хүчин чадал нь хүрэлцэхгүй тул 50 МВт-ын өргөтгөл зориулан түлш дамжуулах цехийг өргөтгөн шинээр байгуулах хэрэгтэй. Хуучин нүүрс буулгах талбайг 4000 м² нэмэгдүүлэх, нүүрс дамжуулах конвейер, нүүрс бутлах байгууламж, нүүрс нуруулах бульдорзэрийг зэргээр хүчин чадлыг нэмэгдүүлэх шаардлагатай.

Түлш дамжуулах хэсгийн шинээр барих барилга байгууламжийг дараах зурагт тоймлж үзүүлэв.



Зураг 15 ДЦС-ын 50 МВт-ын өргөтгөлийн түлийн дамжуулалт байгууламжийн байршилын тойм зураг

Тулши дамжуулах тоноглолд тавигдах шаардлага:

1. Нүүрс жинлэхэд тавигдах шаардлага:

- Одоо ашиглаж буй 100 тн электрон автопүүний даацыг 150-180 тн хүртэл нэмэгдүүлэх, автопүүний тавцанг хүнд даацын лист төмрөөр хүчитгэх (Хуучин автопүүний байрлалд өргөтгөл хийх боломжтой);
- Нүүрсний чанар, тоо хэмжээний хяналт бүртгэлийн систем, электрон ачааллын элемент хэвлэгчтэй байх
- Нүүрс хүлээн авах орцины өргөн 6 м-ээс багагүй байх, ачааны овор хэмжээ, хурд хязгаарлах тэмдэг, тэмдэглэлтэй байх.

2. Нүүрс хүлээн авах ил талбай:

Станцын түлшний аж ахуйн нь нүүрс тээвэрлэх, бутлах байгууламж, хүлээж авах бункеруудээс бүрдэнэ. Мөн хөлдүү нүүрс гэсгээх төхөөрөмжтэй байна. Нүүрсний ил талбайн орчмын тусгал сайтай /600-800 люкс/ гэрэлтүүлэгээр хангаж камерийн систем байрлуулах.

Нүүрс нөөцлөх ил талбай нь 55000-60000 тн нүүрс нөөцлөх багтаамжтай байх ба буулгасан нүүрсийг бульдозероор эмхэлж цэгцлэх, 10 градусын налуутай нягт нуруулдаж хураах, үйлдвэрийн үйл ажиллагааг хангах зорилгоор 3 ээлжийн системээр 24 цагийн хугацаанд түрж татах ажлуудыг тасралтгүй гүйцэтгэнэ.

Нүүрс хүлээн бункер нь нүүрсийг өвлийн улиралд гэсгээх, доргиох төхөөрөмж суурилуулсан байна.

Мазут ба шингэн түлшиний аж ахуй:

ДЦС болон эрчим хүчин системийн бусад ДЦС-ын зуухыг шинээр галлах эсвэл зуухны ачаалал хэт буурахад ОХУ-аас импортлодог M100 маркийн мазутыг хэрэглэдэг. Мазут нь шаталтын процессыг дэмжих зориулалттай юм.

Харин шинээр барих ДЦС-д ЭБДШ зуухыг сонгосон бөгөөд уг зуух нь дизель эсвэл керосин түлш ашиглах зориулалттай байдаг. Иймд шингэн түлш хадгалах 160 тн -с дээш багтаамжтай ган сав байх ёстой. Гэхдээ ДЦС-д ашиглаж буй мазут хадгалах 400 тн 1 ширхэг, 200 тн багтаамжтай 2 ширхэг ган савны нэгийг буюу 200 тн багтаамжтай савыг шинэ ДЦС-д ашиглуулах боломжтой гэж ДБЭХС ТӨХК-ийн удирдлагууд үзэж байна. Энэ тохиолдолд нэмэлт тоног төхөөрөмж авах шаардлагагүй болно (тэжээлийн насос, хаягдлын шүүлтүүр). Шингэн түлшийг цистернтий машиниар станцад нийлүүлж болно.

Мазут аж ахуйн байршил ба өргөтгөлийн зуухыг шингэн түлшээр хангах шугам сүлжээний байршлын тоймыг зураг 16-д үзүүлэв.





Зураг 16 Мазут аж ахуйн байршил ба өргөтгөлийн зуухыг шингэн түлшинд холбох шугамын тоём зураг

1.8 Техникийн усан хангамж

Одоогоор ДЦС нь усан хангамжийг 4 гүний худгаас татдаг байна. Энэ нь өргөтгөлийн 50 МВт ДЦС-ын хэрэгцээнд шаардлагатай усаар бүрэн хангаж чадахгүй. Тиймээс өргөтгөх төслийн хүрээнд Турбин хими цехийн техникийн усан хангамжийг нэмэгдүүлэхийн тулд Хэрлэн голын хөндийд шинээр 5 ширхэг цооног өрөмдөн газрын гүний худаг гарган шийдвэрлэхээр ТЭЗҮ-д тусгасан байна.”Дорнод бүсийн эрчим хүчиний систем” ТӨХК нь Хэрлэн голын сав газрын захиргаанаас ус ашиглах зөвшөөрөл, ус ашиглуулах дүгнэлт, хаягдал усны дүгнэлт, хаягдал ус хаях, зайлцуулах зөвшөөрөл гаргуулан ажиллаж байна.

Усны бэлтгэл:

Гүний худгаас олборлож буй түүхий усыг шугам хоолойгоор дамжуулан ДЦС-ын турбин цехэд түүхий усыг нөөцлөн боловсруулдаг. Турбин цехэд насосоор түүхий усыг халаагчаар халаан → халсан түүхий усыг баканд нөөцлөн → механик шүүлтүүр → натрийн шүүлтүүр → эсрэг осмос → деаратороор оруулан зуухыг цэвэршүүлсэн усаар тэжээдэг.

ДЦС-д ашиглаж буй гүний ус нь механик хольц булингар, төмрийн агууламж өндөр, эрдэс давс ихээр ууссан байдаг учраас урьдчилсан ус цэвэрлэгээний тоног төхөөрөмжүүдээр боловсруулан ион солилцооны арга, эсрэг осмосын бүрэн давсгүйжүүлэх системүүдээр дамжуулан цэвэршүүлж усны хатуулаг 0.01 мг-экв/дм³, төмрийн агууламж 0.02 мг/л хүртэл бууруулж ДЦС-ын дулаан болон цахилгаан энерги үйлдвэрлэх процесст хэрэглэдэг.

ДЦС-ыг 50 МВт-аар өргөтгөхөд турбин химиийн цехийн ус бэлтгэлийн хүчин чадлыг 100 тн/цаг-аар нэмэгдүүлэх шаардлагатай болох ба үүнд зарцуулах техникийн давс, аммиак, фосфатын хэмжээ мөн тодорхой хэмжээгээр нэмэгдэнэ.

Гүний худаг:

Чойбалсан хотын 36 МВт хүчин чадалтай ДЦС-ын техникийн усыг 4 гүний худгаас хангадаг. Худгуудын ашиглалтын усны ундарга 40-45 л/с байна. Гүний худгуудын байршил, техникийн үзүүлэлтүүдийг дараах хүснэгтэд оруулав.



Хүснэгт 9 Гүний худгийн мэдээлэл

№	Худаг	Ашиглалтанд орсон он	Бүтээмж, м3	Даралт, ата	Худгийн цооногийн гүн, м
1	Худаг №3	1980	160	10	42
2	Худаг №4	2004	160	10	43
3	Худаг №5	2003	160	10	44
4	Худаг №6	2004	160	10	42

Цооногийн байршил:

Турбин химийн цехийн үйлдвэрлэлийн зориулалттай техникийн усан хангамжийн газрын гүний 4 худаг нь ДЦС-аас 1.5 км зайд Хэрлэн голын дагуу байрладаг. Гүний худгууд хоорондоо 400-450 м зйттай орших ба шахах шугам нь Ø-273 x 9 хос шугамаар насос станцын ус нөөцлөх бак болон брызгалын ил бассейныг нэмэлт усаар хангадаг.

Хүснэгт 10 Үйлдвэрлэсэн эрчим хүч ба усны хэрэглээ

Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2012	2013	2014	2015	2016	2017	Өргөтгөл
Үйлдвэрлэсэн эрчим хүч	Сая кВт/ц	71.32	88.54	97.32	108.2	213.5	230.2	300
Жилийн усны хэрэглээ	мян/тн	446.8	392.32	450	450.0	988.5	1012.2	834.0

ДЦС-ын ашиглаж буй 4 газрын гүний худгаас татах нийт усны хэмжээ шинээр барих 50 МВт ДЦС-ын өргөтгөлийн хэрэгцээнд шаардлагатай усаар бүрэн хангаж чадахгүй. Тиймээс нэмэлт ус хангамжийн худаг гаргах шаардлагатай.


Нэмэлт техникийн ус хангамжийн худаг:

ДЦС-ыг 50 МВт хүчин чадлаар өргөтгөх төслийн хүрээнд Турбин хими цехийн техникийн усан хангамжийг нэмэгдүүлэхийн тулд Хэрлэн голын хөндийд шинээр 5 ширхэг цооног өрөмдөн газрын гүний худаг гаргах боломжтой гэж үзэж байна. Гүний худгаас татах усыг шинээр барих ус нөөцлөх санд хуримтлуулна. Ус нөөцлөх сангийн эзэлхүүн 1000 м3 багтаамжтай байна.

Гүний худгийн өргөх насос нь ус нөөцлөх сангаас сорж ДЦС-ын хөргөх цамхагийн хөргөлтөөс алдагдах усны хэмжээг тооцоолон шинээр баригдах ДЦСын дотоод хэрэгцээнд хүрэлцэхүйц техникийн усыг гүний худгийн нөөцлөх сангаас татахад 3 ширхэг өргөх насос шаардлагатай ба насос нь 320 т/ц бүтээмжтэй, шахах өндөр 50 м, хөдөлгүүрийн чадал 75 кВт, хөдөлгүүрийн эргэлт 1480 эрг/мин үзүүлэлттэй байна. Ус татах хос шугам сүлжээний голч Ø273мм, 2.2 км урттай байна.

Шинээр барих ус нөөцлөх сан, ус татах шугам сүлжээ, гүний худгийн цооногуудын байрлалыг төслийн талбарт судалгаа хийсний үр дүнд тогтоон зурагт үзүүлэв.





Зураг 17 Шинээр гаргах худгийн байршил

Шинээр баригдах газрын гүний худгуудын дэргэд усны түвшний ажиглалтыг тогтмол хэмжих пъезометрийн 2 цооног гаргана.

Усны хэрэглээ:

Одоогийн ус хэрэглээ: Усны газрын гаргасан 2022 оны 4-р сарын 15-ны өдрийн 62 дугаартай ус ашиглуулах дүгнэлтийг үндэслэн Хэрлэн голын сав газрын захиргаа “Дорнод бүсийн эрчим хүчиний систем” ТӨХК-д цахилгаан, дулаан үйлдвэрлэлийн технологийн хэрэгцээнд 2,374,647.48 м³ газрын доорх усыг нэг жилийн хугацаанд ашиглахыг зөвшөөрчээ.

2022 онд 309,594 мВтц цахилгаан боловсруулж, 569,700 Гкал дулаан үйлдвэрлэнэ. БОНХАЖ-ын сайдын 2015 оны А/301-р тушаалаар баталсан “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны хэрэглээний норм”-ын дагуу тооцоход үйлдвэрлэлийн усны нийт хэрэгцээ 2,374,647.48 м³ байна.

$$309,594 \text{ мВтц} \times 0.42 \text{ м}^3/\text{мВтц} = 130,029.48 \text{ м}^3 \text{ (цахилгаан үйлдвэрлэхэд зарцуулах ус)}$$

$$569,700 \text{ Гкал} \times 3.94 \text{ м}^3/\text{Гкал} = 2,244,618 \text{ м}^3 \text{ (дулаан үйлдвэрлэхэд зарцуулах ус)}$$

$$620 \text{ хүн} \times 150 \text{ л/хон} \times 365 = 33,945 \text{ м}^3 \text{ (унд ахуйн усны нийт хэрэгцээ)}$$

Байгалийн ноөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 20.1.1 дэх заалтын дагуу унд ахуйд ашиглах 33,945 м³ усыг төлберөөс чөлөөлнө.

Өргөтгөсний дараах ус хэрэглээ: Өргөтгөл ашиглалтад орсноор 86 МВт суурилагдсан хүчин чадалтай ДЦС нь жилд 431,000 мВт·ц цахилгаан эрчим хүч, 840,000 Гкал дулаан үйлдвэрлэнэ¹. Энэ ДЦС нь нийт 615 хүний батлагдсан орон тоотой бөгөөд өргөтгөсний дараа орон тоо 90 хүнээр нэмэгдэж нийт 715 хүн болно.

¹ Эрчим хүчиний эдийн засгийн хүрээлэн ТӨҮГ, Чойбалсангийн ДЦС-ыг 50 МВт-аар өргөтгөх ТЭЗҮ

431,000 мВтц x 0.42 м³/мВтц = 181,020 м³ (цахилгаан үйлдвэрлэхэд зарцуулах ус)

840,000 Гкал x 3.94 м³/Гкал = 3,309,600 м³ (дулаан үйлдвэрлэхэд зарцуулах ус)

715 хүн x 150 л/хон x 365 = 39,146 м³ (унд ахуйн усны нийт хэрэгцээ)

“Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны хэрэглээний норм”-ын дагуу тооцоход үйлдвэрлэлийн усны нийт хэрэгцээ 3,490,620 м³ болж нэмэгдэхээр урьдчилсан тооцоо гарч байна.

Хаягдал ус:

Ахуйн хаягдал усны хэмжээг “Дорнод нийтийн аж ахуй” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу 37,200 м³/жил, технологийн хэрэгцээнээс гарсан хаягдал усны хэмжээг тус компаниас ирүүлсэн тайланг үндэслэн 351,000 м³/жил байхаар тооцжээ. ДЦС нь унд ахуйн хэрэглээнээс гарсан бохир усиг “Дорнод нийтийн аж ахуй” ХХК-ийн ариутгах татуургын сүлжээнд нийлүүлдэг бөгөөд технологийн хаягдал усиг 100,000 м³ эзлэхүүнтэй үнсэн сан, тунгаах усны бассейн ашиглан механик аргаар цэвэрлэж 80 орчим хувийг эргүүлэн ашигладаг ба үлдсэн хэсгийг байгальд нийлүүлдэг. 1444 м³ эзлэхүүн бүхий эргэлтийн усан сантай.

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК нь Хэрлэн голын сав газрын захиргаанаас хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийг 2021 оны 4-р сарын 27-ны өдөр авсан. Усны газрын гаргасан 2021 оны 3-р сарын 25-ны өдрийн хаягдал ус хаях, зайлуулах 48 тоот дүгнэлтийг үндэслэн “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-д хаягдал ус зайлуулах цэг буюу хүрээлэн буй орчинд болон төвлөрсөн бохир усны шугамд жилд 388,200 м³ хаягдал усиг Хүрээлэн байгаа орчин, усны чанар, хаягдал ус, ерөнхий шаардлага MNS 4943:2015, Хүрээлэн байгаа орчин, усны чанар, ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус, ерөнхий шаардлага MNS 6561:2015 стандартаар тогтоосон шаардлагад нийцүүлэн хаях, зайлуулах зөвшөөрлийг нэг жилийн хугацаагаар олгож, ус бохирдуулсны төлбөрийн гэрээ, дүгнэлтийг зөрчөөгүй тохиолдолд зөвшөөрлийг жил бүр сунгагдсан тооцно.

ДЦС-ыг өргөтгөсний дараа усны хэрэглээ нэмэгдэх тул хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийг тухай бүрт нь шинэчилж авах шаардлагатай.



ХОЁРДУГААР БҮЛЭГ: ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ

2.1 Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл

ДЦС-ын үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд учирч болзошгүй нөлөөллийг тогтоохдоо энэ төслийн Байгаль орчны төлөв байдлын үнэлгээний тайлан, байгаль орчны суурь нөхцөл, дүгнэлт, урьд өмнө хийгдсэн байгаль, нийгэм, эдийн засгийн холбогдолтой судалгааны материалыуд, судалгаа явуулсан мэргэжлийн экспертуудийн дүгнэлтүүдийг үндэслэн тодорхойлов.

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг Монгол улсын Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, БОНХАЖЯ-наас гаргасан Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний аргачилсан заавар /2014/, Байгаль орчин аялал жуулчлалын яамнаас гаргасан ерөнхий үнэлгээний дүгнэлт, байгаль орчны эрх зүйн баримт бичгүүдэд тулгуурлан байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд өргөн хэрэглэгддэг матриц, магадлан жагсаах зэрэг аргыг ашиглан хийж гүйцэтгэлээ.

Матрицийн арга:

Тухайн төслийн үйл ажиллагаа болон түүнийг хэрэгжүүлэх явцад байгаль орчинд учруулах ээрэг, сөрөг нөлөөллийг харилцан уялдаа холбоотойгоор авч үзэж, нөлөөллийг бүрэн тодорхойлох өргөн боломжтой арга юм. Төслийн үйл ажиллагаатай шууд хамааралтай асуудлууд болон байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдтэй холбоотой асуудлыг матрицийн босоо, хэвтээ шугамын дагуу ангилан байрлуулж харилцан үйлчлэлийг нь матрицийн хүснэгт дээр тэмдэглэнэ. Матрицийг бүрдүүлэхэд төслийн үйл ажиллагааны жагсаалт болон байгалийн нөхцөл байдлын хүснэгт, картыг ашигладаг. Энэ арга нь нэлээд нарийн үйл ажиллагаа шаарддаг.

Аливаа үйлдвэрлэлийн технологийн чухам аль үе шатанд байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд илүү их сөрөг нөлөөлөл үзүүлэх нөхцөлтэй болохыг тодорхойлох нь энэ аргын гол зорилго болно. Энэ зорилгоор байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд болон үйлдвэрлэлийн технологийн үе шатууд дахь нөлөөллийн эрчмийг үнэлсэн экспертуудийн үнэлгээгээр матриц байгуулах аргыг байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээнд өргөн ашигладаг. Экспертнийн үнэлгээг ихэнхдээ 1-5 балл гэж үзнэ. Нөлөөлөл хамгийн бага бол 1, хамгийн их бол 5-аар авна. Энэ арга нь төслийн нөлөөллийг илүүтэй сайн гаргаж чаддагаараа бусад аргуудаас давуутай.

Энэ аргыг хэрэглэхдээ доорхи үйлдлүүдийг дэс дараагаар нь гүйцэтгэдэг. Үүнд:

- Хэрэв ямар нэг нөлөөлөл байна гээж үзвэл түүнд хамаарах дөрвөлжинг босоо зураасаар 2 хуваана.
- Хуваагдсан хэсгийн цагаан хэсэгт болзошгүй нөлөөллийн байдлыг 1-5 хүртэлх тоогоор үнэлнэ.
- Хуваагдсан хэсгийн саарал хэсэгт 1-5 хүртэлх оноогоор нөлөөллийн хир зэрэг хүчтэйг үнэлж болно. Үүнд: 1 бол нөлөөллийн эрчим хамгийн бага, 5 бол хамгийн их утга болно. Ийнхүү нөлөөллийн үнэлгээ өгөхдөө мэргэжлийн экспертуудийн дүгнэлтийг үндэс болгосон болно.



ДЦС-ын үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг матрицийн аргыг ашиглан тодорхойлов.

Хүснэгт 11 Матриц

Нөлөөлөлд өртөгч Нөлөөлөгч													Нийт дүн		
	Газрын гадарга, хэвлэй	Агаарын чанар	Хөрсөн бүрхэвч	Ургамлан нэмрэг	Амьтны аймаг	Газрын доорхи үс	Хүн амын эрүүл мэнд								
Барилга байгууламж /төслийн төлөвлөлт/	5	5	4	3	4	4	4	3	3	2	2	3	3	25	24
Нүүрсний агуулах, тээвэрлэлт	3	3	4	4	4	4	4	4	4	3	2	3	3	25	24
Үнсэн сан	3	3	4	3	3	3	3	3	3	2	2	4	3	22	20
Дуу чимээ, шуугиан	1	1	4	3	1	1	1	3	3	1	1	4	3	15	13
Хатуу хог хаягдал	2	2	3	3	3	3	3	3	3	3	3	3	3	20	20
Хийн хаягдал	2	2	2	2	3	3	3	3	3	3	3	3	3	19	19
Нийт дүн	16	16	21	18	18	18	18	19	19	14	13	20	18	126	120

Үнэлгээний хүснэгтийн хэвтээ багануудын нийлбэр дунгээс үзвэл, төслийн үндсэн үйл ажиллагаа болох барилга байгууламж, дэд бүтэц, тээврийн хэрэгсэл зэрэг нь байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл их байна. Босоо багануудын нийлбэр дунгээс үзвэл агаар, хүн амын эрүүл мэнд зэрэг нь хамгийн их өртөгч байна.

Матрицын агаар үнэлсэн дунгээс авч үзэхэд нийт нөлөөлийн дунгээс төслийн төлөвлөлт 25 буюу 19.8%, нүүрсний агуулах, тээвэрлэлт 25 буюу 19.8% , үнсэн сан 22 буюу 17.4 %, хатуу хог хаягдал 20 буюу 15.8% -ийг эзэлэж байна. Нөлөөллийн эрчмийн хувьд төслийн барилга байгууламж барих үйл явц болон нүүрс хадгалах талбай, үсэн сангаас үүсэх нөлөөлөл илүү эрчимтэй нөлөөлөхөөр байна.

Байгалийн бүрэлдэхүүн хэсэг болох хөрсөн бүрхэвчинд 15%, агаарын чанарт 17.5%, ургамлан нэмрөгт 15%, хүний эрүүл мэндэд 15% сөрөг нөлөөлөл үзүүлэхээр байна.

Магадлан жагсаах буюу хяналтын хуудасны арга:

Энэ арга нь байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдийн төрлийг жагсаан тэдгээрийг төсөлтэй холбоотойгоор харьцуулан тодорхойлсон хүснэгт бүрдүүлэх арга юм. Хүснэгтийн аргын хэд хэдэн ялгаатай хэлбэр /энгийн, хуваарь бүхий, хуваарь болон утга бүхий г.м/-үүд байдаг. Аливаа үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах үйл ажиллагаанаас тухайн орон нутгийн байгаль орчны төлөв байдал, нийгэм, эдийн засаг болон хүн амын амьдрах орчинд хэрхэн нөлөөлөх, тэдгээр нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчимшил зэргийг тогтооход магадлан жагсаах буюу хяналтын хуудасны аргыг өргөн хэрэглэдэг. Энэхүү аргыг байгаль орчны бүрэлдэхүүн тус бүр дээр тооцов.



Хүснэгт 12 Нөлөөллийн үнэлгээг хийсэн аргачлал

Нөлөөллийн чанар	Тухайн нөлөөллийн онцлоогоос хамааран нөлөөллийн утга нь зерэг, сөрөг эсвэл саармаг байж болно. (жишээ нь чухал ач холбогдол бүхий төрөл зүйлийн амьдрах орчин сайжирсан нь зерэг гэдэг ангилалд орох бол амьдрах орчин нь алдагдвал сөрөг гэдэг ангилалд орно)
Нөлөөлийн эрчим	Анализ буюу хэмжилтэд (жишээ нь бэлчээрийн талбайн хэмжээ, стандарт түвшинтэй харьцуулсан усны дээжинд агуулагдах хүнд металлын агууламж зэрэг) гарсан өөрчлөлтийн хэмжээ бөгөөд нөлөөлөл байхгүй, бага, дунд зэрэг, их гэсэн ангилуудтай байна.
Үргэлжлэх хугацаа	Байгаль орчинд үзүүлж буй нөлөөллийн үргэлжлэх хугацааг хэлнэ. Жишээ нь түр зуурын (1 жилээс доош хугацаатай), богино хугацааны (0-5 жил), дунд хугацааны (5-15 жил), урт хугацааны (15 жилээс дээш хугацаатай бөгөөд төсөл хаалт хүртэл үргэлжлэх) эсвэл байнгын нөлөөлөл гэх мэт.
Хамрах хүрээ /Нөлөөллийн бүс	Тухайн нөлөөлөлд өртөх газрын хэмжээ цар хүрээг хэлэх бөгөөд тухайн орчны, орон нутгийн, бус нутгийн, үндэсний хэмжээний, олон улсын хэмжээний гэх зэрэгээр ангилагдана.
Нөлөөлөл магадлал	Нөлөөлөл үүсч бий болох магадлалын зэргийг тодорхойлж буй бөгөөд магадлал байхгүй (үүсэх магадлал нь 5%-аас бага), магадлал багатай (5-40%-ийн магадлалтай), магадлалтай (40-60%-ийн магадлалтай), магадлал өндөртэй (60-90%-ийн магадлалтай), гарцаагүй (магадлал нь 90%-аас дээш) гэх зэрэгээр ангилна.
Нөлөөллийн зэрэглэл	Мэргэжилтнүүд доорх хүснэгтэд үзүүлсэн оноо өгөх системийг ашиглан тодорхойлдог зүйл юм.

Хүснэгт 13 Нөлөөллийн үнэлгээний систем

Нөлөөллийн эрчим	Үргэлжлэх хугацаа	Хамрах хүрээ	Магадлал
10 - Маш их	5 – Байнгын (30- дээш жил)	5 - Олон улсын хэмжээнд	5 - Гарцаагүй
8 - Их	4 - Урт хугацааны (15-30 жил)	4 - Үндэсний хэмжээнд	4 - Өндөр магадлалтай
6 - Дунд	3 - Дунд хугацааны (5-15 жил)	3 - Бус нутгийн хэмжээнд	3 - Дунд магадлалтай
4 – Бага	2 - Богино хугацааны (0-5 жил)	2 - Орон нутгийн хэмжээнд	2 - Бага магадлалтай
2 – Маш бага	1 - Түр зуурын	1-Тухайн орчны хэмжээнд	1 - Тохиолдохгүй
0 - Нөлөөлөлгүй			

Нөлөөлөл тус бүрт эдгээр хүчин зүйлүүдийг эрэмбэлсний дараагаар үүсэх магадлал ба хор уршиг гэсэн 2 зүйлийн зэрэглэлийг доорх томьёог ашиглан тооцно:

Оноо = (Эрчим + Үргэлжлэх хугацаа + Хамрах хүрээ) x Магадлал

Онооны зэрэглэлийн хамгийн их утга нь 100 байна. Байгаль орчны боломжит нөлөөлүүдийг бууруулах арга хэмжээтэй уялдуулан Их, Дунд зэрэг, Бага гэж дараах байдлаар зэрэглэн ангилна.




>75	БО-нд нөлөөлөх зэрэглэл өндөр (H) байгааг илтгэх	Энэ тохиолдолд ямар бууруулах арга хэмжээ байж болох вэ гэдгээс үл хамааран энэ нь төслийг эхлүүлэх эсэх талаар шийдвэр гаргахад нөлөөлнэ.
30-75	БО-нд үзүүлэх нөлөөлөл Дунд зэрэг (M) байгааг илтгэх	Бууруулах арга хэмжээ төлөвлөхгүй л бол энэ нь төслийг эхлүүлэх шийдвэрт нөлөөлнэ. Дунд зэрэглэлийн нөлөөлөл нь менежментийн төлөвлөгөө гаргахыг зайлшгүй шаардлаг. Хэрэв менежментийн төлөвлөгөө боловсруулахгүй бол төслийг эхлүүлэх эсэх талаарх шийдвэрт ч нөлөөлж болзошгүй.
<30	БО-нд үзүүлэх нөлөөллийн зэрэглэл Бага (L) байгааг илтгэх	Төслийг эхлүүлэх эсэх талаарх шийдвэрт нөлөө үзүүлэхгүй. Маш бага нөлөөлөл нь төслийн төлөвлөлт, дизайнд өөрчлөлт оруулахад хүргэдэггүй бөгөөд бууруулах арга хэмжээний өөр хувилбаруудыг ашиглах шаардлагагүй байдаг.
+	Эрэг нөлөөлөл	Ийм нөлөөллийн дунд эрэг үр дүнгүүд гардаг.
-	Нөлөөлөлгүй	

2.2 Газрын гадарагад үзүүлэх гол ба болзошгүй нөлөөлөл

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК нь нийт 25.82 га талбайг үйлдвэрийн зориулалтаар эзэмшдэг бөгөөд одоогоор 15.06 га талбайг ашиглаж байгаа ба 50 МВт станцын өргөтгөлийг үлдсэн 10.7 га талбайд барихаар төлөвлөсөн.

ДЦС нь Чойбалсан хотын зүүн дүүрэгт байрлах бөгөөд станцын баруун болон хойд талаараа суурышлын бүс зэрэгцэн оршиж, зүүн болон урд талаараа суурышлын бүсгүй сүл байна.

Одоогоор ДЦС нь нийт 126.1 мян.м² талбайд 3 үнсэн сан ашиглаж байгаа ба өргөтгөлийн хүрээнд нийт 205 мян.м² талбайд 2 үнсэн сан шинээр байгуулахаар төлөвлөсөн байна.



Зураг 18 Үнсэн сан





Зураг 19 Газар ашиглалт

Гол сорог нөлөөлөл:

- ✓ Станцын өргөтгөл нь газар ашиглалтын хэмжээг 36.0 га-аар нэмэгдүүлэх, газрын неөцийг багасгах
 - ✓ Өргөтгөлийн ажилд ашиглагдах тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд зориулж шинээр зам засаж сайжруулсны улмаас газрын гадарга эвдрэлд өртөх
 - ✓ Нүүрс буулгах, тээвэрлэх хэсэгт нүүрсний нарийн ширхэгт тоос тоосонцор салхинд хийсч орчны газрын гадаргыг бохирдуулах
 - ✓ 36.0 га талбайн шимт хөрсийг хуулсанаар газрын гадарга эвдрэлд өртөх



Болзошгүй сорог нөлөөлөл:

- ✓ Цахилгаан станцад ашиглагдах химиин бодисын ашиглалтын явцад ажилчдын санамсар болгоомжгүй үйлдэл, үйлдвэрлэлийн ослын үед үүссэн алдагдал, асгаралт, дэлбэрэлтээс болж газрын гадарга, хэвлэй бохирдох
- ✓ ЭБД шаталттай зуухнаас гарах дэгдэмхий үнс, шаартыг тээвэрлэх явцад алдагдал асгаралт үүсч, газрын гадарга хэвлэй бохирдуулах
- ✓ Цахилгаан станцын ашиглалтын үед ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын менежментэд доголдол үүссэн тохиолдолд хог хаягдал ил задгай хаягдаж, газрын гадаргыг бохирдуулах
- ✓ Барилгын ажил болон ашиглалтын үед ашиглах тээврийн хэрэгсэлд эвдрэл бий болсноос шатах тослох материал алдагдаж, газрын гадаргыг бохирдуулах

Хүснэгт 15 Магадлан жагсаалт

Аргачлал	Шууд	Шууд бус	Нөлөөллийн эрчим	Үргэлжлэх хугацаа	Хамрах хүрээ	Магадлал	Нөлөөллийн зэрэглэл
Нөлөөллийн эх үүсвэр							
Гол сөрөг нөлөөлөл							
Төслийн төлөвлөлт үйл ажиллагаа	+		8	2	1	5	M
Тээврийн хэрэгсэл	+		8	2	1	4	M
Тоос, тоосонцор		+	6	2	2	4	M
Болзошгүй сөрөг нөлөөлөл							
Хог хаягдал	+		4	1	1	4	L
Химиин бодисын ашиглалт		+	4	1	1	4	L
Шатах тослох материал		+	4	1	1	4	L
Нөлөөллийн зэрэглэл							
>75	8	Их	Бүс нутгийн хэмжээнд	3	Өндөр	4	
30-75	6	Дунд	Орон нутгийн хэмжээнд	2	Дунд	3	
<30	4	Бага	Тухайн орчны хэмжээнд	1	Бага	2	
Эрэг	2	Маш бага					

Хэсгийн дүгнэлт:

Төслийн үйл ажиллагаанаас газрын гадарагад үзүүлэх гол нөлөөллүүд нь төслийн төлөвлөлт, үйл ажиллагаа, хог хаягдал болон тээврийн хэрэгслүүдийн үйл ажиллагаатай шууд хамааралтай.

Төслийн үйл ажиллагаанаас газрын гадарагад нөлөөллөх дээрх гол сөрөг нөлөөллүүдийг магадлан жагсааж тэдгээрийн эрчим, үргэлжлэх хугацааг тодорхойлбол нөлөөллүүдийн 33% нь их, 16% нь дунд, 50% нь бага эрчимшилтэй, үргэлжлэх хугацааны хувьд 50% богино хугацааны буюу 0-5 жил, 50% түр хугацааны нөлөөлөл байна. Ерөнхийд нь дүгнэвэл төслийн үйл ажиллагаанаас газрын гадарагад үзүүлэх нөлөөлөл ДУНД гэсэн ангилалд хамарагдаж байна.



2.3 Агаарын чанарт үзүүлэх гол ба болзошгүй нөлөөлөл

Дулааны цахилгаан станцын байгальд орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийн хамгийн их нь агаарын бохирдол бөгөөд түүний дотроос агаарт хаяж буй утаа нь агаар бохирдуулах гол элемент юм. Ялгарах бохирдуулагчид болох хүхрийн давхар исэл (SO_2), азотын ислүүд (NO_x), нарийн, том ширхэглэгт тоосонцорууд ($\text{PM}_{2.5}$, PM_{10}), угаарын хий (CO), байх ба нүүрстөрөгчийн давхар исэл (CO_2) зэрэг хүлээмжийн хий, мөн нүүрсний агуулгаас хамааран хүнд металлууд, дэгдэмхий органик бодисууд ялгарч болзошгүй. Эдгээрээс үүдэлтэй хүний эрүүл мэнд, байгаль орчинд нөлөөлж болзошгүй.

Байгаль орчны төлөв байдлын үнэлгээний судалгааны хурээнд төслийн талбай дахь нийт 3 цэгээс агаарын шинжилгээ хийлгэхэд нийт тоосонцор (TSP) 4-135 мкг/ m^3 , агууламжтай, хүхэрлэг хийн хэмжээ 1-9 мкг/ m^3 , азотын давхар ислийн хэмжээ 11-50 мкг/ m^3 агууламжтай байна.



Зураг 20 Агаарын хэмжилт

Хүснэгт 16 Агаарын хэмжилт

№	Хэмжилтийн цэгийн нэр	Үзүүлэлтийн нэр	Хэмжилт хийсэн дундаж хугацаа	Хэмжих нэгж	Стандарт утга	Хэмжилтийн дундаж утга
1	Хашаан дотор яндангийн доор	Агаарын температур	20 минут	T°C		5.3
		Агаарын даралт	20 минут	гПа		699.7
		Дуу чимээ	15 удаа	дБА	60	50.5
		Салхины хурд	15 удаа	м/с		2.1
2	Хашаан дотор	Агаарын температур	20 минут	T°C		2.8
		Агаарын даралт	20 минут	гПа		709.0
		Дуу чимээ	15 удаа	дБА	60	53.4
		Салхины хурд	15 удаа	м/с		1.2
3	5,6-р зуухны голд	Агаарын температур	20 минут	T°C		2.5
		Агаарын даралт	20 минут	гПа		708.8
		Дуу чимээ	15 удаа	дБА	60	59.2
		Салхины хурд	15 удаа	м/с		



Нийт 3 цэгээс агаарын дээж авч лабораторид шинжлүүлэхэд нийт тоосонцор (TSP) 4-135 мкг/м³, агууламжтай, хүхэрлэг хийн хэмжээ 1-9 мкг/м³, азотын давхар ислийн хэмжээ 11-50 мкг/м³ агууламжтай байна. АЧИ-ээр цэвэр ангилалд хамаарч байна.²

“Оюун шим мандал” ХХК-ний гүйцэтгэсэн 2022 оны байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт ажлын тайлангаас узэхэд ШТСтанц орчим, 5,6 дугаар зуухны голд, ажлын байрны орчмын хүхэрлэг хий, азотын давхар ислийн агууламж нь MNS 4585:2016 стандарттаас даваагүй ба дээрх 3 цэг болон үнсэн сангийн талбайд хийсэн тоосны шинжилгээний дун стандарттаас даваагүй байна. Мөн химийн бодисын агуулах, саам сувиллын орчмын агаарын шинжилгээний дун MNS 4585:2016 стандарттаас даваагүй үзүүлэлттэй байна.³



Орчны цацрагийн шинжилгээг нийт 16 цэгт Rados rds-110 маркын дозиметр багажсаар мкЗв/цаг гэсэн иргэсэр хэмжилт хийсэн байна. Цацрагийн хэмжилтийн дунгээр агаарт хамгийн их нь 0.14 мкЗв/цаг байгаа нь Монгол улсын байгалийн дундааж дэвсгэр түвшин /0.2 мкЗв/цаг/-д байна.

Агаар бохирдуулах бодисуудын тодорхойлолт:

Хүхэрлэг хий: Хүхэрлэг хий/SO₂/ нь хүхэр агуулсан түлшний шаталтаас үүсэх бөгөөд орчныг бохирдуулагч хортой хий. Хүхэрлэг хий нь нүүрс ашигладаг дулааны цахилгаан станц, үйлдвэр, металтург, гангийн үйлдвэр, нүүрс шатаадаг ахуйн зуух, тээврийн хэрэгсэлийн түлшний шаталтаас үүснэ. Хүхэрлэг хийний хоруу чанар нь өндөр концентрацтai үед амьстгал давчдах, хоолой хорсох гэх мэт шинж тэмдэг илэрдэг бөгөөд амьстгалын замын эрхтний системийг гэмтээдэг. SO₂+H₂O+O₂→H₂SO₄ урвалаар томоохон хот, үйлдвэрийн бүсэд хүхэрлэг хийн өндөр концентраци нь усны ууртай нэгдэж хүчиллэг тундас (H₂SO₄) үүсгэдэг. Энэ химийн нэгдэл нь маш хүчиллэг шинжтэй бөгөөд агаарт дэгдэж борооны устай хамт газар буудаг. Хүний эрүүл мэндэд ялангуяа арье, үсэнд хортой. Барилга байгууламжийг аажмаар элэгдүүлдэг.

Азотын давхар исэл: Азотын давхар исэл (NO₂) нь өндөр температуртай шаталтын үед дулаан шингэх урвалын үр дүнд үүсэх бөгөөд хүрээлэн байгаа орчны бохирдлын бас нэг шалтгаан юм. Гол эх үүсвэр нь тээврийн хэрэгслийн шатахууны шаталт, дулааны цахилгаан станц гэх мэт. Газрын гадарга дээрх озон нь азотын давхар ислийн дам бүтээгдэхүүн бөгөөд хүчтэй исэлдүүлэгч тул озоны агууламж ихэсвэл амьтан ургамалын гаднах эд эсийг гэмтээдэг. Азотын ислүүд нь амьстгалын замын цочмог үрэвсэл, багтраа бронхит үүсгэх нөлөөтэй. Азотын ислүүд нь (NO, NO₂, N₂O) агаарын бохирдлын химийн хувиралд гол нөлөө үзүүлдэг. Азотын (NO_x) ислүүдийн ихэнх хувийг шаталтаас үүссэн азотын исэл эзэлдэг бөгөөд шаталтаар ялгарч буй хий нь 2NO + O₂ → 2NO₂ (1) процессоор азотын давхар ислийг бий болгодог.

Нарны гэрлийн энергийн нөлөөгөөр фотохимийн урвалын үр дүнд азотын давхар исэл NO₂ задарч сул хүчилтерегчийн (2) атомыг чөлөөлдөг.



Энэ чөлөөлөгдсөн хүчилтерегчийн атом нь туривдагч бодис M-ийн тусламжтай агаар дахь хүчилтерегчийн молекултай нэгдэж озон үүсгэдэг. Газар орчим үүссэн озон нь хүний эрүүл мэнд ялангуяа хүний амьстгалын зам, уушгийг гэмтээх, астам үүсэх ургамал бүрхэвчийг гэмтээх нөлөөтэй байдаг.

Нэгэнт агаарт үүссэн озон эргээд азотын исэл (NO)-тэй урвалд орж дахин азотын давхар ислийг бий болгодог. O₃+ NO → NO₂ + O₂ (4) Иймээс азотын давхар исэл нь агаар мандалд явагддаг фотохимийн урвалд гол үүрэг гүйцэтгэдэг.

² Байгаль орчны төлөв байдлын судалгаа 2022 он

³ “Оюун шим мандал” ХХК Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт ажлын тайлан 2022 он



Тоос тоосонцор: Хот суурин газрын агаарт янз бүрийн эх үүсвэрээс үүдэлтэй тоос тоосонцор байх ба тэдгээрийн аэродимик хэмжээ, химиин найрлага, усанд уусах шинж чанар, гэрлийг шингээх, ойлгох, орчны агаар дахь агууламж зэргээс хамаараад хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд сөрөг нелөөлөл үзүүлж байдаг. Агаар мандалд 0.001-100 микрометр ширхэглэлийн хэмжээтэй тоос тоосонцор түгээмэл илрэх ба ширхэглэлийн хэмжээ (аэродинамик диаметр)-нээс хамаарсан агууламжийн тархалтын гол онцлогийг Зураг 24-д үзүүлэв.

Нүүрстөрөгчийн дутуу исэл: Нүүрстөрөгчийн дутуу исэл (CO) нь ихэнхдээ шаталтын процессын завсрлын бүтээгдэхүүн, ялангуяа стехиометрийн шаталтын нөхцөлд үүсдэг. Гэсэн хэдий ч шаталтаас ялгардаг CO-ийн хамаарал нь CO₂-тай харьцуулахад тийм ч өндөр биш юм. Дутуу шаталт явагдахад CO-ийн ялгаруулалт ихээхэн хэмжээгээр үүсч болно.

Бусад агаар бохирдуулагч бодисууд: Дулаан үйлдвэрлэхэд түлшний хими физик шинж чанараас шалтгаалан түгээмэл бохирдуулагчдаас гадна метан агуулаагүй дэгдэмхий ууршигтгай нэгдлүүд (NMVOC),аммиак,бензолийн нэгдлүүд болон хүнд металлууд(хар тугалга,мөнгөн ус г.м) бага хэмжээгээр орчны агаарт ялгардаг.

Дулааны цахилгаан станцын агаар бохирдуулагч эх үүсвэрүүд:

ДЦС-ын нүүрс хүлээни авах ил талбайн үйл ажиллагаанаас агаарт хаягдах бодисын ялгарлын тооцоолол

Нүүрс хүлээж авах талбайд нүүрс буулгах: Адуунчулууны уурхайгаас олборлосон нүүрсийг хүнд даацын автосамсалаар тээвэрлэн ирж хангамжийн талбайд буулгана.Материалыг асахаа процессоос үүдэлтэй үүсэх тоосны ялгарлын фактор тодорхой хэмжээний материалыг шилжүүлэхэд үүсэх тоосны хэмжээгээр илэрхийлэгдэх ба дараах эмпирек томьёог ашиглан тооцоолдог. Нүүрс асахад үүсэх тоосжилтыг доорх томьёогоор тоосны эх үүсвэрийн ялгаралыг тооцоолох бөгөөд материалын шинж чанараасаа хамаарч өөр өөр утгатай тооцоологддог.

$$EF = (0.0018) * \left(\frac{S}{5}\right) * (H/5)) / ((\frac{M}{2})^2 * \left(\frac{V}{6}\right)^{\frac{1}{3}}) \quad (6)$$

Энд:

EF = Ялгарлын фактор

к = тоосонцрын ширхэгээс хамаарсан үржвэр (TSP-0.73.PM10-0.36,PM2.5-0.036)

s = материалын шаварлагийн агуулаж

U = жилийн салхины дундаж хурд (5 м/сек)

H = материалыг асгаж буй өндөр

M = материалийн чийгийн агууламж (%) (1-2)

V = материал тээвэрлэж буй тээврийн хэрэгсэл,төхөөрөмжийн багтаамж , м³

ТЭЗҮ-д тусгасан автомашины техникийн тодорхойлтоор

Xуснэгт 17 Гаагийн талбай дээр нүүрс буулгах ачихад ялгараах тоосны хаягдлын фактор

Эх үүсвэр	EF(TSP) кг/тн	EF(PM10)	EF(PM2.5)
Хангамжийн талбайд талбайд нүүрс буулгах	0.079	0.0037	0.0006

Нүүрс буулгах талбай дээр нүүрс буулгах дахиж ачихад жилд ялгараах үед ялгараах тоосны хэмжээг дараах томьёогоор тооцоолно.

E=EF*AD (2)

E = Ялгарлын хэмжээ (тн/жил)



EF= Хаягдлын фактор (кг/тн) (Хүснэгт 1).

AD=Жилд буулгах түлшний хэмжээ (1,026,852 тн).

Төслийн зүгээс гаалийн нүүрсний талбайд нүүрс буулгахад ялгараах тоосыг 10 метр өндөр хашаа бариж бууруулах арга хэмжээг авсан. Бууруулах технологийн чадамжийг 30 % тооцож ялгарлын хэмжээг доор *Хүснэгт 18* тооцолов.

Хүснэгт 18. Хангамжийн талбайд нүүрс буулгахад ялгараах тоосны хэмжээ

Эх үүсвэрийн төрөл	E(TSP)	E(PM10)	E(PM2.5)
	тн/ жил		
Талбайд нүүрс буулгах	142.2	6.66	1.08

Нүүрс буулгах талбайд бульдозер ажиллах үед ялгараах тоосны хаягдлын хэмжээ:

Талбайд буулгасан нүүрсийг овоолго үүсгэн хураахад бульдозер ашиглана. Бульдозерийн үйл ажиллагаанаас ялгараах тоосны ялгарлын хэмжээг тооцоолоход доорх эмпирек томьёо ашиглан тооцолов.

$$EF(TSP) = 35.6 \frac{s^{1.2}}{M^{1.3}} \quad (3) \quad EF(PM10) = 6.33 \frac{s^{1.5}}{M^{1.4}} \quad (4)$$

Энд:

EF= Бульдозерын цагт ажиллахад ялгарлын фактор (кг/ажиллах цаг)

s = материалын шаварлагийн агуулаж (7%)

M = материалийн чийгийн агууламж (3%)

Цагт бульдозер нэг цагт овоолго дээр ажиллахад үүсэх эх үүсвэрийн ялгарлын фактор ашиглан жилд овоолгод хүдэр овоолоход үүсэх тоосны хэмжээг дараах томьёогоор тооцоолно.

E=EF*AD (5)

E-Ялгарлын хэмжээ (тн/жил) Хүснэгт

EF-Ялгарлын фактор (кг/тн)

AD- Овоолгод ажиллах бульдозерын цагийн хэмжээ (340 цаг)

Хүснэгт 19. Бульдозерын нэг цагт болон жилийн хугацаанд ажиллах үед ялгараах тоосны хаягдлын хэмжээ

Эх үүсвэр	EF(TSP)	EF(PM10)	E(TSP)	E(PM10)
	кг/цаг		тн/жил	
Бульдозер	30.3	7.43	484.92	118.96

Дорнод ДЦС-ын түлшний хэрэглээнээс орчны агаарт хаягдах агаар бохирдуулагч бодисын эх үүсвэрийн тооцоо:⁴

Дорнод дулааны 36МВт хуучин станц жилд дундажаар 500552, төлөвлөж байгаа 50 МВт станц жилд 526300 тн Адуунчулууны уурхайн нүүрс хэрэглэхээр төлөвлөсөн. Түгээмэл бохирдуулагчийн ялгарлын хэмжээг дараах байдлаар тооцов.

⁴ Ялгарлын фактор ашигласан эх сурвалжс. Агаар бохирдуулагч бодисын хаягдлын тооллого хийх аргачлал (2019 он)-Хүснэгт 3.1.2.2 ЕМЕР/ЕЕА-ын цахилгаан станцын зуухны хаягдлын фактор,Хүснэгт 3.1.2.3 АР-42-ын цахилгаан станцын зуухны хаягдлын фактор



$$E_i = AD \times EF_i \times \left(1 - \frac{CE}{100}\right) \quad (7)$$

E= i-Агаар бохирдуулах бодисын ялгарлын хэмжээ, тонн

AD= Хэрэглэх түвшний хэмжээ (117,360 тн/жил)

EF Я/К (кг /тонн) 1 тонн түлш шатаахад үүсэх бохирдуулагчийн ялгарлын хэмжээ буюу хаягдлын фактор хүснэгт-20

CE(Control Efficiency) –Бохирдуулагч бодисыг бууруулах технологийн чадамж (Төсөлд РМ тоосонцрыг бууруулахад уutan фильтр ашиглахаар төлөвлөсөн бөгөөд 95-98% бууруулах чадамжтай)

Эндээс хэрэв нүүрсэнд агуулагдах хүхрийн агууламж болон хүхэргүйжүүлэх технологийн төхөөрөмжийн SO2-ыг зайлцуулах ашигт үйлийн коэффициентын талаарх мэдээллийг олох боломжтой тохиолдолд SO2-ын ялгарлын хэмжээг дараах томьёогоор тооцоолно. Адуунчулууны уурхайн нүүрсний чанарын үзүүлэлтийг ашиглав:

$$\text{Emissions} = \sum FC_i \times \frac{S_i}{100} \times \frac{64}{32} \times \left(1 - \frac{A_i}{100}\right) \times \left(1 - \frac{E}{100}\right) \quad (8)$$

Үүнд:

Emissions: SO2-ын ялгарлын хэмжээ, тонн

FC_i: Нүүрс “i”-ын зарцуулалтын хэмжээ,

S_i: Нүүрс “i”-д агуулагдах хүхрийн хэмжээ, (0.9 %)

A_i: Нүүрс “i”-д агуулагдах үнслэг, 9 %

E: Хүхэргүйжүүлэх төхөөрөмжийн SO2 зайлцуулах AYK, 90%

“E” нь 0-оос 100 хүртэлх тоон утга байх бөгөөд хэрвээ хүхэргүйжүүлэх төхөөрөмж суурилуулаагүй тохиолдолд “E”-г “0” гэж үзнэ. Төслийн зүгээс шохойн чулууг хамт шатааж хүхэрлэг хийн хэмжээг 90-95 % бууруулах технологитой байна.

Хүснэгт 20 ЕМЕР/ЕЕА-ын цахилгаан станцын зуухны ялгарлын фактор

Нүүрсний төрөл	Технологи	SO2	NOx	TSP	PM10	PM2.5	CO
Хүрэн нүүрс (brown coal)	Үнсийг норгон хөргөж хаядаг зуух	1680	247	11.7	7.9	3.2	8.7
	Буцламтгай үет шаталттай зуух	1680	60	10.2	6.9	2.8	13
Сайн чанарын нүүрс (Hard coal)	Үнсийг хүйтэн агаараар хөргөж хаядаг зуух	820	209	11.4	7.7	3.4	8.7
	Буцламтгай үет шаталттай зуух	820	82.5	8.4	7.7	5.2	313

Нэгж: гр/ГЖ; (зөвхөн Hg: мг/ГЖ)

Эх сурвалж: ЕМЕР/ЕЕА air pollutant emission inventory guidebook 2016-ын 1.A.1-ын Table 3-9, Table 3-10, Table 3-15, Table 3-16

Я/К-ийг хүндийн нэгжид шилжүүлэхэд тухайн ДЦС-ын хэрэглэдэг нүүрсний илчлэгийн хэмжээг ашиглаж хувиргадаг.

ЕМЕР/ЕЕА гарын авлагад “Hard coal” -д коксжсон нүүрс (coking coal), чулуун нүүрс (bituminous coal & sub-bituminous coal)-ийг, “Brown coal” нь хүрэн нүүрс (lignite), шатдаг занар (oil shale), хүлэр (peat)-ийг оруулсан байдаг.

Ялгарлын коэффициент (Я/К)-ийн нэгжийн шилжүүлэг



ЕМЕР/EEA Guideline-ын түлшний шаталтын Я/К нь илчлэгийн нэгж (гр/ГЖ зэрэг) байна. Илчлэгийн хэмжээ нь түлшний төрөл болон тухайн түлшний чанараас хамаарч өөр байдаг учраас Я/К-ийг хүндийн нэгжид шилжүүлэх шаардлагатай байдаг.

$$EF \left(\frac{\text{kg}}{\text{ton}} \right) = EF \left(\frac{\text{g}}{\text{GJ}} \right) \times 4186.8 \left(\frac{\text{J}}{\text{kcal}} \right) \times CV \left(\frac{\text{kcal}}{\text{kg}} \right) \times 10^{-9} \left(\frac{\text{J}}{\text{GJ}} \right) \times 10^{-3} \left(\frac{\text{kg}}{\text{g}} \right) \times 10^3 \left(\frac{\text{kg}}{\text{ton}} \right)$$

Томьёоны CV нь түлшний илчлэгийн хэмжээ юм.

Адуунчулууны уурхайн нүүрсний илчлэг дундажаар 2350ккал/кг

Төслөөс өгөгдсөн мэдээлэл болон эх үүсвэрийн тооцооллын аргачлал болон буцламтгай үе шатлалтай болон үnsийг норгон хөргөж хаядаг зуухны ялгарлын факторын утгыг ашиглан дулааны станцын нүүрсний хэрэглээнээс яндангаар гадаад орчинд хаягдах агаар бохирдуулагчдын ялгарлын хэмжээг жилээр *Xүснэгт 21* тооцов.

Xүснэгт 21 Дулааны станц ялгарах агаар бохирдуулагч бодисын ялгарын хэмжээ, тн/жил

	SO2	NOx	TSP	PM10	PM2.5	CO
Дулааны станц	33.88	211.25	35.91	24.29	9.86	45.77
36 МВт хуучин ДЦС	927	1218	57.7	39	15.8	42.9
50 МВт төлөвлөсөн ДЦС	974	223	37.8	25.6	10.4	48.3

AERMOD VIEW 8.9.0 (USEPA) загварын загварчлах зарчим:


AERMOD VIEW 8.9.0 (USEPA) буюу Америкийн хүрээлэн байгаа орчныг хамгаалах агентлагын(EPA),Америкийн цаг уурын нийгэмлэг (AMS) аргачлалын дагуу бүтээгдсэн загварыг ашиглав.Тус загвар нь гаусын тархалтын тэгшитгэл дээр үндэслэсэн загвар болно.Загварын оролтын мэдээнд цаг уурын мэдээлэл,газрын гадаргын топографийн мэдээлэл,эх үүсвэрийн мэдээлэл орно.Тус модель нь гурван томоохон хэсгээс бүрдэнэ.Агаарын урсгалын загварчилдаг AERMET,Топографын өгөдөл боловсруулж тооцооллын тэгшитгэл бодох торыг буулгах AERMAP,Эх үүсвэрийг тооцоолон загварыг бодох AERMOD гэсэн хэсгээс бүрдэнэ. AERMOD загвар нь хөдөөгийн болон хот суурин газар, тэгш, нарийн төвөгтэй газар нутаг, гадаргуугийн болон өндөрлөгт хувилбарууд, олон тооны эх үүсвэрүүдээс (үүнд цэг, талбай, эзэлхүүний эх үүсвэр) үүсэх агаар бохирдуулагчыг тооцоолох чадвартай . AERMOD бол тогтмол төлвийн загвар юм. Тогтвортой хилийн давхаргад (SBL) дээр агууламжийн тархалт нь Гауссын босоо болон хэвтээ тэнхлэгт байрлана. Бүрхэгдсэн давхаргын (CBL) түвшинд хэвтээ тархалтыг Гаусс гэж үздэг боловч босоо тархалт нь хоёр-Гауссын магадлалын нягтын функцийн тодорхойлогдоно.AERMOD нь өндрийг тогтвортой түвшинд нэвтрэн оруулдаг ямар нэгэн бөөгнөрсөн массыг харуулж, шаардлагатай тохиолдолд хил хязгаарын давхаргыг дахин оруулах боломжийг олгодог.Харьцангуй хялбар аргыг ашиглан нарийн төвөгтэй газар нутаг дахь салхины урсгал буюу оронг (wind field) загварчилдаг. AERMOD-ийн тархалтын загварчлалыг бий болгох томоохон сайжруулалтуудын нэг нь гадаргуугийн болон холимог давхаргын масштабаар дамжуулан PBL-ийг тодорхойлох чадвар юм. AERMOD нь ижил төстэй (массив) харилцан хамаарлаар хэмжигдэхүүнийг хэмжих болон экстраполяцид суурилсан шаардлагатай цаг уурын хувьсах хэмжигдэхүүний босоо чиглэлийг тодорхойлдог.Салхины хурд, салхины чиглэл, хуйлралт, температур ба градиентийн градиентуудын босоо үзүүлэлтүүдийг цаг уурын бүх ажиглалтыг ашиглан тооцоолно,.AERMOD нь хамгийн оптималь хувилбараар ажиллахад зориулагдсан. Загварчлах систем нь нэг үндсэн програм (AERMOD), хоёр процессор (AERMET болон AERMAP) -ээс бүрддэг. AERMET-ийн гол зорилго нь AERMOD-ийн ашиглах хилийн давхаргын параметрийг тооцоолох явдал юм. Цаг уурын INTERFACE, AERMOD-ийн дотор байдаг эдгээр цаг уурын хувьсагчийн профайлыг бий болгохын тулд эдгээр параметрийг ашигладаг.Үүнээс гадна, AERMET цаг уурын ажиглалтыг AERMOD-рүү дамжуулдаг.



Тархалтын загварын үр дүн:

Тархалтын загвараар дулааны станцаас ялгарах агаар бохирдуулагчийн ялгаралын орон зайн тархалтаар хүхэрлэг хий, азотын ислүүд, нүүрстөрөгчийн дутуу исэл болон PM2.5 тоосонцор гэсэн түгээмэл агаар бохирдуулагч бодисоор тооцооллоо.


Хүхэрлэг хийн: Хүхэрлэг хийн хоногийн дундаж агууламжын тархалтын загварын үр дүнгээс үзэхэд орчны агаар дахь хүхэрлэг хийн жилийн дундаж агууламжийг хамгийн ихдээ агууламжийг $1.6 \text{ мкг}/\text{m}^3$ нэмэгдүүлж байна. (Зураг 21).



Зураг 21 Дулааны станцаас ялгарах хүхэрлэг хийн тархалт (жилийн дундаж), $\text{мкг}/\text{m}^3$


ДЦС-ын яндангаар хаягдах хүхэрлэг хий нь төвийн барилгжсан бүсэд маш бага нөлөөлөл үзүүлж байгаа ч 1 дүгээр багийн суурьшлын бүсэд голлох нөлөөллийг үзүүлж байна.

Азотын ислүүд NOx: Азотын ислүүд нь өндөр температурт шаталтаас дулаан шингээлтийн урвалын дунд үүсдэг. Мөн түлшэнд агуулагдах азот агуулсан нэгдэлээс шаталтаар үүснэ. Азотын ислийн жилийн дундаж агууламжыг $0.5-1 \text{ мкг}/\text{m}^3$ нэмэгдүүлж байна (Зураг 22).



Зураг 22 Дулааны станцаас ялгарах азотын истүүдийн тархалт (жилийн дундаж), $\mu\text{g}/\text{m}^3$


Нүүрстөрөгчийн дутуу исэл: Нүүрстөрөгчийн дутуу ислийн нөлөөлийн хэмжээ бага буюу орчны агаар дахь түвшинийг нэмэгдүүлэх хэмжээ нь хамгийн ихдээ $0.5\text{-}1 \mu\text{g}/\text{m}^3$ байна. Монгол улсын агаарын чанарын стандарт MNS4585:2016-д гадаад орчны агаар дахь нүүрстөрөгчийн дутуу ислийн 8 цагийн дундаж зөвшөөрөгдхөд дээд хэмжээг $10000\mu\text{g}/\text{m}^3$ гэж заасан байдаг ба энэ хэмжээтэй харьцуулахад нүүрстөрөгчийн дутуу ислийн бохирдуулагч нь маш бага ба тус стандартад заасан зөвшөөрөгдхөд дээд хэмжээний хязгаарт байх боломжтой байна (Зураг 23).




Зураг 23 Дулааны станцаас ялгарах нүүрстөрөгчийн дутуу ислийн тархалт (8 цаг дундаж), $\mu\text{g}/\text{m}^3$



Тоосонцор: Шаталтаас үүсэх гол бохирдуулагчдын нэг нь хатуу тоос тоосонцор бөгөөд хүний эрүүл мэнд байгаль орчин үзүүлэх нолөөллийг харгалzan PM2.5 тоосонцрыг сонгон тооцоолсон. Тооцооллын дунгээс харахад зуухнаас үүсэх тоос тоосонцор хамгийн ихдээ орчны агаар дахь PM2.5 тоосонцрын жилийн дундаж агууламжын хэмжээг $0.016 \text{ мкг}/\text{м}^3$ нэмэгдүүлэхээр байна (Зураг 24).





Зураг 26 Нүүрс буулгах талбайн үйл ажиллагаанаас ялгарах PM10 тоосонцрын тархалт (жилийн дундаж)

Үнсэн сангийн салхины элэгдэл. ДЦС-ын үнсэн сангийн талбайн 3-р хэсгийг одоогоор ашиглаж байна. Үнсэн санд хаягдсан үнснээс орчны агаарт тоос ялгарах үүсэх тоосны хэмжээг дараах томъёог ашиглан тооцоолох боломжтой.

$$EF = k \sum_{i=1}^N P_i \quad (1)$$

$$P = 58(u^* - u_t^*)^2 + 25(u^* - u_t^*)(2)$$

$$u(z) = \frac{u^*}{0.4} \ln \frac{z}{z_0} \quad (3)$$

Энд: EF = тоос тоосонцорын ялгарлын фактор (гр/метр²/жил)

k = тоосонцрын ширхэгийн диаметрээс хамаарсан үржвэр
(TSP=1, PM10=0.5, PM10=0.075)

u = 10 м өндөр дэхь салхины хурд

u* = салхины үрэлтийн хурд (м/с)

u_t^{*} = тоосжилт үүсгэх салхины үрэлтийн хурдны босго утга (0,54 м/с)

Z = салхины хурд хэмжээн өндөр (10м)

z₀ = гадаргын атираашил (Үнс 0.3)

Хүснэгт 4. Үнсэн сангаас салхины элэгдлээр үүсэх тоосны ялгарлын фактор болон хэмжээ


Эх үүсвэр	Үнсэн сангийн хаягдлын фактор			Үнсэн сангаас салхины элэгдлээр ялгарах тоосны хэмжээ, тн/жил		
	гр/м ² /жил	EF(TSP)	EF(PM10)	EF(PM2.5)	EF(TSP)	EF(PM10)
Үнсэн сан	5448.14	2724.07	408.61	232.59	116.29	17.44

Үнсэн сангийн салхины элэгдэл. Үнсэн санд агуулагдах үнснээс салхины элэгдлээр орчны агаарт ялгарах нийт тоосны дундаж агууламж үнсэн сангийн гадна буюу нийт тоосны жилийн дундажаас давах хэсгээр дундажилсан агууламж 197 мкг/м³ буюу жилийн хүлцэх хэмжээ 100 мкг/м³ 2 дахин, PM10 тоосонцор үнсэн сангийн гадна стандарттаас давах хэсэгт 98 мкг/м³ буюу жилийн хүлцэх хэмжээ 100 мкг/м³ 2 мөн 2 дахин давж болзошгүй байна (Зураг 27,28). Үнсэн сангийн агаарын чанарт нөлөөлөх бүсийн хэмжээ үнсэн сан болон ойр орчмын 50 га талбайг хамарч, эх үүсвэрээс 400-500 метр орчны агаарын чанарт сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй (Зураг 29).






Зураг 27 Үнсэн сангас салхины элэгдлээр ялгарах TSP тоосонцрын тархалт (жилийн дундаж)



Зураг 28 Үнсэн сангас салхины элэгдлээр ялгарах PM10 тоосонцрын тархалт (жилийн дундаж)



Зураг 29 Уисэн сангаас орчны агаарын чанарт нөлөөллох бусийн хүрээ

Гол сөрөг нөлөөлөл:

- ✓ Барилга байгууламжийг барих үйл ажиллагаатай холбоотой хөрс хуулалтаас үүсэх тоосжилт болон тээвэрлэлтийн үед үүсэх тоосжилт
- ✓ Төслийн хүрээнд ашиглагдах тээврийн хэрэгслүүдийг шатахуунаар цэнэглэх үед мөн мотор эд ангиас агаар бохирдуулах бодис уурших, тээврийн хэрэгслийн яндангаас агаар бохирдуулагч бодис ялгарах /нүүрстөрөгчийн исэл, хүхэрлэг хий, азотын исэл, нүүрстөрөгчийн давхар исэл, тортог /
- ✓ Төслийн барилга байгууламж барих болон үйл ажиллагааны үе шат мөн тээврийн хэрэгслээс үүсэх дуу шуугиан
- ✓ Нүүрсний шаталтаас үүсэх хийн хаягдал
- ✓ Уисэн сангийн талбайгаас босох тоос

Болзошигүй нөлөөлөл:

- ✓ Төслийн үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдалыг удаан хугацаанд буруу хадгалснаас тухайн хаягдаас нүүрсхүчлийн хий агаарт хаягдах
- ✓ Хадгалалтын горим зөрчигдсөний улмаас химийн нэгдлүүд дулааны задралд орж хий байдалтай нэгдлүүд үүсэх



Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг магадлан жагсаах аргыг ашиглан гүйцэтгэлээ.

Хүснэгт 22 Магадлан жагсаалт 1

Аргачлал	Шууд	Шууд бус	Нөлөөллийн эрчим	Үргэлжлэх хугацаа	Хамрах хүрээ	Магадлал	Нөлөөллийн зэрэг
Нөлөөллийн эх үүсвэр							
Гол сөрөг нөлөөлөл							
Барилга байгууламж барих үйл ажиллагаа	+		10	2	2	5	M
Тээврийн хэрэгсэл хөдөлгөөн	+		8	2	2	4	M
Дуу шуугиан	+		8	2	1	5	M
Станцын яндангаас гараах утаа	+		10	2	2	4	M
Үнсэн сангаас үүсэх тоос	+		10	2	2	4	M
Болзошгүй сөрөг нөлөөлөл							
Хог хаягдал		+	6	1	1	3	L
Химиин бодисын аюулгүй ажиллагаа		+	4	1	1	3	L
Нөлөөллийн зэрэглэл		Нөлөөллийн эрчим		Хамрах хүрээ		Магадлал	
>75	8	Их	Бүс нутгийн хэмжээнд	3	Өндөр	4	
30-75	6	Дунд	Орон нутгийн хэмжээнд	2	Дунд	3	
<30	4	Бага	Тухайн орчны хэмжээнд	1	Бага	2	
Эсрэг	2	Маш бага					

Хэсгийн дүгнэлт:


Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлэх гол нөлөөлүүд нь барилга байгууламж барих үйл явц, тээврийн хэрэгслүүд, станцын яндангаас гараах утааны тархалт, үнсэн сангаас үүсэх тоосжилтын үйл ажиллагаатай шууд хамааралтай.

Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт нөлөөллөх дээрх гол сөрөг нөлөөллүүдийг магадлан жагсааж, төслийн үйл ажиллагааны үе шатууд дахь тэдгээрийн эрчим, үргэлжлэх хугацааг тодорхойлж бол нөлөөллүүдийн 42% маш их, 28% нь дунд, 28% нь бага эрчимшилтэй, үргэлжлэх хугацааны хувьд богино хугацааны /0-5 жил/ нөлөөлөл байна. Ерөнхийд нь дүгнэвэл төслийн үйл ажиллагаанаас тухайн нутгийн агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл ДУНД гэсэн ангилалд хамарагдаж байна.

2.4 Хөрсон бүрхэвчинд үзүүлэх гол болон болзошгүй нөлөөлөл

Өргөтгөл хийх талбайд барилга байгууламжуудыг барих явцад хөндөгдөх 36 га талбайгаас шимт хөрс хуулагдана. Дулааны цахилгаан станцын ашиглалтын нийт талбайд элсэн хүрэн хөрс, голын татмын хөрс тархсан (Зураг 30).





Зураг 30 Хөрсон бүрхэвч

Төслийн талбайд манай компаниййн мэргэжилтнүүд хээрийн судалгааг 2022 оны 04 сарын 11 өдөр урьдчилан төлөвлөсөн зураглал маршрутын дагуу явж нийт хөрсний 8 ш хагас зүсэлт хийж хөрсний морфологи бичиглэлийг хээрийн нөхцөлд тодорхойлж, лабораторийн задлан шинжилгээнд зориулан дээж аван “Нарт шуүн консалтинг” ХХК -ны хөрс судлалын итгэмжлэгдсэн лабораторид шинжилгээ хийлгэсэн⁵. /Шинжилгээний дунг тайланд хавсаргав./

Хөрсний механик бүрэлдэхүүн:

Хөрсний механик бүрэлдэхүүний хэмжээг sp1, sp3 дээжүүдэд хийсэн бөгөөд хөрсний дээжүүдэд хийсэн лабораторийн шинжилгээнээс харакад элсэн хөрс (1-0.25мм) 25.3-44.3%, дунд (0.25-0.05мм) 36.7-54.6%, хөнгөн элсэнцэр (0.05-0.01мм) 1.5-3.2%, , элсэн хөрс (0.01-0.005мм) 2.6-4.7%, , элсэн хөрс ($0<0.001\text{мм}$) 6.9-9.9 %, хөнгөн элсэнцэр ($0<0.01\text{мм}$) 11.2-17.2% агуулагдаж байна.

Хөрсний хими шинж чанар:

Хөрсний үржил шимт ўе давхаргын ялзмагийн агууламжийн утга 1.28-2.78%, хөрсний урвалын орчны утга pH-8.46 буюу шүлтлэг, 100 г хөрсөнд агуулагдах хедөлгөөнд фосфорын утга нь 5-15 мг, солилцох калигийн утга 2.9-4.9 мг, хөрсний цахилгаан дамжуулах шинж чанарын утга 0.084-0.145 EC_{2,5} D/m байна. Хөрсний химийн шинжилгээнээс үзэхэд үржил шимийн ерөнхий түвшин бага, нөлөөлөлд өртсөн төлөвтэй байна.

Хөрсөн дэх хүнд металын агууламжийн өнөөгийн байдлыг тодорхойлох зорилгоор цахилгаан станцын талбайн 7 цэгт хөрсний өнгөн хэсгээс авсан. Хөрсний хүнд металын дээжүүдийг лабораторид өгч нийт 6 элементийг шинжлүүлэн MNS 5850:2019 (Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ) стандарттай харьцуулав.

Шинжилгээний үр дүнгээс хараад sp4 дээжинд Хромын хэмжээ, sp6, sp7, sp8 дугаартай дээжүүдэд Хар туталгын хэмжээ зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс давсан үзүүлэлттэй гарсан байна.

⁵ Байгаль орчны толов байдлын судалгаа 2022 он.



Хуснэгт 23 Хөрсний шинжилгээ

Дээж авсан цэгүүд	Дээж авсан гүн	Хөрсний хүн металлын агууламж, мг/кг					
		Cr	Pb	Cd	Zn	Cu	Ni
Sp 1	0-10	44.5	40.9	0.0	16.1	14.4	22.2
Sp 3	0-10	51.9	38.7	0.0	46.3	14.7	12.7
Sp 4	0-10	66.7	50.0	0.0	93.4	25.4	5.1
Sp 5	0-10	0.0	50.0	0.0	15.5	16.7	7.6
Sp 6	0-10	14.8	52.3	0.0	4.3	16.0	3.8
Sp 7 агуулах	0-10	29.7	72.8	0.0	91.3	40.7	20.9
Sp 8	0-10	37.1	81.8	0.0	36.2	29.4	29.8
Зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850:2019							
Элсэрхэг хөрс		60	50	1	100	60	60
Шавранцар хөрс		100	70	1.5	150	80	100
Шаварлаг хөрс		150	100	3	300	100	15

Эх сурвалж: “Нарт шуүн консалтинг” ХХК-ийн хөрсний итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний үр дүн 2022.04.19

“Оюун шим мандал” ХХК-ний гүйцэтгэсэн 2022 оны байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт ажлын тайланаас үзэхэд нийт 10 цэгээс дээж авч магадлан итгэмжлэгдсэн лабораториор шинжилгээ хийлгүүлсэн ба хөрсний хүнд металлын агууламж нь MNS 5850:2008 стандартаас даваагүй байна.⁶

Орчны цацрагийн шинжилгээг нийт 16 цэгт Rados rds-110 маркын дозиметр багажаар мкЗв/цаг гэсэн ижгисээр хэмжилт хийсэн байна. Цацрагийн хэмжилтийн дунгэрээр хорсонд хамгийн их нь 0.19 мкЗв/цаг байгаа нь Монгол улсын байгалийн дундаж дэвсгэр түвшин /0.2 мкЗв/цаг/-д байна.

Гол сөрөг нолоолол:

- ✓ Өргөтгөл хийх талбайд барилга байгууламжийг барих үйл ажиллагаа болон тээвэрлэлтийн үед төслийн талбай болон ойр орчмын хөрсөн бүрхэвч талхлагдах, эвдрэх, олон салаа замууд үүсэх
- ✓ Өргөтгөл хийх 36 га талбайн шимт хөрс хуулагдах

Болзошигүй нолоолол:

- ✓ Төслийн үйл ажиллагааны явцад машин механизмаас мөн хүний санамсаргүй үйл ажиллагаанаас шалтгаалан ямар нэгэн шатах, тослох материал хөрсөнд ил задгай асгарч хөрс бохирдуулах
- ✓ Хог хаягдлын менежментийг хангалтгүй хэрэгжүүлсэн тохиолдолд хатуу шингэн хог хаягдаар хөрс бохирдох
- ✓ Төслийн үйл ажиллагааны явцад салхи ихтэй үед нүүрсний агуулах болон үns хадгалах байгууламжуудаас тоосонцор, нарийн дэгдэмхий үns зөөгдөн газрын гадаргууд унаж хөрсөн дэх хүнд элементийн агууламжийн нэмэгдүүлэх

⁶ “Оюун шим мандал” ХХК Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт ажлын тайлан 2022 он



Төслийн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг магадлан жагсаах аргыг ашиглан гүйцэтгэлээ.

Хүснэгт 24 Магадлан жагсаалт I

Аргачлал	Шууд	Шууд бус	Нөлөөллийн эрчим	Үргэлжлэх хугацаа	Хамрах хүрээ	Магадлал	Нөлөөллийн зэрэг
Нөлөөллийн эх үүсвэр							
Гол сөрөг нөлөөлөл							
Барилга байгууламж барих үйл ажиллагаа	+		10	2	1	5	M
Тээврийн хэрэгсэл хөдөлгөөн	+		8	2	2	4	M
Шимт хөрс хуулагдах	+		8	2	1	5	M
Болзошгүй сөрөг нөлөөлөл							
Хог хаягдал		+	6	2	1	4	M
Шатах тослох материал		+	6	2	1	3	L
Тоос, тоосонцор							
Нөлөөллийн зэрэглэл	Нөлөөллийн эрчим			Хамрах хүрээ		Магадлал	
>75	8	Их	Бүс нутгийн хэмжээнд	3	Ондер	4	
30-75	6	Дунд	Орон нутгийн хэмжээнд	2	Дунд	3	
<30	4	Бага	Тухайн орчны хэмжээнд	1	Бага	2	
Эрэг	2	Маш бага					

Хэсгийн дүгнэлт:

Төслийн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвчинд үзүүлэх гол нөлөөлүүд нь барилга байгууламж барих үйл явц, хог хаягдал, тээврийн хэрэгслүүдийн үйл ажиллагаатай шууд хамааралтай.


Төслийн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвчинд нөлөөллөх дээрх гол сөрөг нөлөөлүүдийг магадлан жагсааж, төслийн үйл ажиллагааны үе шатууд дахь тэдгээрийн эрчим, үргэлжлэх хугацааг тодорхойлбол нөлөөлүүдийн 20% маш их, 40% нь дунд, 40% нь бага эрчимшилтэй, үргэлжлэх хугацааны хувьд богино хугацааны /0-5 жил/ нөлөөлөл байна. Ерөнхийд нь дүгнэвэл төслийн үйл ажиллагаанаас тухайн нутгийн хөрсөн бүрхэвчинд үзүүлэх нөлөөлөл **ДҮНД** гэсэн ангилалд хамарагдаж байна.

2.5 Ургамлан нөмрөгт үзүүлэх гол болон болзошгүй нөлөөлөл

Төслийн талбай нь суурьшлын бүсэд байрлах ба үйл ажиллагаа явагдаад олон жил болсон, бүхэлдээ техникийн хүчин зүйлийн нөлөөнд өртсөн төдийгүй уг талбайд барилга байгууламж баригдан, ашиглагдаж байгаа учир цөөн зүйлийг ургамал бүртгэв. Ургамалжилтын судалгаагаар нийт 9 овог 17 төрөлд хамаарах 23 зүйл гуурст дээд ургамал бүртгэгдсэн. Судалгаагаар тэмдэглэгдсэн ургамлын зүйлүүдийг овгийн түвшинд авч үзвэл үтэн (Poaceae), лууль (Chenopodiaceae), нийлмэл цэцэгтэн (Asteraceae), буурцагтан (Fabaceae)-ны овгийн ургамлууд зонхиilon тархсан байна. Хээрийн судалгааны явцад 3 цэгт ургамлан бичиглэл хийсэн бөгөөд ургамалжилтын нөхцөл тааруу, ургамлан бүрхэвч 30-60%, хагдан бүрхэвч 10-20%, халцгай газар 20-40%-ийг эзэлж байна.



Судалгааны талбай нь хүн болоод техникийн нөлөөгөөр ихээхэн эвдэрч доройтсон байна. Мөн ургамлын бүрхэц сийрэгдүү (30-40%), ургамлын зүйлүүдийн арви таруу (*Sp*); бэлчээрийн доройтлыг илэрхийлэгч ургамлуудаас Шүлхий шарилж (*Artemisia pectinata*) элбэг (*Cop2*) тархацтай буюу зонхиlj; Ширэг улалж (*Carex duriuscula*) таруу арвитай (*Sp*) ургасан байна.⁷



Зураг 31 Ураглан номрөг

Гол сорог нөлөөлөл:

- ✓ Өргөтгөлийн талбайд барилга байгууламжуудыг барих үйл явцад түүний орчмын талбайн ураглан номрөг талхлагдах, устах
- ✓ Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний улмаас олон салаа замууд үүсэж ураглан номрөг талхлагдах
- ✓ Төслийн үйл ажиллагаанаас үүсэх хатуу, шингэн хог хаягдалын нөлөөгөөр ураглан номрөг хордох, устах

Болзошгүй сорог нөлөөлөл:

- ✓ Үнсэн сангаас үүсэх тоосжилтоос үүдэн ураглан номрөгийн ургах орчин, физиологийн процессууд алдагдаж, доройтож болзошгүй юм.
- ✓ Хуурайшилт ихтэй уед ажилчдын анхаарал болгоомжгүй байдлаас хээрийн түймэр гарч болзошгүй.

⁷ Байгаль орчны төлөв байдлын судалгаа 2022 он



Төслийн үйл ажиллагаанаас ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг магадлан жагсаах аргыг ашиглан гүйцэтгэлээ.

Хүснэгт 25 Магадлан жагсаалт 2

Аргачлал	Шууд	Шууд	Нөлөөллийн	Үргэлжлэх	Хамрах	Магадлал	Нөлөөллийн
Нөлөөллийн		бус	эрчим	хугацаа	хүрээ		зэрэг
Гол сөрөг нөлөөлөл							
Барилга барих үйл ажиллагаа	+		8	2	1	5	M
Тээврийн хэрэгсэл хөдөлгөөн	+		6	2	2	4	M
Хог хаягдал	+		6	2	1	4	M
Болзошгүй сөрөг нөлөөлөл							
Тоосжилт		+	6	2	1	3	L
Хээрийн түймэр		+	4	1	2	2	L
Нөлөөллийн зэрэглэл	Нөлөөллийн эрчим		Хамрах хүрээ		Магадлал		
>75	8	Их	Бүс нутгийн хэмжээнд	3	Өндөр	4	
30-75	6	Дунд	Орон нутгийн хэмжээнд	2	Дунд	3	
<30	4	Бага	Тухайн орчны хэмжээнд	1	Бага	2	
Эрэг	2	Маш бага					

Хэсгийн дүгнэлт:

Төслийн үйл ажиллагаанаас ургамлан нөмрөгт үзүүлэх гол нөлөөллүүд нь барилга байгууламж, дэд бүтэц барих үйл явц, хог хаягдал, тээврийн хэрэгслүүдийн үйл ажиллагаатай шууд хамааралтай.

Төслийн үйл ажиллагаанаас ургамлан нөмрөгт нөлөөллөх дээрх гол сөрөг нөлөөллүүдийг магадлан жагсааж, төслийн үйл ажиллагааны үе шатууд дахь тэдгээрийн эрчим, үргэлжлэх хугацааг тодорхойлбол нөлөөллүүдийн 33.3% нь их, 50% нь дунд, 16.6% бага эрчимшилтэй, үргэлжлэх хугацааны хувьд 83.3% богино хугацааны, 16.3% түр зуурын нөлөөлөл байна. Ерөнхийд нь дүгнэвэл төслийн үйл ажиллагаанаас тухайн нутгийн ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл **ДҮНД** гэсэн анилалд хамарагдаж байна.

2.6 Амьтны аймагт үзүүлэх гол болон болзошгүй нөлөөлөл

Төслөөс амьтны аймагт үзүүлэх шууд нөлөөлөл байхгүй бөгөөд болзошгүй осол аваарийн үед химиин бодисууд хөрсөнд нэвчиж, ургамалжилтад нөлөөлөл үзүүлэх, бохирдуулах зэрэг байдлаар амьтны аймагт шууд бусаар нөлөөлж болзошгүй.

Гол сөрөг нөлөөлөл:

- ✓ Төслийн төлөвлөлт, тээврийн хэрэгсэлийн хөдөлгөөний улмаас амьтад дайжих, тархалт, байршил өөрчлөгдөх, амьдрах орчин тусгаарлагдана
- ✓ Төслийн үйл ажиллагааны улмаас хээрийн өвсөн тэжээлт амьтдын бэлчээрийн талбай багасна



Болзошгүй сөрөг нөлөөлөл:

- ✓ Төслийн ажилчдын буруутай үйлдэлээс шалтгаалан хууль бус ан агуулрын тоо нэмэгдэж болзошгүй
- ✓ Химийн бодис болон түүхий эдийн хог хаягдааар амьтад хордох
- ✓ Ажлын шаардлагаар ухсан нүх, цооногт хүн, мал, зэрлэг ан амьтан

Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг магадлан жагсаах аргыг ашиглан гүйцэтгэлээ.

Хүснэгт 26 Магадлан жагсаалт 3

Аргачлал	Шууд	Шууд бус	Нөлөөллийн эрчим	Үргэлжлэх хугацаа	Хамрах хүрээ	Магадлал	Нөлөөллийн зэрэг
Нөлөөллийн эх үүсвэр							
Гол сөрөг нөлөөлөл							
Дуу чимээ	+		8	2	1	5	M
Төслийн төлөвлөлт, үйл ажиллагаа	+		6	2	2	5	M
Болзошгүй сөрөг нөлөөлөл							
Төслийн ажилчид		+	4	1	1	3	L
Химийн бодис болон түүхий эдийн хог хаягдал		+	4	1	1	3	L
Нөлөөллийн зэрэглэл		Нөлөөллийн эрчим		Хамрах хүрээ		Магадлал	
>75	8	Их	Бус нутгийн хэмжээнд	3	Өндөр	4	
30-75	6	Дунд	Орон нутгийн хэмжээнд	2	Дунд	3	
<30	4	Бага	Тухайн орчны хэмжээнд	1	Бага	2	
Эрэг	2	Маш бага					

Хэсгийн дүгнэлт:

Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлэх гол нөлөөлүүд нь төслийн үйл ажиллагаанаас үүсэх дуу чимээ, химийн бодис болон түүхий эдийн хог хаягдал, тээврийн хэрэгслүүдийн үйл ажиллагаатай шууд хамаарлтай.

Төслийн үйл ажиллагаанаас төсөл хэрэгжих бус нутгийн амьтны аймагт нөлөөлөх дээрх гол сөрөг нөлөөлүүдийг магадлан жагсааж, төслийн үйл ажиллагааны үе шатууд дахь тэдгээрийн эрчим, үргэлжлэх хугацааг тодорхойлбол нөлөөллүүдийн 25% их, 25% дунд, 50% бага эрчимшилтэй, үргэлжлэх хугацааны хувьд 50% богино хугацааны, 50% түр зуурын нөлөөлөл байна. Ерөнхийд нь дүгнэвэл төслийн үйл ажиллагаанаас тухайн нутгийн амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл **ДУНД** гэсэн ангилалд хамарагдаж байна.



2.7 Гадаргын болон газрын доорх усанд үзүүлэх гол болон болзошгүй нөлөөлөл

Чойбалсангийн 36 МВт хүчин чадалтай ДЦС-ыг 50 МВт-ын шинэ станцаар өргөтгөснөөр цахилгаан эрчим хүч үйлдвэрлэлийн хэмжээ 46.0 хувиар, усны хэрэглээ 45.1 хувиар тус тус нэмэгдэнэ.⁸ Энэ нь усны нөөцөөс ашиглах хэмжээг мөн хувиар ихэсгэх тул усан орчинд үзүүлэх нөлөөг ихэсгэх талтай.

Байгаль орчны төлөв байдлын судалгааны ажлын хүрээнд үнсэн сангийн тунгаасан ус, ундны ус, технологийн ус гэсэн 3 цэгээс дээж авч, гэрэл зургаар баримтжуулан, бичиглэл хийсэн.

Хээрийн судалгааны үед усны температур, цахилгаан дамжуулах чанар, нийт ууссан хатуу бодисын хэмжээг хэмжсэн.

Хүснэгт 27 Хэмжилт хийсэн цэгүүдийн мэдээлэл

№	ХХЦ -ийн байршил	ХХЦ	ХХЦ -ийн мэдээлэл	УШУ	Хээрийн судалгааны үеийн фото зураг
1	48°04'35.10" 114°33'25.82"	Үнсэн сангийн тунгаасан ус	TDS=1458 ppm t°=16.1°C	MNS 4943:2015	
2	46°54'47.6" 116°14'58.2"	Технологийн ус	TDS=333 ppm t°=21.1°C	Усны хүнд металлын шинжилгээ	
3	47°04'51.9" 116°21'03.5"	Ундны ус	TDS=226 ppm t°=11.6°C pH=8.06	Усны ерөнхий шинжилгээн	

Хүснэгтийн тайлбар:

ХХЦ-Хэмжилт хийсэн цэг

УШУ- Усны шинжилгээний үзүүлэлт

Хүснэгт 28 Шинжилгээний дүн 1

№	Усан орчин	Нэгж	MNS 0900:2018	Ундны ус
Хээрийн хэмжилт				
1	Усны хэм, t°	°C	-	
3	TDS	ppm	-	226

⁸ Чойбалсангийн ДЦС-ыг 50МВт-аар өргөтгөх төслийн ТЭЗҮ



№	Усан орчин	Нэгж	MNS 0900:2018	Үндны ус
Физик үзүүлэлт				
1	Өнгө	градус	20.0	өнгөгүй
2	Булингар	NTU	5.0	үгүй
3	Усны орчин, pH		6.5-8.5	8.06
4	Цахилгаан дамжуулах чанар	мСм/см	1.0	-0.411
Химийн үзүүлэлт				
5	Нитрат, NO ₃	мг/л	50.0	2.00
6	Кальци, Ca ₂	мг/л	100.0	44.00
7	Сульфат, SO ₄	мг/л	500.0	1.00
8	Хлор, Cl	мг/л	350.0	78.00
9	Магни, Mg ₂	мг/л	30.0	21.00
10	Нийт хатуулаг, CaCO ₃	мг-экв/л	7.0	3.93
11	Хуурай үлдэгдэл	мг/л	1000.0	164
12	Натри+Кали, Na ⁺ K	мг/л	-	25.0
13	Карбонат, CO ₃	мг/л	-	-
14	Гидрокарбонат, HCO ₃	мг/л	-	168.00
Химийн бүрэлдэхүүнээрээ Гидрокарбонатын анги, кальцийн бүлэг, I төрлийн цэнгэг буюу дунд зэргийн эрдэсжилтэй, бага хатуулагтай ус				

Хүснэгт 29 Шинжилгээний дүн 2

Д/д	Шинжилгээ хийсэн элементүүд	Нэгж	MNS 4943:2015	Үр дүн
1	Усны температур	Т°C	20	-
2	Устөрөгчийн илтгэгч- pH		6-9	9.79
3	Перманганатын исэлдэх	мгО/л	20	4.7
4	Жинлэгдэгч бодис	мг/л	30	50.8
5	Аммонийн азот			4.95
6	Нитритийн азот			0.030
7	Нитратийн азот			0.14
8	Фосфор		1.5	0.004
9	Төмөр /нийт/		1	0.08
10	Нийт азот	мгN/л	15	5.12
11	Цахилгаан дамжуулах чанар	Ms/cm		1458.0

Хүснэгт 30 Шинжилгээний дүн 3

№	Дээж авсан цэгүүд	Cr	Pb	Cd	Zn	Cu	Ni
1	Технологийн ус	0.04	0.05	0.00	0.00	0.00	0.02
	MNS 6148:2010	0.07	0.05	0.003	5.0	1.0	0.1

Тайлбар: Нэгж-мг/л

Лабораторийн шинжилгээний дүнгээр цайны газраас авсан дээж нь Химийн бүрэлдэхүүнээрээ Гидрокарбонатын анги, кальцийн бүлэг, I төрлийн цэнгэг буюу дунд зэргийн эрдэсжилтэй, бага хатуулагтай ус байна. Үнсэн сангийн тунгаасан ус нь MNS 4943:2015 “Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага” стандартай харьцуулахад pH болон жинлэгдэгч бодисын үзүүлэлт давсан ба бусад үзүүлэлт даваагүй байна. Технологийн уснаас авсан дээж нь MNS 6148:2010 стандартгаас давсан үзүүлэлт байхгүй байна.



“Оюун шим мандат” ХХК-ний гүйцэтгэсэн 2022 оны байгаль орчны хяналт шинжилгээний хотолборт ажлын тайлангаас үзэхэд Үнсэн сангаас гарч буй хэсэн, үнсэн сангийн тунгаагдсан ус, үнсэн сангийн ус нь MNS 4943:2015 стандарттай харьцуулахад жинлэгдэгч бодис нь стандарттаас давсан байна. Үндны ус, саам амрагтын газрын үндны ус нь MNS 0900:2018 стандартын ерөнхий шаардлагын дагуу байна. Хэрлэн голын усны шинжилгээний үр дүн нь MNS 4586:1998 стандартын ерөнхий шаардлагын дагуу байна.⁹

Гол сорог нолоолол:


- ✓ ДЦС-ыг өргөтгөснөөр цахилгаан, дулаан үйлдвэрлэл, ажиллах хүний тоо нэмэгдэн ашиглах усны хэмжээ ихсэж газрын доорх усны нөөцөд нөлөөлнө.

36 МВт хүчин чадалтай Чойбалсангийн ДЦС-ын үйлдвэрлэлийн усны нийт хэрэгцээ 2,374,647.48 м³ байна. ДЦС-ыг 50 МВт-аар өргөтгөж 86 МВт болсноор усны хэрэгцээ 3,490,620 м³ болж нэмэгдэхээр урьдчилсан тооцоо гарсан. Одоо ашиглаж байгаа 4 худгаас татах нийт усны хэмжээ шинээр барьж өргөтгөх 50 МВт хүчин чадалтай ДЦС-ын хэрэгцээг бүрэн хангаж чадахгүй тул нэмэлт ус хангамжийн худаг гаргах шаардлагатай. Ингэснээр газрын доорх усны нөөцөд нөлөөлнө.

Болзошгүй сорог нолоолол:

- ✓ Хүрээлэн буй орчинд нийлүүлэх хаягдал ус нь MNS 4943:2015 стандартын шаардлага хангаагүй тохиолдолд Хэрлэн голын усны чанарт нөлөөлж болзошгүй.
- ✓ Өвлийн улиралд эргэлтийн усан сангийн уур ойролцоо газарт цан мөс үүсгэж, хаврын улиралд хайлан Хэрлэн гол руу урсдаг. Эргэлтийн усан сангийн ус нь MNS 4943:2015 стандартын шаардлагад нийцээгүй тохиолдолд Хэрлэн голын усны чанарт нөлөөлж болзошгүй.

Эргэлтийн усан сан нь ДЦС-д эргүүлэн ашиглаж буй усыг шаардлагатай температур хүртэл хөргөх үүрэгтэй. Эргэлтийн усан сангаас ус уурших замаар алдагддаг. Мөн эргэлтийн усан сангийн урд хэсгийн авто зам хүйтний улиралд мөстдөг.



Зураг 32 ДЦС-ын одоо ашиглаж байгаа эргэлтийн усан сан

- ✓ Шинээр барих үнсэн сангийн хаягдал ус нэвчиж газрын доорх усыг бохирдуулж болзошгүй.

⁹ “Оюун шим мандат” ХХК Байгаль орчны хяналт шинжилгээний хотолборт ажлын тайлан 2022 он

Төслийн үйл ажиллагаанаас усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг магадлан жагсаах аргыг ашиглан гүйцэтгэлээ.

Хүснэгт 31 Магадлан жагсаалт 4

Аргачлал Нөлөөллийн эх үүсвэр	Шүү д	Шууд бус	Нөлөөллий н эрчим	Үргэлжлэ х хугацаа	Хамрах хүрээ	Магадлал	Нөлөөллийн зэрэг
Гол сөрөг нөлөөлөл							
Үйл ажиллагаанд ашиглагдах усны хэрэглээ		+		8	2	2	5
Болзошгүй сөрөг нөлөөлөл							
Эргэлтийн усан сан		+		4	1	1	3
Үнсэн сангийн хаягдал ус		+		4	1	1	3
Хог хаягдал		+		4	1	1	3
Нөлөөллийн зэрэглэл		Нөлөөллийн эрчим		Хамрах хүрээ		Магадлал	
>75	8	Их	Бүс нутгийн хэмжээнд	3	Өндөр	4	
30-75	6	Дунд	Орон нутгийн хэмжээнд	2	Дунд	3	
<30	4	Бага	Тухайн орчны хэмжээнд	1	Бага	2	
Эрэг	2	Маш бага					

Хэсгийн дүгнэлт:

Төслийн үйл ажиллагаанаас усан орчинд үзүүлэх гол нөлөөлүүд нь төслийн үйл ажиллагаанд ашиглагдах усны хэрэглээ, хог хаягдал, тээврийн хэрэгслүүдийн үйл ажиллагаатай шууд хамааралтай.

Төслийн үйл ажиллагаанаас төсөл хэрэгжих бүс нутгийн усан орчинд нөлөөллөх дээрх гол сөрөг нөлөөллүүдийг магадлан жагсааж, төслийн үйл ажиллагааны үе шатууд дахь тэдгээрийн эрчим, үргэлжлэх хугацааг тодорхойлбол нөлөөллүүд нь 25% их, 75% бага эрчимшилтэй, үргэлжлэх хугацааны хувьд 25% богино хугацааны, 75% түр зуурын нөлөөлөл байна. Ерөнхийд нь дүгнэвэл төслийн үйл ажиллагаанаас усан орчинд үзүүлэх нөлөөлөл **БАГА** гэсэн ангиалд хамарагдаж байна.

2.8 Нийгэм эдийн засагт үзүүлэх гол болон болзошгүй нөлөөлөл

Нийгмийн хүрээнд төслийн үйл ажиллагаа ерөнхийдөө шууд нөлөө үзүүлэх бөгөөд нөлөөллийн үргэлжлэх хугацаа урт учираас нийтийн эрүүл ахуй, мэргэжлээс шалтгаалах өвчний тархалтад үзүүлэх сөрөг нөлөө мөн шууд бусаар ч илэрч болзошгүй. Үүнтэй адилаар ядуурлыг бууруулахад төслийн хүчин чадал нэмэгдэх байдал нь шууд бусаар нөлөөлөх бөгөөд энэ нөлөө нь зерэг төлөвтэй байна. Станцыг өргөтгөсөнөөр ажлын байрыг шууд нэмэгдүүлэх бөгөөд шинээр нэмэгдсэн ажлын байрууд урт хугацаанд хадгалагдана. Эдгээр нөлөөллүүд эргэлтгүй үйлчлэх ба нөлөөллийн эрчим нь ерөнхийдөө дунд зэргийн түвшинд байна. Төсөл хэрэгжүүлэгчийн үйл ажиллагаанд ажиллагдсын аюулгүй байдал, эрүүл мэндийг хамгаалах байнгын үйлчилгээтэй хөтөлбөр хэрэгжиж байдаг тул мэргэжлээс шалтгаалах өвчлэл нь харьцангуй бага нөлөөтэй байх талтай.



ДЦС-ыг 50 МВт-аар өргөтгөснөөр дараах тулгамдсан асуудлуудад эергээр нөлөөлнө.

- ✓ Зүүн бүсийн Дорнод, Сүхбаатар аймгийн эрчим хүчиний хангамжийн найдвартай, аюулгүй ажиллагаа дээшилнэ.
- ✓ Уул уурхай, газрын тосны үйлдвэрлэл хөгжихөд сайнаар нөлөөлнө.
- ✓ Зүүн бүсийн дотоодын нийт бүтээгдэхүүн еснө.
- ✓ Зүүн бүсийн Дорнод, Сүхбаатар аймгийн өрсөлдөх чадвар дээшилнэ.
- ✓ ДЦС-ын засвар үйлчилгээ хийх боломж гарч, найдвартай ажиллагаа дээшилнэ.

2.9 Хуримтлагдах нөлөөлөл

Төслийн талбайтай ойр хэрэгжиж буй төслүүдийн зүгээс хүрээлэн буй орчин, нийгэм эдийн засагт зерэг болон сөрөг нөлөөг их болон бага хэмжээгээр үзүүлэх юм. Үүнээс байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл нь энэ төслийн сөрөг нөлөөтэй уялдан газар ашиглалт, хөрсний бохирдол, хөрсний талхагдал, агаарын чанар, ан амьтны дайжилт, ургамлан нэмрөг доройтох зэргээр хуримтлагдах нөлөөллийг үзүүлнэ. Иймд эдгээр хуримтлагдах нөлөөллөөс өөрийн нөлөөллийн байдлыг ялган салгахын тулд нөлөөллийн бүсэд тогтоосон БОМТ-т цаг тухай бүрд нь авч хэрэгжүүлж, тайлagnaх нь зүйтэй.

Төсөл хэрэгжих явцад баригдах барилга байгууламжийг барьж байгуулах, төслийн цаашдын үйл ажиллагааны явцад тухайн төслийн үйл ажиллагаа, орон нутагт хэрэгжиж буй бусад төслийн үйл ажиллагаанаас хам нөлөөлөл үүсч, байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд сөрөг үр дагавар ихтэй, богино болон урт хугацааны нөлөөллийг үүсгэж болзошгүй.

Хүснэгт 32 Болзошгүй хуримтлагдах нөлөөлөл

№	Хуримтлагдах нөлөөлөл	Нөлөөллийн шалтгаан	Хамрах цар хүрээ	Үргэлжлэх хугацаа
1	Газрын гадарга ба хэвлэй эвдрэлд өртөх	Бусад төслүүдийн нөлөөлөл	Төслийн талбай, нөлөөллийн бүс	Өнгөрсөн, одоо, ирээдүй
2	Газрын доорх усны нөөц багасах	Бусад төслүүдийн усны хэрэглээ, хэрэглээний давхзал		Одоо, ирээдүй
3	Ургамал нэмрэгийн доройтол	Уур амьсгалын өөрчлөлт, төслийн үйл ажиллагаа		Өнгөрсөн, одоо, ирээдүй
4	Агаарын бохирдол нэмэгдэх	Хуурайшилт		Өнгөрсөн, одоо, ирээдүй
5	Хөрсний бохирдол, элэгдэл үүсэх	Уур амьсгалын өөрчлөлт, Бусад төслүүдийн нөлөөллийн давхзал		Өнгөрсөн, одоо, ирээдүй
6	Амьтан дайжих, тоо толгой цөөрөх	Уур амьсгалын өөрчлөлт, Бусад төслүүдийн нөлөөллийн давхзал		Өнгөрсөн, одоо, ирээдүй

Хуримтлагдах нөлөөлөл, түүний үр дагаварыг бодитой тодорхойлох, эрт хугацаанд илрүүлэхийн тулд төслийн үйл ажиллагааны тодорхой үе шат хэрэгжсэний дараа төслийн үйл ажиллагаанд мониторинг хийхийг зөвлөж байна.



ГУРАВДУГААР БҮЛЭГ: СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ, АРИЛГАХ, АРГА ХЭМЖЭЭ

Төслийн үйл ажиллагаанаас үүсэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, тэдгээрийг бууруулах болон арилгахад дараах зөвлөмж, арга хэмжээ, стандартын шаардлагыг мөрдлөг болгон ажиллах, цаг тухайд нь хэрэгжүүлэхийг төсөл хэрэгжүүлэгчид зөвлөж байна. Эдгээр зөвлөмжийг авч хэрэгжүүлэхдээ энэхүү байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн хууль эрхзүйн бүлэгт орсон хууль, дүрэм журам, стандарт болон Олон улсын конвенцийн холбогдох заалтыг мөрдлөг болгон ажиллах хэрэгтэй.

3.1 Аливаа барилгын ажлын үед үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах аргазүй, зөвлөмж

Төслийн барилга байгууламжийн ажлын үед газрын гадарга, хөрс, ургамлан бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах зорилгоор доорх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх нь зүйтэй:

- Ямар нэгэн барилгын ба газар шорооны ажил эхлэхийн өмнө нөлөөлөлд өртөх талбайн онгөн (уржил шимт бараан) хөрсийг 0.5 м зузаантайгаар хуулан авч *MNS5916:2008* стандартын дагуу хадгалах шаардлагатай. Тухайн шимт хөрсийг барилгын ажил дууссаны дараа сөрөг нөлөөлөлд өртсөн орчныг тохижуулах, нөхөн сэргээхэд ашиглана;
- Төслийн талбайд хийгдсэн барилгын болон бусад төрлийн үйл ажиллагаанаас үүдэн эвдрэлд өртсөн, талхлагдсан газруудад нэг бүрчлэн *MNS 5917:2008, MNS 5918:2008* стандартын дагуу техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх шаардлагатай. Биологийн нөхөн сэргээлтийг нутгийн унаган ургамлаар хийх нь зүйтэй болно;
- Аливаа барилгын ажлын үед хөрс, ургамал, газрын элэгдэл, эвдрэлийг хамгийн бага байлгахын тулд зөвхөн тухайн ажил эхлэхээс тусгайлан тогтоосон хил хүрээнд ажлыг явуулж байх шаардлагатай;
- Барилгын ажлын үед үүсэх хог хаягдлыг Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 48-р тушаалаар батлагдсан “Барилгын хог хаягдлыг цэвэрлэ, цуглуулах, англах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, бушилах журам”-ын дагуу зохицуулж байх шаардлагатай;
- Хөрсөнд шатах тослох материал алдагдахаас сэргийлж эвдрэл гэмтэлтэй машин техникийг ажлын талбайд гаргахгүй байх;
- Засвар үйлчилгээний талбайг гадаргын урсац орохоос хамгаалагдсан ирмэг хөвөө бүхий хатуу цементэн хучилттай болгох;
- Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг мэргэжлийн байгууллага болон мэргэжлийн хүмүүсээр хийлгүүлэх, үр дүнд үндэслэн хөрс хамгаалах арга хэмжээг төлөвлөх гэх мэт шаардлагатай арга хэмжээнүүдийг авах нь зүйтэй;
- Газар хөндөх зөвшөөрлийн дотоод журам боловсруулан аливаа барилгын болон газар шорооны бүх ажлын үед мөрдөн ажиллах.

3.2 Газрын гадарга, хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ

Станцын орготгол нь газар ашиглалтын хэмжээг 36.0 га-аар нэмэгдүүлэх, газрын нөөцийг багасгах:

- ✓ Цахилгаан станцыг барьж байгуулахдаа төлөвлөгдсөн зураг төслийн дагуу барилгын ажлыг гүйцэтгэж, эвдэрсэн газруудын техникийн нөхөн сэргээлтийг хийх шаардлагатай. Нөхөн сэргээлт хийхдээ газрын гадаргад үүссэн овоолгуудыг тарааж тухайн газрын гадаргын хэлбэртэй дүйцүүлэх хэрэгтэй.
- ✓ Бүтээн байгуулалтаар хуулсан шимт хөрсний нөөцийг тусгайлан овоолж үнсэн санг хучиж ургамалжуулахад зориулж хадгалах бөгөөд шимт хөрсний овоолгын өндөр нь 5 м-ээс ихгүй байна.



Өргөтголийн ажилд ашиглагдах тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд зориулж шинээр зам засаж сайжруулсны улмаас газрын гадарга эвдрэлд ортох:

- ✓ Барилгын ажлын үед олон салаа зам гаргахгүй байх тал дээр анхаарч ажиллах ба замын ашиглалт дууссаны дараагаар нөхөн сэргээлт хийж, тэмдэгжүүлэх шаардлагатай.
- ✓ Ашиглалтын үед засвар үйлчилгээ хийх засвар, үйлчилгээний ажлыг хийхдээ тогтсон нэг замаар зорчиж байх, хөдөлгөөнийг хязгаарлах

Нүүрс буулгах, тээвэрлэх хэсэгт нүүрсний нарийн ширхэгт тоос тоосонцор салхинд хийсч орчны газрын гадаргыг бохирдуулах:

- ✓ Нүүрс тээвэрлэх, буулгах ажлыг салхины хурд багатай үед, эсвэл битүү орчинд буулгах, буулгах үед тоос дарах арга хэмжээ авах шаардлагатай.

Цахилгаан станцаад ашиглагдах химийн бодисын ашиглалтын явцад ажилчдын санамсар болгоомжгүй үйлдэл, үйлдвэрлэлийн ослын үед үүссэн алдагдал, асгаралт, дэлбэрэлтээс болж газрын гадарга, хэвлэй бохирдох:

- ✓ Цахилгаан станцын аваар устгах төлөвлөгөөг боловсруулан холбогдох мэргэжлийн байгууллагаар батлуулан ажиллах ба аваар осол гарсан тохиолдолд байгаль орчинд учруулсан хохирлыг тооцоолон бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай.

ЭБД шаталттай зуухнаас гарах дэгдэмхий үнс, шааргыг тээвэрлэх явцад алдагдал асгаралт үүсч, газрын гадарга хэвлэйг бохирдуулах:

- ✓ Цахилгаан станцын зуухнаас гарах дэгдэмхий үнс болон шааргыг зориулалтын, тусгай байгууламжид хүлээн авч хөргөөх ба барилгын материалын түүхий эд болгон ашиглах боломжийг судлан, аль болох дахин ашиглах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай.

Цахилгаан станцын ашиглалтын үед ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын менежментэд доголдол үүссэн тохиолдолд хог хаягдал ил задгай хаягдаж, газрын гадаргыг бохирдуулах:

- ✓ Барилгын ажлын үед ахуйн хог хаягдал хийх, тоног төхөөрөмжүүдийн бүрэн бүтэн байдлыг шалгах ба, ажлын талбар дээр тээврийн хөдөлгөөний менежментийн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх

- ✓ Барилгажилтын хугацаанд ОХШХ-ийн дагуу газрын гадаргын эвдрэл, бохирдлыг хянах, хяналтыг хийх.

Барилгын ажил болон ашиглалтын үед ашиглах тээврийн хэрэгсэлд эвдрэл бий болсноос шатах тослож материал алдагдаж, газрын гадаргыг бохирдуулах:

- ✓ Барилгажилтын үед ашиглах техник тоног төхөөрөмжүүдийн бүрэн бүтэн байдлыг шалгах ба, ажлын талбар дээр тээврийн хөдөлгөөний менежментийн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх

- ✓ Барилгажилтын хугацаанд ОХШХ-ийн дагуу газрын гадаргын эвдрэл, бохирдлыг хянах, хяналтыг хийх.

3.3 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ

Барилга байгууламжийг барих үйл ажиллагаатай холбоотой хорс хуулалтаас үүсэх тоосожилт болон тээвэрлэлтийн үед үүсэх тоосожилт:

- ✓ Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүсэх тоосожилтын хэмжээг бууруулах зорилгоор хурдны хязгаар тогтоох, замын усалгаа чийгшүүлэлтийг хийх, шороон замыг дагтаршуулах, хайргаар хучих, тоос дарагч бодисоор шүрших зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх
- ✓ Тээврийн хэрэгслийг сонгоходо шатахуун зарцуулалт багатай, ашигт үйлийн коэффициент ондортай техник хэрэгсэл сонгох
- ✓ Нүүрс ачсан ачааны автомашинуудын тэвшийг хучиж, нүүрс салхинд хийсэж, алдагдахаас сэргийлэх



- ✓ Нүүрс овоолох, нүүрс асгах явцад зохистойгоор шаардлагатай тохиолдолд ус шүршин тоосжилтыг багасгах замаар орчны агаарын чанарыг хамгаалах
- ✓ Нүүрсний овоолгын тоосыг багасгахад усаар чийгшүүлэх нь ашиглалтын зардлыг ихэсгэдэг, мөн өвлүүн улиралд боломжгүй тул хадгалах нүүрсний хэмжээг тээвэрлэлтийн тасралтгүй үйл ажиллагааны горим, нүүрс хадгалалтын хэмжээг оновчтой тогтоох
- ✓ Нүүрсийг зориулалтын салхины хамгаалалттай хашаа бүхий талбайд буулгах, хадгалах, дамжуулах ба талбайн эргэн тойронд салхи тоосноос хамгаалах ургамал нөмрөг бий болгох замаар салхины хурд хүчийг сааруулах, өнгөн хөрсний шороо, тоос хийсэхийг багасгах боломжтой эсэхийг судлах
- ✓ Агаарын чанарын хяналтыг тогтмол графикийн дагуу хийж агаарын чанарын стандартын шаардлагыг хангаж ажиллах, заасан хүлцэх хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд хэтрэхэд нөлөөлсөн эх үүсвэрт тохирох арга хэмжээг авч ажиллах хэрэгтэй.

Шороон замыг усалж чийгшүүлэх нь тоосны дэгдэлтийг дунджаар 55% түүнээс их хэмжээгээр бууруулдаг бол химийн нэмэлт бүрэлдэхүүнийг нэмж өгснөөр тоосны дэгдэлт 98% хүргэлт буурдаг¹⁰.

Тоос дарагч бодис:

Тоос дарагч нь тухайн орчны агаар халуун хуурай байсан хэдий ч орчны чийглэгийг шороон замын гадаргууд цуглувулан барих замаар тоосонцрын жижиг хэсгүүдийг барьцаалдуулан шороон гадаргыг нягтруулж тоосжилтыг 90-95% хүргэлт бууруулах боломжтой байдаг. Тоос дарагч бүтээгдэхүүнүүд нь DustOff, DustBlock, Магний хлорид, Кальцийн хлорид, Асфальтын эмульс зэрэг олон төрөл байна. Тоос дарагч бүтээгдэхүүнийг устай хольж усны машинаар талбайд жигд шүрших маягаар хэрэглэдэг.

Төслийн хүрээнд ашиглагдах тээврийн хэрэгслүүдийг шатахуунаар цэнэглэх үед мон мотор эд ангиас агаар бохирдуулах бодис уурших, тээврийн хэрэгслийн яндангаас агаар бохирдуулагч бодис ялгарах /нүүрсторогчийн исэл, хүхэрлэг хий, азотын исэл, нүүрсторогчийн давхар исэл, тортог /:


- ✓ Бохирдуулагч хийн ялгарлыг бууруулахын тулд техникийн үзлэгт хугацаанд нь оруулсан, ялгаруулж буй бохирдуулагч нь стандарт түвшинд буй машин техникийг ашиглах, ашиглагдаж буй машин техникт засвар үйлчилгээг тогтмол хугацаанд чанартай хийх, техникийн хэвийн ажлын горимыг хангах, тээвэрлэлтийн машинуудад ашиглагдах түлшинд чанарын хяналт явуулж, зөвхөн нэг шатахууны агуулах, ШТС-аас үйлчилгээ үзүүлэх шаардлагатай.

Төслийн барилга байгууламж барих болон үйл ажиллагааны үе шат мон тээврийн хэрэгслээс үүсэх дуу шуугиан:

- ✓ Тээврийн хэрэгслийн дууны даралтын түвшнийг техникийн хяналтын үзлэгээр хянан шалгаж хүлцэх хэмжээнээс хэтэрсэн дуу чимээ ялгаруулж байгаа эсэхийг тодорхойлох шаардлагатай ба MNS 17-5-1-21:1992 /Авто тээврийн хэрэгслийн дуу чимээ Дуу чимээний хүлцэх түвшин, хэмжих арга) стандартын шаардлагыг хангасан байна./
- ✓ Барилгын ажлаас үүсэх дуу чимээгээр төслийн талбай орчмын оршин суугчдын тав тухыг алдагдуулахгүйн тулд дуу чимээний хаалт, хашлагыг суурилуулах ёстой
- ✓ Дуу чимээний дундаж түвшин 85dBА-ээс дээш тохиолдолд ажлын байрны орох хаалга, ойролцоо хэсгүүдэд анхааруулах тэмдэг харагдахуйц байрлуулна. (MNS 6768:2019, 7.6.1)

¹⁰ General EHS guidelines, Air emissions and ambient air quality, IFC, 2007





- ✓ Дуу чимээний бохирдолтой буюу зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн орчинд дараах тэмдгийг анхаарулга болгон ашиглаж болно.



Төслийн уйл ажиллагаанаас үүсэх хаягдалиг удаан хугацаанд буруу хадгалснаас тухайн хаягдаас нүүрсхүчлийн хий агаарт хаягдах:

- Ахуйн хог хаягдлыг ариун цэврийн бүсийн гадна, түүнээс 60м-ээс багагүй зайд, салхины зонхилох чиглэлийн дагуу, төслийн барилга байгууламжийн доод талд ус үл нэвтрэх дотортой, зориулалтын саванд цуглуулна. Энд муудаж болзошгүй, чийгтэй юмуу, муудсан зүйл хаяж болохгүй. Энд халдвартгүйжүүлэх, нян устгах ариутгалыг мэргэжлийн байгууллагаар тогтоосон хугацаанд хийлгэж байвал зохино.

Хадгалалтын горим зорчигдсонийн улмаас химиин нэгдлүүд дулааны задралд орж хий байдалтай нэгдлүүд үүсэх:

- Химиин бодисуудыг тээвэрлэх, хадгалах аюулгүй ажиллагааны дүрэм журмыг баримтлан ажиллах, аливаа эрсдэл үүсгэх эх үүсвэрийг зогсоох, тархалтыг аль болох хязгаарлах, ажилчдад аюулгүй ажиллагааны талаар сургалт зохион байгуулах
- Төсөл хэрэгжих орчмын агаарт жилд 2-оос доошгүй удаа орчны агаараас сорьц дээж авч, мэргэжлийн байгууллагаар шинжилгээ хийлгэж, түвшинг тодорхойлнуулан, заавар зөвлөмж авч ажиллах

Түгээмэл бохирдуулагчийг бууруулах технологи: Агаар бохирдуулагч түгээмэл бохирдуулагч болох хүхэрлэг хий, азотын давхар исэл, нүүрстөрөгчийн давхар исэл, тоосонцрыг уламжлалт цахилгаан станцтай адил бууруулдаг.

Хүхэрлэг хийг бууруулах: Хүхэрлэг хийг шохойн чулуун уусмалыг ашиглан бууруулдаг

Хүхрийн давхар исэл нь нүүрсэнд агуулагдах хүхрийн нэгдлүүдийн шаталтын урвалаас үүсдэг. Шаталаас үүсэх урвалын тэгшигтээлийг бичвэл:



Энэ бохирдуулагч дараах урвалаар арилгаж болдог бөгөөд түлшинд шохойн чулун хольц нэмж шатаадаг.



Яндангас хаягдах тоос, тоосонцрын хэмжээг бууруулах. Станцад ашиглаж буй гол технологи нь цахилгаан статик хуримтлуур (EP-electrostatic precipitation) болон уутан шүүлтүүр (FF) -ийг бас ашигладаг. Тоосонцорыг бууруулах технологи ашигласнаар тоосонцроос гадна ихэнх тоостой хаягдах хүнд металлын ялгаралтыг бууруулдаг.

Нүүрс хадгалах талбайгаас агаарын чанарт нолоолох сорог нолооллийг бууруулах олон улсын жишиг:

Төсөл хэрэгжүүлэгч нь дулааны станцын нүүрс хадгалах талбайг битүүмжлэх, боломжгүй бол дараах арга технологиудаас сонгон хүрээлэн буй орчныг нүүрсний тоосоор бохирдуулахаас хамгаалах нь зүйтэй. Үүнд:

1. Тороор хучих арга;
2. Салхины хаалт хашаа барих арга;
3. Мод тарьж салхины хаалт бий болгох арга.

1. Тороор хучих арга

Энэ аргыг өнөөгийн байдлаар дэлхийн улс орнуудад барилгын ажлын талбай дахь тоосны дэгдэлтийг бууруулах, нүүрс болон бусад ашигт малтмалын хүдрийн гаалийн хяналтын талбай дахь овоолгуудаас дэгдэх тоосны тархалтыг бууруулах арилгах зорилгоор өргөн ашиглаж байна.



Зураг 33 Тороор хучих арга


2. Салхины хаалт хашаа барих арга

Нүүрсийг ил задгай талбайд хадгалж байгаа тохиолдолд машин тоног төхөөрөмжийн орчим их хэмжээний нурмаг материал үүсэж тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр агаарт тоосжилтыг үүсгэж байдаг. Иймд салхины хурдыг сааруулах хашаа барьж байгуулснаар тоосжилтоос сэргийлэх боломжтой. Хаалтын өндрийг нүүрсний овоолгын өндөрөөс хамааруулж сонгох ба 12 м хүртэлх өндөртэйгөөр байгуулах боломжтой байдаг. Мөн хаалт хийх материал нь 30-40%-н нүхтэй (торшиг) байх нь илүү үр дүнтэй байдаг. Хаалт болон хашааг салхины ерөнхий чиглэлтэй тэгш өнцөг үүсгэх чиглэлд барьж байгуулснаар салхины хурд чиглэлийг өөрчилж хаалтаас салхины доод чиглэлд үүсэх тоосонцрыг 80-90%-р бууруулдаг [Grantz et al. 1998]. Хаалтыг мөн овоолгын тоосжилтыг бууруулахад мөн ашигладаг ба гэхдээ овоолгыг бүрэн хаахын тулд хаалтын хэмжээ хангалттай том байх шаардлагатай.

Салхины хаалт болон хашааг салхины ерөнхий чиглэлтэй тэгш өнцөг үүсгэх чиглэлд барьж байгуулснаар салхины хурд чиглэлийг өөрчилж хаалтаас салхины доод чиглэлд үүсэх тоосонцрыг 80-90%-р бууруулдаг [Grantz et al. 1998]. Хаалтыг мөн овоолгын тоосжилтыг бууруулахад мөн ашигладаг ба гэхдээ овоолгыг бүрэн хаахын тулд хаалтын хэмжээ хангалттай том байх шаардлагатай.




Дулааны цахилгаан станцын нүүрсний агуулахын талбайг тойруулан олон улсын жишигт нийцсэн салхины хамгаалалт болохуйц өндөр хашаа барьснаар тоосжилтыг бууруулах боломжтой. Өнөөгийн байдлаар иймэрхүү хашааг Монгол улсад нүүрс ачижж буулгах үйл ажиллагаанд түлхүү ашиглаж байна.




Зураг 34 Салхины хаалтын үр дүн

Тус хашаа нь өндөр нягт төрон бүтэцтэй учир салхины хамгаалалт болохоос гадна зөөгдлийг тодорхой хэмжээнд бууруулдаг байна. Монгол улсад баригдсан хашааны загварыг энд үзүүлэв.



Зураг 35 Салхины хаалт хэрэглэж буй жишээ





Зураг 36 Салхины хаалт барих төлөвлөлт


3. Мод тарьж салхины хаалт бий болгох арга

Дулааны цахилгаан станцын нүүрсний талбайн эргэн тойронд салхины хаалт хашаа барих боломжгүй тохиолдолд тус талбайн эргэн тойронд орших сул газруудад мод тарьж бичил зурvas бий болгосноор салхины хүчийг бууруулж улмаар нүүрсний тоосны тархалтыг багасгах, арилгах боломжтой.

Нүүрсний талбайгаас дэгдэх тоосны тархалтыг буруулах зорилгоор талбайд тарьж болно. Нэг мод, бутны эзлэх талбайг дунджаар 3 m^2 байхаар тооцоолбол 7160 гаруй мод, бут тарьж бичил цэцэрлэг байгуулж болох талбай байна. Тус талбайд мод, бут бүхий ногоон байгууламж байгуулснаар салхинаас хамгаалахаас гадна агаарын бохирдолт болон дуу чимээнээс хамгаалж, орчны нүүрс хүчлийн хийг багасгаж өөрийн эзэмшлийн талбайд байгалийн зүй тогтцыг бүрдүүлж бий болгоно.

Энэ ажлыг “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд тус байгууллагын хүлээж буй үүрэгт багтаан гүйцэтгэн ажиллах боломжтой. Мод, бут тарих талбайн төлөвлөлтийн зургийг дор үзүүлэв (Зураг 37).





Зураг 37 Салхины хаалтын зориулалтаар мод тарих арга хэмжээний төлөвлөлт

Тоос баригч төхөөрөмж сууринуулж ашиглах:

Дулааны цахилгаан станцын нүүрс бутлах, шигших, зөөх дамжлагуудаас үүсэх тоосжилтыг бууруулахын тулд юуны түрүүнд үр ашиг өндөртэй тоос цуглуулах систем сонгон ашиглах нь чухал юм. Нүүрс бутлах, жигдруулэх хэсэгт тоосны хэмжээг бууруулах зорилгоор тоос баригч төхөөрөмж сууринуулан ашиглахыг зөвлөж байна.

Үнсэн сангаас үсэх нолооллийг бууруулах:

Хаягдлын санд хуримтлагдсан үйлдвэрийн хатуу хаягдлыг байнга нойтон чийгтэй байлгавал үнс хийсэхгүй. Ашиглаж байгаа үндсэн үнсэн санг хэсэгчлэн хуваарилах байдлаар ашигладаг ба энэ нь тухайн ашиглаж байгаа хэсэгтэй үнсний хийсэлтийг бууруулах арга хэмжээг оновчтой хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ. Тиймээс ашиглаж байгаа үнсэн санг байнга чийгтэй байлгах хэрэгтэй. Энэ нь усны зарцуулалтыг боломжит хэмжээнээс илүүтэйгээр нэмэгдүүлэх хүртэл нимгэн плёнкоор хучилт хийж болно. Үнсэн санд булинга дүүрэхийн хэрээр хучилт нь өөрөө өргөгдөх нөхцөлтэй байх тул үнс хийсгэхгүй байхад илүү ч зохимжтой байх бөгөөд энэ арга хэмжээг хэрэгжүүлснээр үнс хийсэхээс зайлсхийх боломжтой.

Станцыг өргөтгөх төслийн ТЭЗҮ-д шинээр байгуулах үнсэн сангийн ёроолд плёнк дэвсэх тухай заасан байгааг дараах байдлаар хэрэгжүүлэх хэрэгтэй. Үүнд:

- ✓ Үнсэн сан нь хийцийн хувьд далангаар хашигдсан, далан нь түүн дотор хуримтлуулах шингэн булингыг тогтоон барьж байх даац бүхий тэсвэртэй байх хэрэгтэй. Тиймээс далангийн суурийн өргөн 10м-ээс багагүй, дотор талын налуу 30 хэмээс ихгүй байх нь тохиромжтой. Сангийн доод ёроол аль болох жигд тэгшлэгдсэн байх бөгөөд бохир усны шүүрлээс хамгаалах дэвсэг тавихад тохируулсан байх хэрэгтэй.



- ✓ Үнсэн сангийн ёроолд дэвсэх плёнк нь 1 мм-ээс багагүй зузаантай байх бөгөөд манай орны улирлын өөрчлөлтөд зохицсон халуун, хүйтэнд тэсвэртэй байх шаардлагатай. Ийм төрлийн дэвсгийг нийлэг мембрان хальс гэх бөгөөд уян хатан чанартай байх тул чулуу хайрган дээр дэвсэхэд тийм ч амархан цоороод байдаггүй онцлогтой.
- ✓ Үнсэн сан хамгаалалтын мембран дэвсэхдээ сангийн булан , далангийн суурь зэрэгт мембран дэвсгийг сайтар нягт суулгаж зохих хэлбэрт оруулах хэрэгтэй. Булан болон суурийн хэлбэрийг сайтар гаргаж , зүйдэл залгааг сайтар шалгаж мембранныг дэвсэнэ.
- ✓ Үнсэн сангийн далангийн гадна талд газрын доорх усны бохирдлын хяналтын цооног гаргаж, усны чанарын хяналт шинжилгээг авч байх хэрэгтэй.
- ✓ Үнсэн сангийн далаан, хамгаалалтын суваг шуудуу зэрэг шороон хийцүүд нь салхи, усны нөлөөгөөр эвдрэх , хэлбэр дүрсээ алдах байдлаар тогтвортойт нь муудах нөхцөлийг байнга хянах, засаж сайжруулах арга хэмжээ авч байх шаардлагатай
- ✓ Үнсэн сангийн далангийн тогтвортой байдлыг хангахад далангийн гадна талын налууг 30 хэмээс ихгүй байлгаж түүнийг ургамалжуулан, олон наст ургамлын үндсээр бэхжүүлснээр газрын тогтвортойт тогтвортойт хангаж зохисгүй эвдрэлээс зайлсхийнэ.
- ✓ Үнсэн сангийн талбайг хашаалах шаардлагатай.

3.4 Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ

- ✓ *Усыг ашиглах боломжит ноөцийн хүрээнд хэмнэлттэй, үр ашигтай, эргүүлэн ашиглах (Усны тухай хууль, 4.3)*

ДЦС-ын технологийн хэрэгцээнээс гарсан хаягдал усыг үнсэн сан, тунгаах усны бассейн ашиглан механик аргаар цэвэрлэж 80 орчим хувийг эргүүлэн ашигладаг. Үлдсэн хэсгийг байгальд нийлүүлдэг.

- ✓ *Ус ашиглуулах дүгнэлт, холбогдох зөвшөөрөлгүйгээр ус ашиглахгүй, цооног гаргахгүй байх (Усны тухай хууль, 28.18)*

Нэмэлт ус хангамжийн эх үүсвэрийн хайгуул, судалгаа явуулах зөвшөөрлийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас авч мэргэжлийн байгууллагаар хийлгэх шаардлагатай. Усны хайгуул, судалгаа явуулсан байгууллага нь хайгуул, судалгааны ажлын дүнг усны ноөцийн зөвлөлөөр баталгаажуулан, мэдээ, тайланг улсын усны мэдээллийн санд хүлээлгэн өгөх үүрэгтэй (Усны тухай хууль, 5.3, 5.4).

- ✓ *Ус ашиглах зөвшөөрөлд заасан хэмжээнээс илүү ашиглахгүй байх (Усны тухай хууль, 30.1.1)*

Хэрвээ хэтрүүлж ашигласан тохиолдолд Засгийн газрын 2018 оны 391-р тогтоолоор баталсан “Зөвшөөрсөн хэмжээнээс илүү ашигласан усны төлбөр тооцох журам”-ын дагуу илүү ашигласан усны төлбөрийг шатлан өсгөж тооцно.

- ✓ *Усны нөөц ашигласны төлбөр төлох*

Хэрлэн голын сав газарт газрын доорх усны экологи, эдийн засгийн суурь үнэлгээ 2835 төгрөг байдаг. Эрчим хүч үйлдвэрлэхэд газрын доорх ус ашиглавал экологи, эдийн засгийн суурь үнэлгээний 15% (Усны нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээ, МУ-ын ЗГ 2013 оны 9-р сарын 21-ний өдрийн 326-р тогтоол)-ийг ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүр (МУ-ын ЗГ 2013 оны 9-р сарын 21-ний өдрийн 327-р тогтоол) 0.15 болон ашигласан усны хэмжээ (m^3)-ээр үржүүлэн усны нөөц ашигласны төлбөрийг тооцно.

1 m^3 усны нөөц ашигласны төлбөр: $2835 \text{ төг}/m^3 \times 0.15 \times 0.15 = 63.7875 \text{ төг}/m^3$

- ✓ *Шинээр гаргах худгуудын мэдээллийг Дорнод аймгийн байгаль орчны албаны усны мэдээллийн санд бүртгүүлж, худгийн паспорт авах (Усны тухай хууль, 27.3)*



- ✓ Шинээр гаргах худгуудын дэргэд усны түвшний ашиглалтыг пьезометрийн 2 цооногоор тогтмол хянах, логгер сууринуулах, хэмжилтийн үр дүнд анализ хийх
- ✓ Одоо ашиглаж байгаа 4 худгийн усны түвшнийг хянах пьезометрийн цооногийн байршилыг мэргэжлийн байгууллагаар тодорхойлуулж гаргах, гаргасан пьезометрийн цооногт усны түвшнийг тогтмол хянах, үр дүнд анализ хийх

Ус хангамжийн эх үүсвэрийн хайгуул, судалгаа явуулах үед мэргэжлийн байгууллагаас пьезометрийн цооногуудын байршилын талаар зөвлөгөө авах хэрэгтэй. Ашиглаж байгаа усны хэмжээ, ашиглалтын худгийн усны түвшний бууралтад байнгын мониторинг хийх хэрэгтэй. Логгер сууринуулан усны түвшнийг хянаж, хэмжилтийн мэдээг цуглуулан дун шинжилгээ хийх шаардлагатай.

- ✓ Одоо ашиглаж байгаа болон шинээр гаргах худгууд, дамжуулах, түгээх шугам хоолойд эрүүл ахуйн хориглолт, хязгаарлалтын бусийг тогтоох, эрүүл ахуйн бусийн дэглэмийг мөрдох

Ус хангамжийн эх үүсвэрийн нөөц хомсдох, бохирдохоос хамгаалах зорилгоор ус хангамжийн эх үүсвэрт Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бусийн дэглэмийг мөрдөх журам (Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, Барилга, хот байгуулалтын сайдын 2015 оны А-230/127 дугаар хамтарсан тушаалын хавсралт)-ын дагуу эрүүл ахуйн бүс тогтоох нь зүйтэй. Энэ журамд заасан эрүүл ахуйн хориглолт, хязгаарлалтын бусийн дэглэмийг тогтоосон бүсүүдэд баримтлах шаардлагатай.

- ✓ Хаягдал усны шугам, шинэ эх үүсвэрийн ус авах худаг, ус дамжуулах шугамын оролт тус бүр дээр тусгай зөвшөөрөлтэй байгууллагаар баталгаажсан тоолуур сууринуулах (Усны тухай хууль, 30.1.4, БОНХ-ийн сайдын 2013 оны 5-р сарын 16-ны өдрийн А-156 дугаар тушаалаар батлагдсан “Ус ашиглалт, хэрэглээг тоолууржсуулах журам”)

Байгальд нийлүүлэх хаягдал усны шугамд баталгаажсан тоолуур сууринуулах шаардлагатай.

- ✓ Тоолууруудыг графикийн дагуу тогтоосон хугацаанд хэмжил зүйн байгууллагын баталгаажуулалтад хамруулж гэрчилгээ авах, дахин битүүмжлүүлэх

Усны тоолуур эвдэрсэн тохиолдолд ус хангагч байгууллагад яаралтай мэдэгдэж, усны тоолуурыг шугамнаас салгах, баталгаажуулсны дараа буцааж тавихад байлцах, тоолуурын засвар, сууринуулалтыг тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллагаар хийлгэх (Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам, 3.6.2); усны тоолуурын ашиглалтын хугацааг харгалзахгүйгээр хэмжилзүйн ажил, үйлчилгээний гэрээ, графикийн дагуу тогтоосон хугацаанд хэмжил зүйн төв болон Дорнод аймгийн хэмжил зүйн байгууллагын баталгаажуулалтад хамруулж гэрчилгээ авах бөгөөд дахин битүүмжлүүлэх шаардлагатай (Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам, 3.6.5).

Бохир усны шугамын гаргалгаан дээр сууринуулах тоолуур нь гаргалгааны шугамын голчтой адил байх бөгөөд мэдрэгчийн хийц нь бохир усны найрлагаас хамааран өөрчлөгдөх, эвдрэх, гэмтэх зэрэг эрдэлээс хамгаалагдсан эд ангиар хийгдсэн байна.

- ✓ Ус ашиглах, хаягдал устай холбоотой тайлан, мэдээг холбогдох газруудад заасан хугацаанд огох

Усны тухай хуулийн 7.5-д заасны дагуу усны мэдээллийн сан бүрдүүлэхэд шаардлагатай ус ашиглалтын тайлан (ус ашиглах зөвшөөрөл, гэрээ, гэрээ дүгнэсэн акт, газрын доорх усны хяналт-шинжилгээний мэдээ, усны нөөц ашигласны төлбөрийн баримт, ус ашиглалтын тоо хэмжээ)-г жил бүрийн 12-р сарын 20-ны дотор Усны газарт цахимаар болон холбогдох газарт өгнө. Мөн хаягдал ус хаях, зайлцуулах зөвшөөрлийн бичиг, хаягдал усны шинжилгээний дүгнэлтүүд, төлбөр төлсөн баримтыг жил бүрийн 12-р сарын 10-ны дотор Усны газарт өгнө.



- ✓ MNS 6561:2015 стандартад нийцэн хаягдал усыг ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх
- ✓ MNS 4943:2015 стандартын шаардлагыг хангасан хаягдал усыг байгальд нийлүүлж буй эсэхийг орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу тогтмол хянах, нийцэхгүй байгаа тохиолдолд шаардлагатай арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх

Төсөл хэрэгжүүлэгч нь хаягдал усныхаа тоо хэмжээ, найрагад хяналт тавих, хаягдал усны стандартын шаардлагад нийцүүлэн бохир усыг цэвэрлэж зайлуулах, ус бохирдуулсны төлбөр төлөх үүрэг хүлээнэ (Усны тухай хууль, 25.1).

Ослын улмаас хаягдал усыг цэвэрлэхгүйгээр хаях болсон тохиолдолд сав газрын захиргаа, зохих шатны Засаг даргад цаг алдалгүй мэдэгдэж, усны бохирдлыг бууруулах, байгаль орчныг нөхөн сэргээх ажлыг өөрийн зардлаар гүйцэтгэнэ (Усны тухай хууль, 24.3).

- ✓ *Хаягдал усны чанар дээрх стандартад заасан зөвшөөрөгдох дээд хэмжээнээс давсан бол нөхөн толбор толох (Усны тухай хуулийн 25.2, БОАЖ-ын сайдын 2019 оны А/635 дугаар тушаалаар баталсан “Ус бохирдуулсны нөхөн толборийг шатлан осгөх хэлбэрээр ноогдуулах журам”)*

Төсөл хэрэгжүүлэгч нь бохирдуулах бодисыг хаягдал усны стандартад заасан хэмжээнээс хэтрүүлэн гаргасан тохиолдолд байгаль орчны итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүгнэлтийг үндэслэн байгаль орчны байцаагч ус бохирдуулсны нөхөн төлбөрийг ногдуулж, төлөлтөд хяналт тавих бөгөөд нөхөн төлбөрийн хэмжээг ус бохирдуулсны төлбөрийг хоёроос тав дахин шатлан осгөх хэлбэрээр нэмэгдүүлж, бохирдуулах бодис бүрээр тогтооно (Усны тухай хууль, 25.2).

Мөн Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Сангийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 23-ний өдрийн А/406/226 дугаар хамтарсан тушаалаар баталсан Хаягдал усны эзлэхүүн болон бохирдуулах бодисын агууламжийг үндэслэн хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээг тогтоох журам, Хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээг тооцоолох аргачлалыг баримтална.

Тухайн улиралд байгаль орчинд шууд хаясан болон ариутгах татуургын байгууламжид нийлүүлсэн хаягдал усан дахь бохирдуулах бодист ногдох төлбөрийг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор харьалах татварын албанад төлнө.

- ✓ Эргэлтийн усан сангийн усны чанарыг орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу MNS 4943:2015 стандартын шаардлагад нийцэж байгаа эсэхийг тогтмол хянах, нийцэхгүй байгаа тохиолдолд шаардлагатай арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх
- ✓ Шинээр барих үнсэн санг ус үл нэвчүүлэх материалыаар доторлох
- ✓ Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдох журамын дагуу усны эх үүсвэрт эрүүл ахуйн бус тогтоох
- ✓ Шинэ үнсэн сангийн зураг, тосол боловсруулах, барих ажлыг тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагаар хийлгэх (Усны тухай хууль, 32.1)

Үнсэн сангаас шүүрэлт, нэвчилт бий болж, бохирдол үүсэж байгаа эсэхийг гадаргын болон газрын доорх усны хяналт шинжилгээний цэгүүдээр хянах шаардлагатай.

- ✓ Шинэ үнсэн сангийн усны чанарыг орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу тогтмол хянах, шинжилгээний үр дүнг харьцуулан анализ хийх
- ✓ Шинэ үнсэн сан орчмын газрын доорх усны урсгалын чиглэлийн дээд, доод талд хяналтын цооног гаргаж, усны чанарыг орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу тогтмол хянах, шинжилгээний үр дүнг харьцуулан анализ хийх
- ✓ Шинэ үнсэн сан орчмын Хэрлэн голын усны чанарыг хянах зорилгоор шинэ үнсэн сангаас дээших хэсэг болон үнсэн сангаас дооших хэсгийн Хэрлэн голоос орчны хяналт



*шинжилгээний хотолборт дагуу тогтолцох хянах, шинжилгээний үр дүнг харьцуулан
анализ хийх*

- ✓ *Үнсэн сан орчмын хяналт шинжилгээний цэгүүдэд бохирдол илэрсэн тохиолдолд үнсэн
сангийн ус үл нэвчүүлэх материал цоорсон эсэхийг шалгах, мөн шаардлагатай арга
хэмжээнүүдийг хэрэгжүүлэх*

Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэнийг мөрдөх журмыг үйл ажиллагаандaa мөрдлөг болгон ажиллах шаардлагатай.

3.5 Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нээлтгээний урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ

*Өргөтгөл хийх талбайд барилга байгууламжийг барих үйл ажиллагаа болон тээвэрлэлтийн үед
төслийн талбай болон ойр орчмын хөрсөн бүрхэвч талхлагдах, эвдрэх, олон салаа замууд үүсэх:*

- ✓ Барилга байгууламжуудыг барихаас өмнө эвдрэх талбайн үржил шимт хөрсийг “MNS 5916:2008 Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулагт, хадгалагт” стандартын дагуу хуулан шимт хөрсний овоолгод байршуулах.
- ✓ Барилгын материал, тоног төхөөрөмж, нүүрс тээвэрлэж буй тээврийн хэрэгслүүд төсөл хэрэгжүүлэгчээс зөвшөөрсөн авто замын маршрутаар зорчих, автозамын хэсгүүдийг засварлах
- ✓ Нүүрс буулгах талбайг хатуу хучилттай болгон бетондох, засварлах

Өргөтгөл хийх 36 га талбайн шимт хөрс хуулагдах:

- ✓ Цахилгаан станц барих талбайн орчимд улирлаас хамааран салхины хурд, чиглэл өөр боловч ихэвчлэн баруун, баруун хойноос зонхилон салхилдаг. Иймд шимт хөрсний овоолгуудыг зонхилох салхины дагуу хэлбэршүүлэн 5 метр хүртэл өндөртэйгээр байгуулна.
- ✓ Шимт хөрсний овоолгоог машин техникийн хөдөлгөөнд саад болохгүй, барилгын хог хаягдлаар бохирдохооргүй талбайг сонгон байршуулна.
- ✓ Шимт хөрсний овоолгын гадаргуут хэлбэржүүлэн усанд урсах, салхиар зөөгдөх эрсдэлийг бууруулна.

Төслийн үйл ажиллагааны явцад машин механизмаас мөн хүний санамсаргүй үйл ажиллагаанаас шалтгаалан ямар нэгэн шатах, тослох материал хөрсөнд ил задгай асгарч хөрс бохирдуулах:

- ✓ Нэн тэргүүнд нийт ажилчид байгууллагын дотоод дүрэм, журам, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрэм, журмуудыг чанад мөрдөж ажиллах;
- ✓ Тээврийн хэрэгслүүдийн урсгал засвар үйлчилгээг үйлдвэрлэгчээс өгсөн хугацаанд нь хийж ажиллах;
- ✓ Тээврийн хэрэгслүүдийн засвар, үйлчилгээг зөвхөн зориулалтын засварын газарт хийлгэх
- ✓ Машин, механизмуудын хэвийн ажиллагааг өдөр бүр ажилд гарахын өмнө шалгах;
- ✓ Хүнд машин механизмууд, тээврийн хэрэгслүүдийг зөвхөн ШТС эсвэл зориулалтын машинаар цэнэглэх
- ✓ Шатах тослох материалыг битүүмжлэл сайтай зориулалтын төмөр саванд түр хадгалах ба дахин ашиглах
- ✓ ШТМ асгарсан тохиолдолд тархалтыг хязгаарлах шингээх зориулалтын материал (Spill Station Oil & Fuel Spill Kit)-ыг хангалттай хэмжээгээр бэлэн байлгах ба хэрэв хөрсөн бүрхэвчид шингэвэл бохирдсон хөрсийг хуулан бохирдсон хөрс цутгуулах талбайд тээвэрлэн хүргэж саармагжуулна.



Хог хаягдлын менежментийг хангалтгүй хэрэгжүүлсэн тохиолдолд хатуу шингэн хог хаягдааар хорс бохирдох:

- ✓ Хог хаягдлыг хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний дагуу ангилан цуглуулж устгах, төвлөрсөн хогийн цэгт зөөн зайлцуулах.
- ✓ Хашаа, хязгаараас гадна элдэв, хог хаягдал хаяхгүй, газрын төрх, төслийн талбайн хөрсийг эвдэхгүй, хөндөхгүй байх арга хэмжээг хэвшүүлэх.

Төслийн үйл ажиллагааны явцад салхи ихтэй үед нүүрсний агуулах болон үns хадгалах байгууламжуудаас тоосонцор, нарийн дэгдээмхий үns зөвгөн газрын гадаргууд унаж хорсон дэх хүнд элементийн агууламжийн нэмэгдүүлэх:

- ✓ Нүүрс тээвэрлэж буй авто машинууд хучлагыг тогтмол хэрэглэх
- ✓ Цахилгаан станцаас жилд хаягдал болон гарах үnsийг дахин ашиглах талаар судалгааг хийж ажиллах

3.6 Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ

Өргөтголийн талбайд барилга байгууламжуудыг барих үйл явцад түүний орчмын талбайн ургамлан нөмрөг талхлагдах, устах:

- Олон салаа зам үүсгэхгүй байх тогтсон нэг замаар зорчуулах, засаж сайжруулж байх
- Замын усалгааг цаг уурын нехцөлд тохируулан хийх, дулааны улиралд тогтмол хийх
- Хүчтэй салхитай үед хөрс хуулах, ачиж буулгах үйл ажиллагааг зогсоох

Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний улмаас олон салаа замууд үүсэж ургамлан нөмрөг талхлагдах:

- ✓ Төлөвлөлтийн үе шатанд нүүрс тээвэрлэлтийн замын маршрутыг нарийвчлан төлөвлөн, ашиглалтын үе шатанд зөвхөн батлагдсан маршрутыг ашиглах, ачааны авто машинуудын тэвшийг хучих, хурдны зохистой хязгаарыг мөрдүүлэх

Төслийн үйл ажиллагаанаас үүсэх хатуу, шингэн хог хаягдалын нөлөөгөөр ургамлан нөмрөг хордох, устах:

- ✓ Хог хаягдлыг хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний дагуу ангилан цуглуулж устгах, төвлөрсөн хогийн цэгт зөөн зайлцуулах.
- ✓ Хашаа, хязгаараас гадна элдэв, хог хаягдал хаяхгүй, газрын төрх, төслийн талбайн хөрсийг эвдэхгүй, хөндөхгүй байх арга хэмжээг хэвшүүлэх.

Үнсэн сангаас үүсэх тоосожилтоос үүдэн ургамлан нөмрөгийн ургах орчин, физиологийн процессууд алдагдах, доройтож болзошгүй:

- ✓ Ургамлан нөмрөгийн хяналт шинжилгээг тогтмол хугацаанд гүйцэтгэх

Хуурайшилт ихтэй үед ажилчдын анхаарал болгоомжгүй байдлаас хээрийн түймэр гарч болзошгүй:

- ✓ Гал түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, *MNS 5566:2020 “Аж ахуй нэгж, байгууллага, барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм”* стандартын дагуу галын иж бүрэн багаж суурилуулах




3.7 Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах зөвлөмж

Төслийн талбайд хийгдэх барилгын ажил болон ойн менежментийн төлөвлөгөөний дагуу хийгдэх ажлуудын үр дүнд хөрс ба ой шүтэн амьдрагч амьтад, мөлхөгчид, шавжийн зүйлийн бүрдэл, шувуудын тоо толгойг бууруулах, амьдрах орчныг алдагдуулах сөрөг нөлөө үзүүлнэ. Амьтны үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахын тулд төсөл хэрэгжүүлэгч нь дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлбэл зохино. Үүнд:

- Аливаа газар шорооны ажил гол төлөв газар гэсэх үе болох 4-р сарын 1-нээс эхэлдэг ба энэ үе нь амьтан ичээнээс гарч идэвхтэй амьдарч эхлэх үетэй давхацдаг. Иймд ямар нэгэн барилгын ба газар шорооны ажлын хөрс хуулалт, гадаргыг тэгшлэхажлыг 4-р сараас өмнө хийж байх зүйтэй. Учир нь олонх амьтан 5-6-р сард төллөдөг ба тэдгээр амьтад төллөхөөс өмнө амжих тул амьтны хорогдлын тоо бага байх болно. Экологи эдийн засгийн үнэлгээгээр эм амьтан эрээсээ, төл амьтан аль алинаас нь өндөр үнэлгэддэг.
- Төслийн талбайд баригдах цахилгаан дамжуулах агаарын шугамын шон бүр дээр шувуу үргээх хэрэгсэл зааврын дагуу, бүтэн байрлуулах шаардлагатай.

Сүүлийн үед зарим зүйл шувууд цахилгаан дамжуулах агаарын шугамуудын хүчдэлд цохиулж олноор үхэх болсон. Үүнд махчин шувууд, элдэв идэшт хон хэрээ, улаан хошуут болон жижиг шувуудаас чогчиго зэрэг 13 зүйл шувуу цахилгааны хүчдэлд цохиулж үхдэг болохыг тогтоосон судалгааны үр дүн байдаг. Шувуу үргээх төхөөрөмжийг цахилгаан гүйдэл гүйх утсанд ойр байрлуулах ёстой. Шувуу биеийн аль нэг хэсгээрээ, гол төлөв нисэхээр далавчаа дэлгэх үед дамжуулах утсанд хүрснээр богино холбоо үүсэж гүйдэлд цохиулж үхдэг. Төхөөрөмжийг шувуу хамгаалах зорилгыг хангасан байхаар буюу гүйдлийн утас шон хоёрын дунд нь юм уу цахилгаан гүйдлийн утас руу ойр байхаар суурьшуулах шаардлагатай. *Мөн цахилгааны хүчдэлийг тусгaaялагч, цахилгаан хундрүүлэгч материалыар хийсэн уян зоолон хамгаалалт хийх хэрэгтэй.* Тэр зөөлөн материал нь хөдөлдөг болохоор шувуу суусан даруйдаа нисээд явчихдаг.




Зураг 38 Шувуу үргээх төхөөрөмж



3.8 Ногоон байгууламж байгуулах зөвлөмж

Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх хуулийн 7.2.4 заалтын дагуу газар эзэмшигч нь эдэлбэр газрын 10-аас доошгүй хувийг ногоон байгууламжтай байлгах шаардлагатай байдаг. Тус төслийн эдэлбэр газрын талбай нь 258150 м² бөгөөд энэ талбайн 10%аас багагүй хувь буюу хамгийн багадаа 25815 м² талбайд ногоон байгууламжийг байгуулах шаардлагатай.

Төслийн өмнөх жилүүдэд төслийн талбайд нарс-16ш, хайлаас-613ш, улиас-387ш, үрэл-5ш, чацаргана-60ш, 2022 онд хайлаас-1000ш мод бут тарьж ургуулан арчилж байна. “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд эрчим хүчиний салбарын хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу салбарын хэмжээнд “Зуун мянган мод” тарих үйл ажиллагааг зохион байгуулж байна. Энэхүү арга хэмжээтэй уялдуулан жилд 600ш мод бут тарих ба хайлаас 300ш, улиас 200ш, нарс 50ш, чацаргана 50ш тарихаар төлөвлөсөн байна.



Зураг 39 Ногоон байгууламж

ДЦС-ын хашаан доторх орчныг сайжруулах, ногоон байгууламжийн талбайг нэмэгдүүлэх, ажилчдын ая тухыг хангах зорилгоор төслийн талбайн сул чөлөөтэй хэсэгт мод бут тарих, шаардлагатай газруудыг зүлэгжүүлэх хэрэгтэй.

Төслийн талбайн хөрс, ургамлыг элэгдэл эвдрэлээс хамгаалах, ногоон байгууламж байгуулах талаар дор дурдсан зөвлөмжийг мөрдлөг болгон ажиллахыг төсөл хэрэгжүүлэгчид зөвлөж байна. Үүнд:

- Барилга байгууламжийн үйл ажиллагаанаас талхлагдсан ургамал, элэгдсэн хөрсийг нөхөн сэргэх зорилгоор хар шороон хөрсийг зөөверлөн авчирч хөрсжүүлэх элэгдсэн хөрсийг байнга сэргээж байх
- Байгуулалтын ажлын явцад эвдрэлд орсон хөрсийг нөхөн сэргээж, барилга объектын талбайгаас бусад сул газрыг бүрэн хэмжээнд зүлэг ургах нөхцөлөөр бүрэн хангах, ургамалжуулах, тариалсан ургамлыг тухай бүр нь арчилж тордох арга хэмжээ авч хэрэгжүүлж байх



- Тарималжуулалтыг технологийн горимын дагуу явуулах шаардлагатай ба мэргэжлийн байгууллагаас технологийн нэмэлт заавар, зөвлөгөө авч хэрэгжүүлэх

Аль болох тухайн орчинд ургадаг, дасан зохицох чадвартай мод, бут, сөөг, олон наст ургамлыг хольж тариалах нь зүйтэй.

Бидний зүтгэс ногоон байгууламжийн тариалалтыг хийхэд тохиромжтой мод сөөгийг сонгон авч дараах хувилбарыг санал болгож байна. Манай орны хээр, ойт хээр, хангайн бүс бүслүүрт ургах чадвартай мод сөөгийг сонгосон. Мөн олон наст ургамлаар согооврыг сонгосон бөгөөд соговор нь манай оронд хамгийн сайн ургадаг, өргөн тархацтай, өвөлжилт хамгийн сайн даадаг ургамал юм.

Ногоон байгууламжийг 2 эгнээ модлог ургамал, 1 эгнээ өвслөг ургамал гэсэн хэлбэрээр зохион байгуулагдана. Сөөг-Ургамал-Сөөг.



Тариалалтын үе шат:

Тариалалтын үе шат нь 2023 оны хавар 4 сарын сүүл 5 сарын эхээр явагдана. Уг хугацааг ургамал тариалахад хамгийн тохиромжтой.

Зурvas газраа бэлтгэх:

Нүх ухажад гарсан шороог шигшиж, чулуу хайрга, элдэв хог зэрэг бүхий л хольцоос салгаж ялгана. Засаж бэлтгэсэн талбайд 40-50 см өргөн, 35-40 см гүн суваг ухаж, урьдчилан бэлтгэсэн зохих найрлагатай хөрсийг нүхний гуравны нэг хүртэл дүүргэнэ. Тус талбай нь хог ургамал багатай тул хөрсийг нийтэд нь хагалахгүйгээр нүх ухаж суулгана. Мод сөөгөндөө тохируулан нүх ухаж, түүндээ үржил шимт хар шороо хийж дүүргэнэ.

Хөрс бэлтгэх:

Мод сөөгөнд үржил шимтэй талбай дутагдах, хийсэн ус нь доош шүүрч мод сөөг ус чийгээр гачигдах тал ажиглагддаг тул ногоон байгууламжид зориулж, талбайн хөрсийг 30-40 см-ийн гүнд нэлд нь боловсруулах нь чухал. Боловсруулсан хөрсний доод талд 6-10 см зузаан шавар болон хүнд шаваранцар хөрс дэвсэж, дээрээс нь элсэрхэг ба хар шороон хөрс хийж, мод сөөгөө тарих хэсэгт хотойлгож өгвэл зохино. Хөрсийг шороогоор ингэж баяжуулах нь ухсан нүх талбайн үржил шимиж дээшлүүлэх, нөгөөтэйгүүр ус алдахгүй байдаг сайн талтай. Налуу газар тарьц, суулгац тарихдаа дэвсэг дэнжийт гадаргууд эгц шатлуулан хөрсийг нь засан боловсруулвал зохино.

Суулгац тээвэрлэх, хадгалах:

Мод, бут, сөөгийн суулгацыг тээвэрлэх үедээ үндсийг нь хатаахгүйн тулд 50-100 ширхэгээр нь багцлан боож, үндсийг нь шорооны нойтон зуурмагт гүйцэд дүрж, тэр хэсгийг нь нийлэг хальсаар хэдэн давхар боож хамгаална. Тээвэрлэж авчирсан суулгацыг тарихын өмнө, үндсийг төдийгүй, ишний доод хэсгийг оролцуулан нойтон шороогоор дарж, сүүдэр газар түр хадгална. Ургамал тайван ургаж байсан орчиноос еер орчинд очихдоо тодорхой хэмжээгээр амьдрах чадвар нь мууддаг.



Тиймээс суулгацыг заавал сүүдэр газар, үндэс нь чийгээ алдахааргүй нөхцөлд хадгалах шаардлагатай.

Суулгах:

Мод, сөөгийг суулгах нүхийг дараах аргаар бэлтгэнэ. 5 дугаар сарын эхээр тариалахаар төлөвлөсөн байна. Мод суулгахын өмнө нүхэндээ үржил шимт хар шороо дэвсэж, сайтар усална. Дараа нь суулгачны үндэс нугаларахгүйгээр нүхний ёроолд жигд тарааж, дахин хар шороо хийж чигжинэ. Үлдсэн шороогоо нүх руу хийж чигжинэ.

Зүлэг тарих зөвлөмжс:

1. Талбайгаа зүлэгжүүлэхийн өмнө шим тэжээл муутай газрын хөрсийг 20-30 сантиметр түн хагалж хайрга чулууг цэвэрлэж аваад үлдсэн шороог зөөсний дараа хүрэн хөрсийг 2.5x2.5 сантиметрийн гишгүүрээр гишгиж, ургамлын үндэс болон бусад хогноос цэвэрлэж, гишгэсэн хар хүрэн хөрсийг 20 сантиметрээс доошгүй зузаан дэвсэж гадаргууд жигд тарааж тэгшилснээр зүлэг тарих талбай бэлэн болно.
2. Үрийг нэг метр квадрат талбайд 50-80 грамм орохоор тооцоолж салхи багатай тогтуун өдөр талбайд жигд цацаад тармуураар самнаасны дараа элсээр нэгээс хоёр сантиметр зузаан хучина.
3. Үүний дараа 50-100 килограмм жинтэй булаар булдаж зөөлөн шүршиж усална.
4. Зүлэгжүүлэх ажлыг тавдугаар сарын хоёрдугаар хагасаас долдугаар сарын 10-нд багтааж тарьдаг байна.
5. Тарьсан үрээ соёолтол хөрсийг нь чийгтэй байлгахын тулд өдөр бүр өглөө оройн сэргүнд нэг метр квадрат талбайд 30-40 литр ус, үр соёолсноос хойш нэг метр квадрат талбайд 20-30 литр ус орохоор бодож долоо хоногт гурваас дөрвөн удаа услах бөгөөд гандуу үед өдөр бүр услах хэрэгтэй.

Усалгаа хийх аргыг Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2010 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 234 дүгээр тушаалын 2 дугаар хавсралт “Усжуулалтын систем, түүний байгууламж” БнбД 33-09-10-аас сонгон суурилуулах шаардлагатай.

Усалгаа: Ургамлын усны хэрэгцээг зориудаар хангах үйлдлийг усалгаа гэнэ.

Усалгааны арга: Усыг талбайд түгээн тараах үйлдлийг усалгааны арга гэнэ. Усалгааг хийдэг олон арга, технологи байдаг.

Усалгааны үндсэн аргууд:

- Гадаргуугаар услах усалгаа;
- Бороожуулах усалгаа;
- Мананжуулах усалгаа;
- Дуслын усалгаа;
- Хөрсөн дотроос услах усалгаа;
- Лиманы усалгаа.

Талбайн гадаргуугийн байдал, хөрсний нөхцлөөс хамааруулан усалгааны аргыг сонгох

Хүснэгт 33 Усалгааны систем

Усалгааны арга	Давжсан хөрстэй	Хөнгөн хөрстэй	Хүнд хөрстэй	Атриажсан рельефтэй	Хэвгий ихтэй	Үс дутагдалтай	Салхи ихтэй
Гадаргуугийн	+	x	+	-	x	x	+
Бороожуулах	x	+	-	+	+	+	x
Мананжуулах	x	+	+	+	+	+	x
Дуслын	+	+	+	+	+	+	+



Хөрсөн дотроос	+	+	+	-	+	+	+
Лиманы	-	x	+	-	+	-	+

Хүснэгт 34 Усалгааны систем


Усалгааны арга	Хөрсийг чийглэх	Агаарыг чийглэх	Чийгээр цэнэглэх	Хөрсийг угаах	Бордох усалгаа	Ургамал хамгаалал	Хүйтнээс хамгаалах
Гадаргуугийн	+	x	+	+	x	-	x
Бороожуулах	+	+	+	-	+	+	+
Мананжуулах	+	+	-	-	-	-	+
Дуслын	+	-	-	-	-	-	-
Хөрсөн дотроос	+	-	x	-	-	-	-
Лиманы	+	-	+	x	x	-	-

Тайлбар: (+) – хэрэглэнэ, (x) – хааяа хэрэглэнэ, (-) – хэрэглэхгүй

Дуслын усалгаа: Энэ нь дусал үүсгэгч төхөөрөмж ашиглан ургамлын үндэсний орчимд усыг дусал хэлбэрээр өгч хөрсийг чийглэхийг хэлнэ.

Энэ аргын давуу тал нь усалгааны усыг дусаагуурын тусламжтайгаар таримал бүрд оноон өгч, усаар тасралтгүй хангахад оршдог. Дуслын усалгаагаар талбайг нийтэд нь усалдаггүй, зөвхөн тухайн таримлын үндэсний систем тархах орчны хөрсийг чийглэдэг тул усны нөөц багатай, хуурай халуун цаг агаартай нутагт хэрэглэхэд хамгийн их үр дүнг өгдөг байна. Дуслын усалгааны систем нь дараах эд ангиудаас бүрддэг. Үүнд:

- ус сорох ба шахах шахуурга,
- ус шүүх шүүр,
- бордооны сав,
- ус дамжуулах хоолой,
- дуслын шугам хоолой,
- хэмжих хэрэгслүүд,
- удирдлагын компьютер.



Зураг 40 Дуслын усалгааны системийн схем

Дуслын усалгааны системийг бичил бороожуулагч системтэй хослуулан хэрэглэвэл таримлыг агаарын гандалтад оруулдаггүй, ургамлын иш, навчийг угааж цэвэрлэх, сэргүүцүүлэх ач холбогдолтой. Дуслын усалгааны системийн ус дусаагуур болон гуурсан хоолойнууд, бичил



бороожуулагчийн ус шүршигч хушуу зэрэг нь амархан бөглөрдөг тул усалгааны усыг сайн шүүсэн байх шаардлагатай. Дуслын усалгаагаар бүх төрлийн хүнсний ногоо, жимс, жимсгэний мод бут, томс, цай, кофе зэрэг таримлыг усалдаг. Үр тариа, тэжээлийн болон тосны ургамлыг услахад эдийн засгийн хувьд үр ашиг багатай байдаг.

Давуу тал:

- Усалгааны ажлын хөдөлмөр зарцуулалт маш багатай,
- Хөрсний бүтцийг эвддэгүй,
- Усалгааны ажилд агаарын саатал гардаггүй,
- Харанхуй шөнө ч усалгааг хийдэг,
- Усалгааны нормыг 30-60 хувиар бууруулдаг,
- Тэгш бус гадаргуутай, хэвгий ихтэй талбайн хөрсийг жигд услаж болдог,
- Хөрсний гадаргуугаас уурших чийгийн ууршилт багатай,
- Хөрсний шим тэжээлийн бодис угаагдаж алдагдахгүй,
- Таримлын үндэсний систем тархсан орчны хөрсийг чийглэх тул хог ургамал бага ургадаг,
- Усалгааны үед ургамлын иш, навч нордоггүй тул зарим төрлийн өвчин, хортон шавж гарах нь багасдаг,
- Усалгааны устай хамт бордоог хөрсөнд өгөх бололцоотой,
- Усалгааны системийг угсрал, салгах, зөөвөрлөх, тээвэрлэхэд хялбархан, дуслын шугам хоолойны дээгүүр хучлагаар хучиж хөрсний дулааны хангамжийг нэмэгдүүлж, чийгийн ууршилтыг багасгадаг,

Манай оронд голлох нэрийн таримлын усалгааны горим, услалтын ба усалгааны нормыг тариалангийн үндсэн бүс бүрт хийсэн олон жилийн туршлага судалгааны ажлын үр дүнгээр тогтоож үйлдвэрлэлд зөвлөсөн байдаг. Энэхүү жишиг нормыг баримтлан тухайн үеийн агаарын температур, орсон хур тунадасны хэмжээ, таримлын сортын онцлогт тохируулан ихэсгэх буюу багасгах зэргээр өөрчилж зохицуулан мөрдөнө. Тухайлбал, тариалалт хийсэн жилийн агаарын температур нь олон жилийн дундаж хэмжээнээс 1 градусаар нэмэгдэх буюу буурах тутамд таримлын усалгааны нормыг 60- 80 м³/га хэмжээгээр ихсэж буюу багасгаж зохицуулна.

Хүснэгт 35 Усалгааны дундаж норм, услах тоо

Таримлын нэр	Бүс нутаг							
	Ойт хээр		Тал хээр		Их нууруудын хотгор		Говь	
Олон наст өвс	1800-2000	4-5	2100-2400	5-6	2500-2800	9-10	3600-4000	8-9
Тэжээлийн нэг наст	1500-1800	4-5	1800-2200	7-8	2400-2800	6-7	2600-3000	8-9
Хүнсний ногоо	2200-2500	6-7	2600-3200	7-9	3500-3900	8-10	3600-4000	10-12

3.9 Ногоон технологи ашиглах тухай зөвлөмж

Монгол улсын их хурлын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан Ногоон хөгжлийн бодлогын 3.1.2-т “Ногоон барилгын үнэлгээний систем, эрчим хүчиний аудит зэрэг ногоон шийдэл, эрчим хүчиний хэмнэлттэй, дэвшилтэт технологи, стандартыг нутагшуулан нэвтрүүлж, эдгээрийг дэмжих урамшуулал, хөнгөлөлтийн механизмыг хэрэгжүүлж, барилгын дулааны алдагдлыг 2020 онд 20 хувь, 2030 онд 40 хувиар тус тус бууруулах” гэж заасан бөгөөд тус бодлогод ногоон барилга гэж гэж хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөөгүй материал ашигласан, дулааны алдагдал хамгийн бага байх хийцтэй, агаарт ялгаруулах хаягдал багатай халаалтын шийдэлтэй, эрчим хүч, нөөцийн хэмнэлт үр ашигтай, хур тунадасны усыг хуримтлуулж ашиглах, хаягдал бохир



усаа цэвэрлэж зайлуулах технологи бүхий, тав тухтай орчныг бүрдүүлсэн барилга байгууламжийг хэлнэ гэж тодорхойлсон байна

Энэхүү нөхцлийг хангасан барилга, байгууламж барьж байгуулахад “Тэсрэх материалын агуулах”-д дараах технологийг нэвтрүүлэх шаардлагатай юм.

- Гадаад гудамж талбайн гэрэлтүүлэгт нар, салхины бага чадлын эх үүсвэрээр ажилладаг гэрэлтүүлэг сууринуулах
- Дулаан алдагдлыг бууруулах технологийг судлан барилга, байгууламжид нэвтрүүлэн дулаан алдагдалыг 20-30% хүртэл бууруулах
- Төслийн талбайн хэтийн төлөв хүчин чадалтай уялдуулан бохир ус цэвэрлэх байгууламжийг төлөвлөх зэрэг болно.

3.10 Химиин хорт болон аюултай бодис тээвэрлэх үеийн сөрөг нэлээллөөс сэргийлэх арга хэмжээний зөвлөмж

Химиин бодисыг тээвэрлэх үед байгаль орчин, аялал жуулчлалын сайд, эрүүл мэндийн сайд, онцгой байдлын ерөнхий газрын даргын 2009 оны 02 сарын 03-ны өдрийн 28/40/29 дүгээр хамтарсан тушаал баталсан “хорт болон аюултай бодисыг хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам”-ыг баримтлах ба энэ журмын дагуу дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөмж болгож байна.

- ✓ Химиин хорт болон аюултай бодисыг анхааруулах аюулын шинж чанаарын тухай санамж байрлуулсан, техникийн болон аюулгүйн шаардлага хангасан зориулалтын буюу тухайн ачааг тээвэрлэхэд тусгайлан бэлтгэсэн тээврийн хэрэгслээр зөвхөн тогтоосон маршрутын дагуу тээвэрлэнэ.
- ✓ Химиин хорт болон аюултай бодисыг тухайн бодисын хор аюулын лавлах мэдээлэлд заасан зааврын дагуу тээвэрлэнэ.
- ✓ Тээвэрлэлтийн үед ачаа унах, сав баглаа боодол гэмтэх, холилдооос урьдчилан сэргийлж тэдгээрийг зөв байрлуулж, хөдөлгөөнгүй сайтар бэхэлж ачих ба шингэн бодисын хувьд савны амыг дээш харуулан босоогоор байрлуулна.
- ✓ Химиин хорт болон аюултай бодисын ангиллын “а” зэрэглэлийн бодисыг зөвхөн өдрийн цагаар ачиж буулгах ба энэ үед хор аюулын лавлах мэдээлэлд заасан зааврыг хатуу сахина.
- ✓ Химиин хорт болон аюултай ачаа тээвэрлэх тээврийн хэрэгслийн хурд 25-30 км/цаг-аас хэтрэхгүй, 2 тээврийн хэрэгслийн хоорондын зайд 50 метрээс багагүй байвал зохино.
- ✓ Химиин хорт болон аюултай бодисын хайрцаг, сав нь гэмтэлтэй, тээврийн хэрэгслэл бүрэн бус, баримт бичиг зөрчилтэй, анхааруулга, тэмдэг тэмдэглээгүй байвал тээвэрлэлт хийхийг хориглоно.
- ✓ Химиин хорт болон аюултай бодисыг тээвэрлэх тээврийн хэрэгслийн жолооч болон түүнийг дагалдан явах ажилтанд химиин бодис бүрийн хор аюулын лавлах мэдээлэл, аюулгүй ажиллагааны зааварчилгаа, болзошгүй ослын үед ажиллах төлөвлөгөө, тээвэрлэх маршрут зэргийг танилцуулж, гарын үсэг зуруулна.
- ✓ Тээвэрлэх үед бодисын сав баглаа, боодлын битүүмжлэл алдагдах, ачаа нурах зэрэг зогсох шаардлага гарсан тохиолдолд уг аюултай ачааг тээвэрлэж яваа тээврийн хэрэгслээс хоёр тийш 100 м зайд “орохыг хориглоно” гэсэн тэмдгийг байрлуулна.
- ✓ Тээвэрлэлтийн явцад болзошгүй аюул учирсан тохиолдолд хэрэглэх хор уршгийг арилгах зориулалтын багаж, хэрэгсэл /галын хор, хүрз, лоом, сүх зэрэг багаж хэрэгсэл, шуудайтай элс, хувин гэх мэт/, хор саармагжуулах бодис, уусмалаар тээврийн хэрэгсэл бүр хангагдсан байна. Тээврийн хэрэгслийн утааны янданг радиоторын тал руу байрлуулна.
- ✓ Химиин хорт болон аюултай бодис тээвэрлэх маршрутыг аль болох хөдөлгөөн багатай, тэгш сайн байхаар сонгож, хэзээ, хаанаас тээвэрлэх талаархи мэдээллийг тухайн орон нутгийн онцгой байдлын асуудал эрхэлсэн болон замын цагдаагийн байгууллагад урьдчилан мэдэгдэж зөвшөөрөл авах ба аюулгүй байдлыг ханггуулсан байна.



- ✓ Химиин хорт болон аюултай бодис тээвэрлэсэн тээврийн хэрэгслийг хот, суурин газрын дотор болон ойролцоо удаан хугацаагаар зогсоохыг хориглоно.
- ✓ Химиин хорт болон аюултай бодис тээвэрлэсэн тээврийн хэрэгслэлийг сайтар цэвэрлэж, хоргүйжүүлнэ.
- ✓ Химиин хорт болон аюултай бодис тээвэрлэх бусад шаардлагыг аюултай ачаа тээвэрлэх техникийн нөхцөл, стандартад тусгана.
- ✓ Ашиглах, устгах үйл ажиллагаа эрхлэгч нь химиин хорт болон аюултай бодисыг тээвэрлэх үйл ажиллагааг 2 талын хооронд байгуулсан гэрээний дагуу өөр байгууллагаар гүйцэтгүүлж болно. Тээвэрлэгч нь энэхүү журамд заасан шаардлагыг биелүүлж, тээвэрлэлтийн үеийн аюулгүй ажиллагааг хангаж ажиллах үүрэг хүлээнэ.
- ✓ Химиин хорт болон аюултай бодисыг хүн, мал, амьтан болон өөр бүтээгдэхүүнтэй хамт тээвэрлэхийг хориглоно.
- ✓ Химиин хорт болон аюултай бодисыг цуваагаар тээвэрлэх үед дараах шаардлагыг биелүүлнэ
- ✓ Тээвэрлэлтийн аюулгүй байдлыг хариуцахаар томилогдсон ажилтан (цувааны ахлагч) цувааг зохион байгуулж, зөвшөөрөгдсөн маршрутын дагуу замын хөдөлгөөний дүрмийг баримтлан, химиин хорт болон аюултай бодисыг тээвэрлэх үйл ажиллагааг удирдана.
- ✓ Цувааны ахлагч цувааны эхний машинд явах бөгөөд тээвэрлэж буй ачаа, цаг агаарын нөхцөл, цуваанд яваа техник хэрэгслийн байдал зэргийг харгалзан бүх төрлийн замд хурд ба машин хоорондын зайд тохируулж явах үүрэгтэй;
- ✓ Цувааны эхний болон сүүлчийн тээврийн хэрэгсэл “цуваа” гэсэн тод бичлэгтэй байх ба цуваанд эзлэх дугаарыг тээврийн хэрэгсэл бүрийн урд болон ар талд харагдахуйцаар жигд байрлуулна;
- ✓ Химиин хорт болон аюултай бодис тээвэрлэх цувааны эхэнд хамгаалалтын машин, төгсгөлд нөөц тээврийн хэрэгсэл явах ба өдрийн цагт ойрын гэрлээ асааж явна.

3.11 Химиин хорт болон аюултай бодис хадгалах үеийн сөрөг нөлөөллөөс сэргийлэх арга хэмжээний зөвлөмж

Химиин бодисыг тээвэрлэх үед Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайд, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2009 оны 02 сарын 03-ны өдрийн 28/40/29 дүгээр хамтарсан тушаалаар баталсан “Хорт болон аюултай бодисыг хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам”-ыг баримтлах ба энэ журмын дагуу дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөмж болгож байна.

- ✓ Химиин хорт болон аюултай химиин бодисыг зориулалтын агуулахад, хор аюулын лавлах мэдээлэлд заасан нөхцөлд хадгална;
- ✓ Химиин хорт болон аюултай бодисын агуулахыг хүн ам оршин суугаа газраас 300-аас доошгүй метрийн зайд, үер усанд автхааргүй байрлалд байрлуулах ба агуулах нь галд тэсвэртэй материал, хийцтэй, болзошгүй ослын үед хөрсөнд болон гадагш бодис алдагдаарагүй шал (цементэн болон плитган), бат бэх хамгаалалт бүхий цонх, хаалга, үерийн далан, хамгаалалтын сувагтай байна.
- ✓ Химиин бодисын агуулах нь хэд хэдэн хэсгээс бүрдсэн тохиолдолд тэдгээрийг хадгалах бодисын хэмжээнээс хамаарч гал тархах боломжийг хязгаарласан зайд байрлуулах ба хэсэг бүр нь дотроо хамт хадгалж болох бүлэг бодисыг тусад нь хадгалах зориулалт бүхий өөр хоорондоо битүү тусгаарлагдсан өрөө тасалгаатай байна;
- ✓ Химиин бодисын нэг агуулахад 500 тонноос, агуулахын доторхи нэг тасалгаанд 50 тонноос ихгүй бодис хадгална;
- ✓ Химиин бодисыг хүний нүдний түвшингээс дээш түвшинд байрлах тавиур дээр тавихыг хориглох бөгөөд химиин бодисын тавиур нь гулсаж унахаас хамгаалсан хаалт, саадтай байна;
- ✓ Химиин бодисыг шалан дээр хурааж хадгалах тохиолдолд хүн явах зам гарган байрлуулах



- ба гарцыг хааж болохгүй;
- ✓ Шингэн химийн бодисыг хагардаггүй эсвэл бат бөх хагардаггүй давхар савалгаатай саванд хадгалах ба хадгалах агуулахын температур нь тухайн бодисын хадгалах нөхцөлд тохирсон байвал зохино;
 - ✓ Дэгдэмхий эсвэл хурц үнэртэй химийн бодисыг шаардлага хангахуйц агааржуулалтын системээр тоноглогдсон агуулахад хадгална;
 - ✓ Бүх химийн бодис, ялангуяа шатамхай шингэнийг халаалтын хэрэгсэл, системээс хол, шууд нарны гэрэл тусахааргүй нөхцөлд хадгална.
 - ✓ Химийн бодисын агуулахад асгарч гоожсон эсвэл эвдэрхий сав, баглаа боодлой химийн бодисыг хадгалахыг хориглоно;
 - ✓ Химийн бодисын агуулахад ил гал гаргах, шүдэнз зурахыг хориглоно;
 - ✓ Химийн хорт болон аюултай бодисыг юулэх, савнаас нь хэсэгчлэн аваходаа зөвхөн тусгай тоноглосон /салхивч, агааржуулалтын систем, шингэний шахуурга гэх мэт/ агуулахад гүйцэтгэнэ;
 - ✓ Химийн бодисын агуулах нь ажиллагсдын гар угаах, усанд орох, хувцас солих нөхцлөөр хангагдсан байна;
 - ✓ Агуулахад хадгалж буй химийн бодисын хор, аюулын шинж чанараас хамааруулан зохих анхааруулах тэмдэг, дохио үг, аюулын тухай тэмдэглэгээг агуулахын гадна болон дотор харагдахуйц байрлалд тодор зурж, бичиж байрлуулна /Жишээлбэл: галын аюултай, хортой гэх мэтийг анхааруулсан тэмдэг, “Шатамхай шингэн”, “Хортой”, “Идэмхий” гэх мэт дохио үг/;
 - ✓ Химийн бодисын агуулах нь гаднын хүн үл нэвтрэх хаалт, цоожтой байх ба онцгой хортой, аюултай бодис хадгалах агуулах нь зөвхөн хариуцагч этгээдийн хувийн тэмдэг бүхий лацаар битүүмжлэгдсэн байна;
 - ✓ Агуулах нь хадгалж буй бодисын ангилал, нэр төрөл, тоо хэмжээг тусгасан байнгын бүртгэлтэй байна;
 - ✓ Химийн бодисын агуулахад хүнсний зүйл хадгалах, хэрэглэхийг хориглоно.

3.12 Химийн бодисын сав, баглаа боодлын хог хаягдлын талаар авч хэрэгжүүлэх зөвлөмж

Химийн бүтээгдэхүүн, бодисын хаягдал, ашиглалтын хугацаа дууссан, чанарын шаардлага хангахгүй болсон бодис, холимог болон сав баглаа боодлыг “Химийн хорт болон аюултай бодис тээвэрлэх, хадгалах, ашиглах, устгах журам”-ын 2.3.1.2-т заасны дагуу тээвэрлэх ёстой.

- ✓ Заасан аргачлалын дагуу байгаль орчин, эрүүл ахуй болон гамшгаас урьдчилан сэргийлэх улсын байцаагч нарыг байльцуулж зориулалтын цэгт устгана.
- ✓ Химийн бүтээгдэхүүн, хорт болон аюултай бодисын сав баглаа боодлыг ахуйн зориулалтаар ашиглахыг хориглоно.

3.13 Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээний зөвлөмж

- ✓ Ус ашиглуулах дүгнэлт гаргуулж, зөвшөөрөл авч, гэрээ байгуулж байх /Усны тухай хууль 26.1, 27.1, 28.1, 28.2, 28.4, 28.6, 28.8, 28.11, 28.18, 29.1, 29.2, 30.1 /
- ✓ Ус ашигласны төлбөрөө тогтмол төлж байх /Усны тухай хуулийн 31.1/
- ✓ Усны хэрэглээг тоолууржуулах, MNS ISO 4064-15 2016 стандартын дагуу мэргэжлийн байгууллагаар сууринуулах /Усны тухай хууль 30.1.4, УАХТЖ /
- ✓ Ажилчдын унд ахуйн хэрэглээг хангаж буй усны чанар, найрлагад мэргэжлийн итгэмжлэгдсэн лабораториор шинжилгээ хийлгэж байх /MNS 0900:2018 стандартын дагуу/
- ✓ Байгаль орчны менежментийг төлөвлөгөөг жил бүр боловсруулж эрх бүхий байгууллагаар батлуулж байх



- ✓ Станцын өргөтгөлийн хүрээнд химиин бодисын агуулахыг MNS 6458 : 2014 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химиин хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлагын дагуу барьж байгуулах
- ✓ Химиин хорт болон аюултай бодисын тухай хуулийг тогтмол мөрдөж ажиллах /Химиин хорт болон аюултай бодисын тухай/ хуулийн 8,9,10,12,13,14,17,18 дугаар зүйл, заалтууд/
- ✓ Байгаль орчны дотоод хяналтын журам боловсруулан ажиллах /Засгийн газрын 311-р тогтоол/
- ✓ Гамшигаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах
- ✓ Байгаль орчны хамгаалах нөхөн сэргээх зардлыг жил бүр төсөвтөө тусгах /БОХТХ 31.4/
- ✓ Экологийн паспорт хөтлөх /БОХТХ 31.6/
- ✓ Байгаль орчны мэргэжилтэнтэй байх /БОХТХ 31.7/
- ✓ Газрын төлбөрийг тогтмол төлж байх /ГТХ 7.1 ГТХ 35.3.3/
- ✓ Газар эзэмших гэрээнд заасан нөхцөл, болзлыг биелүүлэх /ГТХ 35.3.1/
- ✓ Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг тогтоосон журмын дагуу хийлгэж байх /ГТХ 35.3.4 ГТХ 58.5/
- ✓ Нийт ажилтнуудыг хамруулсан байгаль орчны сургалтыг байгаль орчны улсын байцаагчдыг оролцуулан зохион байгуулах
- ✓ Төслийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа ШТС нь “Шатахуун түгээх станц. Техникийн ерөнхий шаардлага” MNS 4628:2013 стандартын шаардлагыг хангаж байх шаардлагатай.
- ✓ Гал түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, галын иж бүрэн багаж сууритуулах, холбогдох байгууллагаар галын дүгнэлт гаргуулж байх
- ✓ Төсөлд ашиглагдах тээврийн хэрэгсэлүүдийн агаар бохирдуулсаны төлбөрийг жил бүр тогтмол төлж байх /АТХ- 29.1 АБТХ- 9.3/
- ✓ Төслийн ажилчидыг тогтмол эрүүл мэндийн үзлэгт хамруулж байх
- ✓ Утааны яндан нь утааны хийг хянах сорыцын цэг, оврын гэрэлтуулэг болон аянга зайлзуулах системтэй байх. Мөн үзлэг шалгалт хийх цахилгаан шаттай байх;
- ✓ Станцын үндсэн барилга нь тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээ явуулах боломжтой засварын талбайтай байх;
- ✓ Засварчдын ажлын байр болон тоног төхөөрөмжийн сэлбэг материал хадгалах агуулахтай байх;
- ✓ Бүх барилга, байгууламжууд нь нэгдсэн холбоо, дохиоллын системтэй байх;
- ✓ Бүх барилга, байгууламжууд нь галын аюулаас хамгаалах нөхцөлийг хангасан гал унтраах тоноглолоор бүрэн тоноглогдсон байх /галын усны нэгдсэн шугам, галын хор, галын дохиолол гэх мэт/;
- ✓ Үйлдвэрийн зам, талбайд тоггсон борооны усыг төвлөрсөн санд хуримтлуулж дахин ашиглах системтэй байх
- ✓ Харуул хамгаалалтын байр шинээр барих, хашааны гадна машины зогсоолын талбай байгуулах
- ✓ Станцын газар нутгийг хамарсан газардуулга, аянгын хамгаалалтын системтэй байх
- ✓ Зуухны үнсийг нойтон байдлаар зайлцуулж, үнсэн сангаас усыг эргүүлэн ашиглах схемтэй байх
- ✓ Станцын одоогийн байгаа нүүрс хадгалах талбайгаас тусад нь 50 МВт-ын станцад зориулсан нүүрс хадгалах талбайг шинээр бэлтгэх. Уг талбайд байгаа хуучин хүчилтөрөгчийн станцыг буулгаж, өөр газарт хүчилтөрөгчийн станцыг шинээр барих
- ✓ Үнсэн сангийн бетон далангийн гадна талаар төмөр сараалжин хашаа хийх
- ✓ Үнсэн сангудыг байгаль орчинд ээлтэй шинэ технологиор хийж, эко систем бүрдүүлэх
- ✓ Станцын ус хангамжийн эх үүсвэрт мэргэжлийн байгууллагаар нөөцийн судалгаа хийлгэн, дүгнэлт гаргуулах
- ✓ Одоогийн ашиглаж байгаа 4 ширхэг гүний худгийг цаашид ашиглаж болох талаар техникийн дүгнэлт гаргуулах. Шаардлагатай бол засварлах;



- ✓ Гүний худгуудын барилгыг сэргээн засварлах
- ✓ Шинээр барих худгийн геодези болон геологийн судалгаа хийлгэж, холбогдох төрийн захиргааны байгууллагатай зөвшлилцөх
- ✓ Станцын өргөтгөх төслийн ажлын зураг, төсөл боловсруулах даалгаварын дагуу гүйцэтгэх
- ✓ Байгаль орчны нарийвчилсан үнэлгээний тайланг 5 жил тутамд нэмэлт тодотгол хийлгэж байх
- ✓ *Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10¹-т* заасны дагуу Байгаль орчны төлөвлөгөөт аудитыг 2 жил тутамд хийлгэж байх хэрэгтэй.



ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ: ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ, МЕНЕЖМЕНТ

Төслийн эрсдлийн үнэлгээг Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд, Эрүүл мэндийн сайд, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2012 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн А-50- /378/565 дугаар хамтарсан тушаалын хоёрдугаар хавсралтын дагуу үндсэн зарчмуудад нийцүүлэн төсөлд ашиглагдаж буй химийн бодисын хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх серөг нөлөөлөл болон болзошгүй осол аюулын эрсдлийг тодорхойлох замаар хийж гүйцэтгэлээ. Эрсдлийн үнэлгээнд химийн бодисын шинж чанар, байгаль орчин, хүний эрүүл мэндэд үүсгэж болох болзошгүй эрсдэл, осол аюулыг урьдчилан тодорхойлж эрсдлээс сэргийлэх, бууруулах арга зөвлөмжийг тусгасан болно.

“Дорнод бүсийн эрчим хүчиний систем” ТӨХК нь Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас Химийн хорт болон аюултай бодисыг экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, ашиглах, худалдах аж ахуйн үйл ажиллагааны тусгай 0001528 дугаар зөвшөөрөлтэй. Химийн хорт болон аюултай бодисыг ашиглах тусгай зөвшөөрөлийн хүрээнд нийт 17 төрлийн бодис ашиглаж байна.

4.1 Эрсдлийн үнэлгээг хийсэн аргачлал

Төслийн хүрээнд хэрэглэгдэх химийн бодис, материалуудын үзүүлэх физикийн аюул, хүний эрүүл мэнд болон байгаль орчинд учруулах хор, аюулуудыг антилах, зэрэглэх ба хаягжуулах үүднээс хангалттай, найдвартай ба баталгаатай мэдээлүүдийг цуглуулахын тулд бодис, материал тус бүрийн химийн аюулын лавлах мэдээллийг (MSDS) судлаж өгөгдлүүдийг цуглууллаа;

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, эрүүл мэндийн сайдын 2015.10.08 өдрийн хамтарсан тушаалаар батлагдсан ‘Химийн хорт болон аюултай бодисын ангилал’-ын дагуу цуглуулсан өгөгдлүүдийг ашиглан ангиллын шалгуур үзүүлэлтийн дагуу химийн бодис, материалуудын хор, аюулыг Ангилах, Зэрэглэх болон Хаягжуулах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Үүнтэй холбогдуулан химийн бодис, материал тус бүр дээр дээрх ангиллуудын дагуу хор, аюулын ангилал ба зэрэглэл, аюулын дурс тэмдэглэгээ, сээрэмжлүүлэх үг, аюулын болон анхааруулах тэмдэглэгээ, эрсдэл тохиолдсон үед хариу арга хэмжээ авах зөвлөмжүүдийг тусгалаа. Тус төсөлд ашиглагдаж буй химийн бодис, материалууд нь олон нэр төрлийн бодис, холимгууд учраас эрсдлийн үнэлгээг аль болохоор нуршилгүйгээр хүснэгт, кодчилсон тэмдэглэгээ, тэдгээрийн тайлбарыг оруулсан байдлаар хийж гүйцэтгэлээ.


Химийн бодисын эрсдлийн ерөнхий дүр зургийг (зураг 5.1) харуулбал:



Зураг 41 Химийн бодисын эрсдлийн дүр зураг



Схем 5.1. Химиин бодисын аюулыг тодорхойлох загвар



Дээрх зургийн дагуу Химиин бодисын эрсдэл нь хортой болон аюултай нэгдлүүд, тэдгээрээр өртөх замууд болон өртөгч бүлэг гэсэн 3 хүчин зүйлсийн нэгдлээр тодорхойлогдоно.

Энд:

Хортой, аюултай нэгдлүүд: Хүний эрүүл мэнд, байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд эрсдэл учруулахийц тун хэмжээтэй химиин бодис

Өртөгчид: Тухайн химиин бодисын өртөж болзошгүй хүн ам, амьтан, ургамал



Дамжих зам: Химиин бодисоор хордох замууд (амаар, арьсаар болон амьсгалаар) болон физик нөлөөллүүд

Төсөлд хэрэглэгдэх химиийн бодис, материал нэг бүр дээр эрсдлийн үнэлгээг схем 5.1-д үзүүлсэн загварын дагуу хийж гүйцэтгэлээ.

Эрсдэлийн хамрах хүрээ:

Төслийн болзошгүй эрсдэл нь химиийн бодисуудыг тээвэрлэх, агуулахад хадгалах, ашиглах үйл ажиллагааны хүрээнд үүсэж болзошгүй.

4.2 Төслийн хүрээнд импортлох, ханган нийлүүлэх химиийн бодис, материалуудын хор, аюулын ангилал

НҮБ-аас санаачилж хэрэгжүүлсэн GHS системээс өмнө дэлхийн улс орнуудад химиийн бодисуудын хор, аюулын ангиллын тал дээр олон өөр зохицуулалт, журмууд үйлчилж байсан билээ. Эдгээр системүүд нь хэдийгээр агуулга, чиг хандлагын хувьд төстэй байсан хэдий ч ижил төрлийн хор, аюулыг өөр өөр байдлаар тусгасан ангилал болон зэрэглэл, стандартуудыг хэрэглэж байлаа.

Олон улсын хэмжээнд химиийн бодисын худалдаа өргөжсөн, хяналт шалгалт сүл байгаа хөрш орнуудад боломжтой бүхий л байдлаар туслах үүдиэс дэлхийн энэхүү чиг хандлагын хэрэгцээ, шаардлага урган гарч ирсэн билээ.

GHS систем нь хэдийгээр НҮБ-ын хуульд зааснаар албадлагын чанартай биш боловч химиийн бодисын хор, аюулын ангиллын өөр өөр системүүдийг халж бүх улс орнууд нийтээр даган мөрдөж байх дэлхий нийтийн стандартыг бий болгох зорилготой юм.

Хүснэгт 31-д төслийн хүрээнд импортлох, ханган нийлүүлэх химиийн бодис, материалуудын хор, аюулын ангилал, зэрэглэлийн элементүүд болон аюулын нэмэлт тэмдэглэгээг GHS/CLP-Дэлхий нийтийн зохицуулалтын системийн стандарт аргачлалын дагуу үзүүллээ.



Хүснэгт 36 Төслийн хүрээнд импортлох, хадгалах, худалдаатах хамийн бодис, материслудын хор, аюулын ангилал

Бодисын нэршил			Химийн томъёо	CAS дугаар	Хор, аюульн ангилаал	Аюульн тэмдгэлэгээ	Дурс тэмдгэлгээ, сэргэжлиүүлэх үт
№	Монгол нэр	Олон улсын нэр					
1	Аммоний гидроксид	Ammonium hydroxide	NH ₄ OH	1336-21-6	<ul style="list-style-type: none"> Арьс түлэх - 1B Усан орчин (хурц)-1 	H314 H400	GHS05 GHS09 Аюултай
2	Аммоний хлорид	Ammonium chloride	NH ₄ Cl	12125-02-9	<ul style="list-style-type: none"> Хүрц хоруу чанар- 4 Нуд цочроох- 2 	H302 H319	GHS07 Болгоомжил
3	Бензол	Benzene	C ₆ H ₆	71-43-2	<ul style="list-style-type: none"> Шагамхай шингэн - 2 Хорт хавдар - 1A Мутаген - 1B Амьсталаар учруулах аюул - 1 Давтан өргөтгөөр тодорхой эрхтний байлж хордуулах- 1 Арьс цочроох - 2 Нуд цочроох - 2 	H225 H350 H340 H304 H372 ** H315 H319	GHS02 GHS08 GHS07 Аюултай
4	Хүхрийн хүчил	Sulfuric Acid	H ₂ SO ₄	7664-93-9	<ul style="list-style-type: none"> Металыг коррозид оруулах - 1 Арьс түлэх - 1A Нудийг нодтойгоор гэмтэх - 1 	H290 H314	GHS05 GHS09 Аюултай
5	Этанол	Ethanol	C ₂ H ₅ OH	64-17-5	<ul style="list-style-type: none"> Шагамхай шингэн - 2 Нуд цочроох - 2 	H225 H319	GHS02 GHS07 Аюултай
6	Натрийн гидроксид	Sodium hydroxide	NaOH	1310-73-2	<ul style="list-style-type: none"> Арьс түлэх-1A 	H314	GHS05 Аюултай
7	Калийн гидроксид	Potassium hydroxide	KOH	1310-58-3	<ul style="list-style-type: none"> Хүрц хоруу чанар- 4 Арьс түлэх - 1A 	H302 H314	GHS05 GHS07 Аюултай
8	Давсны хүчил	Hydrochloric acid	HCl	7647-01-0	<ul style="list-style-type: none"> Нэг удаагийн өртөлтөөр тодорхой эрхтнийг байлж хордуулах-3 Арьс түлэх-1B 	H335 H314	GHS05 GHS07 Аюултай
9	Натрийн фосфат	Trisodium phosphate	Na ₃ PO ₄	7601-54-9	<ul style="list-style-type: none"> Арьс цочроох - 2 Нуд цочроох - 2 	H315 H319	GHS07 Болгоомжил



**“Дорнод бусин” эрчим хүчиний систем” ТӨХК-ийн Дулааны цахилгаан станц төслийн
Байгаль орчны полоолтуйн парийчилсан үнэлгээний нэмэгт тодотголын тайллан**

10	Глицерин	Glycerol	C ₃ H ₈ O ₃	56-81-5	• Нэг удаагийн өргөлтөөр тодорхой эрхтнийг байж хордуулах - 3 (амьсгалын систем)	H335
11	Эрихром хар	Erochrome black	C ₂₀ H ₁₂ N ₃ NaO ₇ S	1787-61-7	EU-GHS/CLP Regulation (EC) No.1272/2008 дагуу аюултай нэгдэл болон хольц биш.	
12	Метилоранж	Methyl orange	C ₁₄ H ₁₆ N ₃ NaO ₃ S	547-58-0	• Хури хоруу чанар - 3 EU-GHS/CLP Regulation (EC) No.1272/2008 дагуу аюултай нэгдэл болон хольц биш.	H301 GHS06 Аюултай
13	Глюкоз	Glucose	C ₆ H ₁₂ O ₆	59-23-4	EU-GHS/CLP Regulation (EC) No.1272/2008 дагуу аюултай нэгдэл болон хольц биш.	
14	Аммоний молибдат	Ammonium molybdate	(NH ₄) ₆ Mo ₇ O ₂₄ X 4H ₂ O	12054-85-2	EU-GHS/CLP Regulation (EC) No.1272/2008 дагуу аюултай нэгдэл болон хольц биш.	
15	Фенолфталейн	Phenolphthalein	C ₂₀ H ₁₄ O ₄	77-09-8	• Мутаген-2 • Хорт хавдар-1В • Нехөн үржихүй-2	H341 H350 H361F GHS08 Аюултай
16	Метилийн хөх	Methylen blue	C ₁₆ H ₁₈ N ₃ SCl	61-73-4	• Хури хоруу чанар - 4	H302 GHS07 Болгоомжил
17	Трилон-Б	EDTA	C ₁₀ H ₁₄ N ₂ -Na ₂ O ₈	6381-92-6	• Хури хоруу чанар (амаар) - 4 • Давтан өргөлтөөр тодорхой эрхтнийг байж хордуулах - 2 (амьсгалын зам)	H332 H373 GHS08 GHS07 Болгоомжил



Дээрх хүснэгтэд **Схем 5.1-ийн** дагуу **CLP/GHS** олон улсын стандартын дагуу ангилагдсан нэгдлүүдийн хор, аюулын зэрэглэлийн элементүүдийг бодис тус бүрээр үзүүлсэн болно. Үүнд:

- ✓ Аюулын тэмдэглэгээ-Н (Hazard statement) – Аюулын тэмдэглэгээний кодын тайлбарыг “Эрсдлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зөвлөмж” – д дэлгэрэнгүй оруулсан болно.
- ✓ Дүрс тэмдэглэгээ (Pictogram)
- ✓ Сэромжлүүлэх үг (Signal word)
- ✓ Анхааруулах тэмдэглэгээ-Р (Precautionary statement) – Анхааруулах тэмдэглэгээний кодын тайлбарыг “Эрсдлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зөвлөмж” – д дэлгэрэнгүй оруулсан болно.

Хүснэгт 37 Төсөлд хэрэглэгдэх химийн бодис, материалуудын хор, аюулын нэгдсэн дун

Хор, аюулын төрөл зүйл	Хор, аюулын ангиллууд	Тухайн ангиллаар ангилагдсан бодисын тоо
Физикийн аюул	Шатамхай шингэн Хурц хоруу чанар (амаар) Арьс түлэх Арьс цочроох Нүдийг ноцтойгоор гэмтээх Нүдийг цочроох Үр хөврөлийн эсэд мутаци үүсгэх Хорт хавдар үүсгэх Нөхөн үржихүйд нөлөөлөх Нэг удаагийн өртөлтөөр тодорхой эрхтнийг байлж хордуулах Давтан өртөлтөөр тодорхой эрхтнийг байлж хордуулах	2 5 5 2 1 4 2 2 1 2 2
Хүний эрүүл мэндэд учруулах хор, аюул	Усан орчин (хурц) Усан орчин (ужиг)	1 0
Байгаль орчинд учруулах хор, аюул		

4.3 Хүний эрүүл мэндэд учруулах эрдлийн үзлэгээ

Хүснэгт 31-д төслийн хүрээнд импортлох, ханган нийлүүлэх химийн бодис, материалуудын хүний эрүүл мэндэд учруулах хор, аюулын ангилал болон зэрэглэлийг Хүснэгт 32-д үзүүлсэн шалгуур үзүүлэлтүүдийн дагуу бодис тус бүр дээр харуулсан болно. Тухайлбал: хүний эрүүл мэндэд үзүүлэх хор, аюулын эрсдлүүдийг H300-399 (Hazard statement) хүртэлх аюулын тэмдэглэгээгээр болон дүрс тэмдэглэгээ, сэромжлүүлэх үгээр илэрхийлсэн болно.

Хүснэгт 31-д төсөлд хэрэглэгдэх химийн бодис, материалуудад хамаарах хүний эрүүл мэндэд үзүүлэх хор, аюулын ангилал, зэрэглэлийн бүхий л элементүүдийг нэгтгэн үзүүлээ. Эдгээр хүснэгтүүд болон Хүснэгт 31-ийг ашиглан эдгээр ангиллуудаар ангилагдсан бодис, материал тус бүр дээр хүний эрүүл мэндэд учруулах эрсдэл, түүнийг бууруулах зөвлөмжүүдийг аюулын тэмдэглэгээ-Н (Hazard statement: H300-399) болон анхааруулах тэмдэглэгээ-Р (Precautionary statement)-тэмдэглэгээнүүдээс олж үзнэ. (Н болон Р кодуудын тайлбарыг тайландаа дэлгэрэнгүй байдлаар хавсаргасан болно).



Хуснэгт 38 Хүний эрүүл мэндэд учруулах хор, аюулын тодорхойлолт

Хүрц хордлого үзүүлэх	LD ₅₀ (амаар, арьсаар), эсвэл LC ₅₀ (амьсгалаар) өгөгдлүүд дээр үндэслэн хордлогын 5 ангилалд хуваагдана. Эдгээр ангиллуудаас тээвэрлэлт, хэрэглэгч, ажиллагсад болон байгаль орчныг хамгаалахад аль тохирх элементийг нь сонгоно.
Арьс түлэх	4 цагийн туршид арьсанд үйлчилж туршихад нөхөн сэргээгдэшгүй байдлаар арьсыг гэмтээдэг бодисууд юм. Энэ аюулд хамаарах дан бодис болон холимгууд нь зөвхөн 1 ангиллаар зохицуулагдана.
Арьс цочроох	4 цагийн туршид арьсанд үйлчилж туршихад дараа нь нөхөн сэргээгдэх боломжтой байдлаар арьсыг гэмтээдэг бодисууд юм. Энэ аюулд хамаарах дан бодис болон холимгууд нь зөвхөн 1 ангиллаар зохицуулагдана. Хортон шавьж устгалын зэрэг бодисуудын хувьд арьс цочроох тал дээр 1-ээс илүү тэмдэглэгээ буюу <u>зөвлөн байдлаар цочроох</u> гэсэн нэмэлт ангилал хэрэглэгдэнэ.
Нүдийг ноцтойгоор гэмтээх	Нүдний ил хэсэгт үйлчлэхэд салст бүрхүүлийг нь гэмтээх, эсвэл харааны чадварыг муутгах бөгөөд 21 хоногийн дотор уг үйлчилгээ нь бүрэн биш арилах байдлаар үйлчилгээ үзүүлдэг бодисууд бөгөөд энэ ангилалд хамрагдах дан болон холимог бодисууд нь зөвхөн 1 ангиллаар зохицуулагдана.
Нүдийг цочроох	Нүдэнд үзүүлэх үйлчилгээ нь 21 хоногийн дотор бүрэн арилдаг бодисууд бөгөөд энэ ангилалд хамрагдах дан болон холимог бодисууд нь зөвхөн 1 ангиллаар зохицуулагдана. Хортон шавьж устгалын гэх мэт бодисуудын хувьд үйлчилгээ нь 21 эсвэл 7 хоногийн дотор арилж байна уу, үгүй юу гэдгээс хамаарч 1-ээс илүү тэмдэглэгээ буюу 2 дэд ангиллаас аль нэг нь сонгогдож болно.
Үр хөврөл, эс, генийн өөрчлөлт бий болгох	Хүн амын эс болон бие организмд генийн өөрчлөлтийг бий болгогч бодисууд ба энэ ангилалд хамрагдах дан болон холимог бодисууд нь 2 ангилалд, 1-р ангилал нь 2 дэд ангилалд хуваагдана.
Хорт хавдар үүсгэх	Хорт хавдрыг үүсгэх, эсвэл түүний явцыг ихэсгэх үйлчилгээтэй дан болон холимог бодисууд бөгөөд эдгээр нь 2 ангилалд, 1-р ангилал нь 2 дэд ангилалд хуваагдана.
Уран-238 /U238/-ын хувийн идэвх 151 Бк/кг байгаа нь Цацрагийн аюулгүйн нормийн хүснэгт 12.2 /Нүүрсийг цацраг идэвхийн хэмжээнээс нь хамааруулан дараах зориулалтаар ашиглахыг зөвшөөрнө/-д зааснаар (ахуйн хэрэглээ, эрчим хүчний станцад болон бусад зориулалтаар ашиглана) ангилалд хамаарч байна.

Хөрсөнд агуулагдах Кали-40 /K40/-ийн хувийн идэвх 678-855 Бк/кг, Уран-238 /U238/-ын хувийн идэвх 19-525 Бк/кг, Тори-232 /Th232/-ийн хувийн идэвх 15-36 Бк/кг хэмжээтэй байгаа нь Цацрагийн аюулгүйн нормын хүснэгт 11.2-т заасан цацрагийн хяналтад байх шаардлагатай хамгийн бага утга (U238, Th232-1000 Бк/кг, K40-10000 Бк/кг)-аас бага буюу Монгол орны хөрсөнд агуулагдах байгалийн цацраг идэвх изотопын дундаж хэмжээнд байна.

Мөн 2022 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 01 дугаартай хэмжилтийн протоколоос үзэхэд үнсэн сангийн далан дээр /N048⁰07'52.511" E114⁰53'70.031"/ цэгт 0,11-0,16мк3в/цаг, /N048⁰08'28.318" E114⁰56'14.751"/ цэгт 0,11-0,16мк3в/цаг, /N048⁰07'88.553" E114⁰55'77.579"/ цэгт 0,14-0,17мк3в/цаг, /N048⁰07'24.633" E114⁰52'44.258"/ цэгт 0,09-0,12 мк3в/цаг байгаа нь Монгол улсын байгалийн дундаж дэвсгэр түвшин /0,2 мк3в/цаг/-д байна.

Харин тус хэмжилтийн протоколоос харахад /N048⁰07'87.432" E114⁰55'77.165"/ цэгт 0,52-0,67мк3в/цаг, /N048⁰08'62.778" E114⁰56'51.631"/ цэгт 0,42-0,44мк3в/цаг, /N048⁰07'87.432" E114⁰55'77.165"/ цэгт 0,79-0,82мк3в/цаг байгаа нь Монгол улсын байгалийн дундаж дэвсгэр түвшин /0,2 мк3в/цаг/-д зааснаас 2.1-4 дахин өндөр байна.

Сүүлийн 3 жилийн хяналт шинжилгээний хэмжилтийн үр дүнгээс харахад үнсэн сан 1-ийн тунгаагуур хоолойн /Үнсэн сангийн ус гадагшлуулах эхний цорго/, үнсэн сангийн гадна орчимд /Эхний цоргоор урссан тогтоох давхар далангаас гадагшлах 2 дахь цорго/ хийсэн хэмжилтийн дүн өссөн үзүүлэлтгэй байна.

Иймд Дулааны цахилгаан станцаас гарч байгаа хаягдал үнсийг барилгын материал үйлдвэрлэдэг байгууллага аж ахуйн нэгжид ашиглуулахгүй байх мөн үнсэн сангийн орчмын үнсний хаягдалтай хэсгүүдийн хорсийг цацрагийн дэвсгэр түвшний хэвийн нохцолийг хангаж ажиллах шаардлагатай.



5.3 Хог хаягдлын менежментийн стратеги

Хог хаягдлын төвлөрсөн цэгийг бий болгож хог хаягдлын менежментийн диаграммын дагуу хетөлбөрийг боловсруулан, төлөвлөгөөт хугацааны дагуу хог хаягдлыг ангилан ялгаж, бөөгнүүлэн цуглуулах, зайлцуулах, тарж бутрахаас сэргийлэх, устгах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх шаардлагатай. Мэргэжлийн байгууллагаас санал болгож буй хог хаягдлын менежментийн стратеги нь төслийн төлөвлөлтийн үе шатаас эхлэн ашиглалтын үйл ажиллагаа дуусах хүртэлх хог хаягдлын менежментийг хамарна.

Цахилгаан станцын хог хаягдлын удирдлага нь дараах дэс дарааллыг баримталж ажиллана.

- ✓ Төслийн үйл ажиллагаанд ашиглагдах тоног төхөөрөмж, техник хэрэгслийг байгаль орчинд ээлтэй, хог хаягал бага үүсгэх, удаан хэрэглэгдэх бүтээгдэхүүнийг сонгох,
- ✓ Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах,
- ✓ Дахин ашигладаг бүтээгдэхүүнийг ашиглах,
- ✓ Хаягал бүтээгдэхүүнийг дахин боловсруулах,
- ✓ Зөвхөн үүний дараа хог хаягдлыг устгах зэрэг болно.

5.4 Хог хаягдлыг бууруулах

Бүтээгдэхүүнийг худалдан аваходаа гарах хог хаягдлын хэмжээ багатайг сонгох, ашигдалтын явцад хог хаягал бий болгохоос зайлсхийх нь хог хаягдлын хэмжээг багасгах зохион байгуулалтын эхний бөгөөд хамгийн чухал алхам юм. Хог хаягдлыг бий болгох явдлаас зайлсхийхийн тулд хог хаягал ихээр бий болгодог техникийн болон хүний үйл ажиллагаа, бүтээгдэхүүнийг тээвэрлэх үйл ажиллагааны үед эдэлгээ урт, байгальд ээлтэй технологи, техник, тоног төхөөрөмж, хэрэгслүүдийг сонгох нь чухал. Мөн хог хаягдлыг багасгах дараах аргуудыг хэрэглэх нь зүйтэй. Үүнд:

- ✓ Нэг удаагийн, бага хэмжээгээр савалсан бүтээгдэхүүнээс татгалзаж, том савлагаатай бүтээгдэхүүн сонгох;
- ✓ Аль болох цаасгүй технологийг хэрэглэх, үсгийн фонт мөр хоорондын зайнт багасгах, цаасны 2 талыг бүрэн ашиглах;
- ✓ Пластик, резин, хуванцар савнуудыг ангилан овор хэмжээг нь багасгаж, түүхий эд дахин боловсруулах газарт хүргүүлэх;
- ✓ Худалдан авах бүтээгдэхүүний ашиглалтын насжилт, эдэлгээ даах чанарт анхаарч, ногоон худалдан авалтыг дэмжих;
- ✓ Худалдан авах бараа бүтээгдэхүүний сав баглаа боодол болон ашиглаж дууссан бараа материал, бүтээгдэхүүнийг борлуулагчид нь буцаах боломжийг эрэлхийлэх зэрэг болно.

5.5 Хог хаягдлыг ангилан ялгах

Хог хаягдлын хувьд эрүүл мэнд, эрүүл ахуйн асуудлуудыг онцгой анхаарч үзэх бөгөөд ДЦС-ын талбай дахь хог хаягдлыг ангилан цуглуулж, тохиромжтой саванд хадгалан, хог хаягдлын төвлөрсөн цэгт хүргэх ба зарим хог хаягдлыг дахин боловсруулж ашиглах боломжтой хог хаягдлыг ангилан ялгаж, хаягал боловсруулах үйлдвэрүүдэд нийлүүлэх нь зүйтэй. Хог хаягдлыг гарч буй цэг дээр нь ангилан ялгана. Тухайлбал, дахин ашиглах, дахин боловсруулах хаягдлыг ердийн хог хаягдаас ялган авах нь зүйтэй. Хог хаягдлыг тухайн хог хаягал бий болох эх үүсвэр дээр нь ангилснаар дахин ашиглагдах хог хаягдлын ялгах үйл ажиллагааг хөнгөвчлөх давуу талтай. Ахуйн болон үйлдвэрлэлийн хэрэглээнээс үүссэн хог хаягдлыг аюултай, хяналттай болон энгийн гэж 3 ангилан ялгаж эдгээр хог хаягдлыг цэгт хүргэх нь зүйтэй.



Энгийн хог хаягдал:

ДЦС-ын үйл ажиллагааны улмаас үүссэн хяналттай болон аюултай хог хаягдлаас бусад хог хаягдлыг энэ ангилалд хамруулна. Энгийн хог хаягдлыг дахин ашиглах, дахин боловсруулах, шууд устгах хаягдал гэж ангилан хадгална.

Хүснэгт 58 Энгийн хог хаягдлын жагсаалт

№	Үүсэж болзошгүй хог хаягдлын эх үүсвэрийн нэр	Хог хаягдлын код	Хог хаягдлын кодчилсон жагсаалтад орсон нэр
1	Цахилгаан станц	10 01 05	Утааны хийг хүхэргүйжүүлэх кальц суурьтай урвалаас үүсэх хатуу хаягдал
		10 01 06	Утааны хийг хүхэргүйжүүлэх кальц суурьтай урвалаас үүсэх лаг хэлбэрийн хаягдал
		10 01 16	10 01 15-д зааснаас бусад хаягдал усны анхан шатны цэвэрлэгээнээс үүсэх лаг
		10 01 18	10 01 17-д зааснаас бусад зуухны цэвэрлэгээнээс үүсэх шингэн лаг
		10 01 20	Нүүрсээр ажилладаг цахилгаан станцын түлшний хадгалалт, урьдчилан боловсруулалтаас үүсэх хаягдал
		10 01 21	Зуух, дулааны сүлжээ, хөргөлтийн усны цэвэрлэгээнээс үүсэх хаягдал
		10 01 99	Тусгайлан заагдаагүй бусад хог хаягдал
2	Ажилчдын байр	20 01 01	Цаас, картон
		20 01 02	Шил
		20 01 27	Хуванцар
		20 03 01	Холимог ахуйн хог хаягдал
3	Удирдлагын байгууламж	15 01 01	Цаасан болон кардонон сав баглаа боодол
		20 01 99	Тусгайлан заагдаагүй бусад хог хаягдал
4	Ариун цэврийн өрөө	20 03 01	Бохир танкны лаг
		20 03 05	Бохир ус цэвэрлэгээнээс гарсан хаягдал
		20 01 01	Цаас, картон
		20 03 99	Тусгайлан заагдаагүй бусад хог хаягдал
5	Шатахуун түгээх газар	20 01 01	Цаас, картон
		20 03 01	Холимог ахуйн хог хаягдал
6	Харуул хамгаалалтын байр	20 01 01	Цаас, картон
		20 03 01	Холимог ахуйн хог хаягдал
7	Лаборатори	15 01 01	Цаасан болон кардонон сав баглаа боодол
		15 01 02	Хуванцар сав баглаа боодол
8	Бохир ус цэвэрлэх байгууламж	19 08 01	Хөвөгдөс
		19 08 02	Шүүлгүүрийн хатуу үлдэгдэл
		19 08 03	Ахуйн бохир ус цэвэрлэгээний лаг
		19 02 99	Тусгайлан заагдаагүй бусад хаягдал
9	Ус зөвлүүлэх систем	19 09 01	Анхан шатны шүүлгүүрийн хаягдал ба хөвөгдөс
		19 09 99	Тусгайлан заагдаагүй бусад хаягдал
10	Барилгын материалын хог хаягдал	17 01 01	Бетон
		17 01 02	Тоосго
		17 01 05	Бетон, тоосгоны хаягдал
		17 02 01	Мод
		17 02 02	Шил
		17 02 03	Хуванцар
		17 08 04	Барилгын бусад холимог хаягдал



Аюултай, хяналттай хог хаягдал:

БОАЖ-ын Сайдын 2017 оны 12 сарын 12-ны өдрийн А/349-р тушаалаар батлагдсан аюултай, хяналттай хог хаягдлын жагсаалтаас харахад ДЦС-ын үйл ажиллагааны улмаас үүсэж болзошгүй дараах (*Хүснэгт 5.3*) хаягдууд байна. Эдгээр хаягдлыг аюултай хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журмын дагуу цахилгаан станцын талбай дээр түр хадгалан, дахин боловсруулах, устгах эрх бүхий тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж байгууллагад шилжүүлнэ.

Хүснэгт 59 Аюултай, хяналттай хог хаягдлын жагсаалт

#	Үүсэж болзошгүй хог хаягдлын эх үүсвэрийн нэр	Хог хаягдлын код	Хог хаягдлын кодчилсон жагсаалтад орсон нэр
1	Цахилгаан станц	10 01 01	Зуухны доод үнс
		10 01 02	Нүүрний дэгдэмхий хий
		10 01 15*	Шингэн хаягдлын анхан шатны цэвэрлэгээнээс үүсэх хортой бодис агуулсан лаг
		10 01 17*	Зуухны цэвэрлэгээнээс үүсэх аюултай бодис агуулсан усархаг шингэн лаг
		16 07 01*	Тос агуулсан хаягдал
2	Ажилчдын байр, удирдлагын байгууламж	20 01 21*	Хаягдал батерей
3	Ус зөөлрүүлэх систем	19 08 11*	Үйлдвэрийн хаягдал усны бусад цэвэрлэгээнээс үүссэн хортой бодис агуулсан лаг
5	Засварын газар	13 05 01*	Түлшний тос, дизель
		15 01 09*	Хортой бодисын үлдэгдэл агуулсан эсвэл бохирдсон сав баглаа боодол
		15 01 10*	Хортой сүвэрхэг материал бүхий метал сав, баглаа бооодол, хоосон даралтат сав
		15 02 01*	Хортой бодисоор бохирдсон шингээгч болон шүүлтууриний материал, бохир алчуур, тусгайлан заагдаагүй хамгаалалтын хувцас
		16 01 02*	Ашиглалтаас гарсан автомашин
		16 01 04*	Тосны шүүр
		17 05 01*	Хортой бодис агуулсан хөрс, чулуулаг

5.6 Хаягдлыг дахин ашиглах, дахин боловсруулах

ДЦС-ын үйл ажиллагаанд зориулан авчирсан материалын хэмжээг багасгаж дахин ашиглах аргыг хэрэгжүүлвэл зардлыг хэмнэж, гарах хог хаягдлыг бууруулна. Аливаа илүүдсэн материал, хэрэглэгдсэн техник тоног төхөөрөмж, түлшний сав, баглаа боодлыг тусгайлан бэлтгэсэн талбайд хадгалж (асгаралт алдагдлаас хамгаалсан), үйлдвэрлэгчид нь буцаах, хаягдал материал боловсруулдаг аж ахуйн нэгжид нийлүүлэх зэргээр хог хаягдлыг менежментийг зөв хэрэгжүүлэх шаардлагатай. Хог хаягдлыг дахин боловсруулдаг аж ахуйн нэгжүүдийг доор дурьдсан ба үүнээс сонгон цахилгаан станцаас гарах дахин боловсруулах боломжтой хог хаягдлыг хүргүүлэх нь зүйтэй. Дахин ашиглах боломжтой энгийн хог хаягдууд

- Цаас /хэт бодирдоогүй сонин, сэтгүүл, дэвтэр, бичгийн цаас, төрөл бүрийн боодлын цаас, картон цаас, сүү, жүүсний тетрапак савалгаа/



- Хуванцар /төрөл бүрийн ус, ундааны хуванцар сав, 0,025 мм-ээс дээш зузаантай гялгар уут, баглаа боодол кетчуп, ургамлын тос, бие угаагч шингэн, шампунь, угаалгын шингэний хуванцар сав, гм/
- Хөнгөн цагаан, төмөр, метал, зэс, гууль, тэдгээрээр хийсэн зүйл;
- Шил /хүнсний болон бүх төрлийн шилэн сав, шилэн эдлэл/;
- Лааз;
- Мод, модон эдлэлийн хаягдал;
- Хувцас, даавуун эдлэл;
- Савхи, резин;
- Θвс, мод
- Бусад зэрэг болно.

Цахилгаан станцын талбайд эдгээр хог хаягдлыг ангилан ялгаж, овор хэмжээг нь багасган тээвэрлэхэд тохиромжтой болгон хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрт хүргүүлэх шаардлагатай.

5.7 Хаягдлыг зайлцуулах, устгах

Хатуу хог хаягдлыг зайлцуулах:

ДЦС-ын үйл ажиллагааны улмаас үүссэн хог хаягдлыг байгаль орчинд аль болох бага нөлөөлөл үзүүлэх байдлаар цуглуулах, түр хадгалах, устгах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Хяналттай болон аюултай хог хаягдлын жагсаалтад орсоноос бусад хатуу хог хаягдлыг ангилан ялгаж, хог хаягдлын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасны дагуу хог хаягдлыг ангилах, ачих, цуглуулах технологид нийцсэн, галд тэсвэртэй материалыар хийгдсэн, хог хаягдал салхиар тархах, хур тунадасны ус хуримтлагдах, шүүрэл ялгарахаас сэргийлсэн зэрэг шаардлагуудыг хангасан хогийн савыг станцын хог хаягдал хамгийн их үүсдэг хэсгүүдэд байршуулах шаардлагатай. Хогийн саванд цугларсан хогны ангилалтын байдлыг дахин шалгаж, хог хаягдал түр хадгалах цэгт хадгална.

Дахин ашиглах, дахин боловсруулах хог хаягдлыг орон нутгийн тусгай зөвшөөрөлтэй компанийтай гэрээ байгуулан нийлүүлэх, эсвэл нийлүүлэгчид нь буцаах арга хэмжээ авах нь зүйтэй.

Аюултай хог хаягдлыг эх үүсвэр дээр нь түр хадгалах, тээвэрлэх

Хог хаягдлын тухай хуулиар хог хаягдлын өмчлөгч нь хог хаягдлын үүсгэгч байна гэж заасан.. Хог хаягдал үүсгэгч нь дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

- Аюултай хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, түүнд хяналт тавих,
- Үүсэх хог хаягдлын хэмжээг бууруулах, эргүүлэн ашиглах, хоргуйжүүлэх, устгах замаар байгаль орчинд ялгарах ялгарал, бохирдуулагчийн хэмжээг бууруулах,
- Өөрийн үйл ажиллагаанаас үүссэн аюултай хог хаягдлаа устгах тохиолдолд байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авах,
- Өөрийн үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлаа устгах болон дахин боловсруулах боломжгүй тохиолдолд аюултай хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, устгах, дахин боловсруулах экспортлох зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллагад шилжүүлэх,
- Хэвийн үйл ажиллагааны үед аюултай хог хаягдалтай харьцах болон аюул осолын үед ажиллах зааварчилгааг түүнтэй харьцаг ажилтан бүрээр боловсруулж, тэднийг сургаж, дадлагажуулах,



- Аихны тусламж үзүүлэх зааварчилгаа боловсруулж, шаардлагатай материал, хэрэгслээр хангах зэрэг болно.

Аюултай хог хаягдлыг эх үүсвэр дээр нь түр хадгалахдаа дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- ✓ Агааржуулалтын системтэй, тухайн хаягдлыг хадгалах нөхцөлийг хангасан орчинтой,
- ✓ Ангилан ялгасан байх,
- ✓ Агуулах сав нь агуулж буй хог хаягдалтайгаа урвалд ордоггүй материалаар хийгдсэн, эсвэл ийм материалаар доторлосон байх,
- ✓ Аюултай хог хаягдал гэсэн бичиглэлтэй, стандартаар тогтоосон тэмдэг, тэмдэглэгээтэй байх ба ил харагдахуйц газар тухайн хаягдлын нэр, хуримтлуулж эхэлсэн хугацааг тэмдэглэсэн байх (Аюултай хог хаягдал нь сард 1000 кг-аас их бол 90 хоног, 1000 кг-аас бага бол 180 хоног хадгална),
- ✓ Хог хаягдлын аюулын шинж чанар болон аюултай шинж чанар үзүүлэгч бүрэлдэхүүнийг итгэмжлэгдсэн лабораториор тодорхойлуулсан байх,
- ✓ Үүсэх хог хаягдлын төрөл, кодыг хог хаягдлын кодчилсон жагсаалтын дагуу тогтоосон байх,
- ✓ Гал унтраах хэрэгсэл, аюултай хог хаягдал асгарч алдагдсан үед ашиглах материал, хувийн хамгаалах хэрэгслийг шаардлагатай газар байрлуулж, ашиглалтын бэлэн байдлыг хангасан байх,
- ✓ Шаардлагатай газруудад аюултай хог хаягдал хариуцсан ажилтын овог нэр, утасны дугаар, гал унтраах хэрэгсэл, галын дохиолол, аюултай хог хаягдал асгарч алдагдсан үед ашиглах материалын байрлалыг заасан зураг, схем, галын дуудлага өгөх утасны дугаар зэрэг болно.

Аюултай хог хаягдлаа байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын олгосон зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллагаар тээвэрлүүлж, нийлүүлнэ..

5.8 Ахуйн болон тусгай ангиллын хог хаягдлын ангилан ялгалт хийх зөвлөмж

Уг төслийн үйл ажиллагаанаас гарах хог хаягдлыг эх үүсвэр дээр нь дахин ашиглагдах, энгийн, аюултай гэсэн ангиллаар ялгаж төрөл төрлөөр нь зориулалтын хогийн цэгт төвлөрүүлэх буюу устгалд оруулах шаардлагатай юм. Иймд доорх хүснэгтэд заасанчлан хогийн савнуудыг байрлуулж, саванд хаяг, пайз хадан түүндээ хог хаягдлаа хуримтлуулж зайлцуулж байх шаардлагатай.


Хүснэгт 60 Хог хаягдал ангилах

Хогны төрөл	Хадгалалт, тээвэрлэлт	Устгалд оруулах хэлбэр
Энгийн хог хаягдал	Ногоон өнгийн хогийн сав	Гэрээний дагуу ачуулах
Хуванцар сав, лааз	Цэнхэр өнгийн хогийн сав	Дахин боловсруулах эрх бүхий этгээдэд тушаах
Хоолны үлдэгдэл	Хүрэн өнгийн хогийн сав	Гэрийн тэжээвэр амьтдын хоол болгох





Зураг 42 Ахуйн хог хаягдал ангилан хийх сав



Зураг 43 Хог хаягдал хуримтлуулан зайлцуулах сав

Дээрх сав нь хатуу хог хаягдлыг ангилах, хадгалах, тээвэрлэх зориулалттай бөгөөд үүнийг орлуулан хийх боломжтой, хамгийн гол нь бөх бат шинжтэй, дотроо тусгаарлагчтай, битүүмжлэгдсэн, онгойлгоход хялбар, өргөж тээвэрлэхэд хялбар, дахин ашиглах боломжтой байх ёстой. Үүсэх ахуйн хатуу хог хаягдлыг тусгай зориулалтын саванд цуглувалж, орон нутагтай гэрээ хийж сард 2 удаа ачуулж байх.

Хог хаягдлын төрөл, хэмжээ нэмэгдэж цаг тухайд нь зохистойгоор зайлцуулахгүйн улмаас орчныг бохирдуулах эрсдэлтэй. Тиймээс эцсийн байдлаар үүсэх хог хаягдлын хэмжээг бууруулах үүднээс хог хаягдлын дараах эрэмбэлсэн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх нь зүйтэй. Үүнд:



- 1) **Багасгах:** Боломжтой бол хог хаягдал үүсэхээс зайлсхийх. Үүсэх хог хаягдлаас зайлсхийх үүднээс тухайн ажилчин нь хэрэглэж буй бүтээгдэхүүн материалыг аль болох байж болох боломжит дээд утгаар нь дуустал нь хэрэглэх шаардлагатай юм;
- 2) **Дахин ашиглах:** Боломжтой хаягдал хог, материалыг дахин ашиглана. Иймд тухайн материалыг хэрэглэж буй хүн хаягдал бага гарган ашиглах бүх арга замуудыг эрэлхийлэх шаардлагатай. Хэрэглэсэн мод, материалыг нутгийн иргэд бусад зорилгоор ашиглах нь үүний нэг жишээ болно;
- 3) **Дахин боловсруулан ашиглах:** Цаашид сайжирна гэж үзэж байгаа ч, одоогоор Монгол улсад хог хаягдлыг дахин боловсруулах боломж хязгаарлагдмал байдаг. Хаягдал мөн боловч дахин ашиглах боломжгүй цаас, мод, төмөр, хуванцар, шил гэх мэт материал буюу барааг дахин боловсруулах боломжтой ба энэхүү дахин боловсруулалтыг явуулах боломжтой;
- 4) **Ангилан ялгах:** Инерт, аюултай болон аюулгүй хог хаягдлыг ялгана. Мод, төмөр, хуванцар, инерт материал зэргийг ялгах нь хог хаягдлыг устгах зардлыг хэмнэж, иргэдэд ашиг тусаа өгөх зэрэг давуу талуудтай тул энэ нь эн тэргүүний зорилт байх ёстой;

Хүснэгт 61 Хог хаягдлыг дахин боловсруулах ашиглах чиглэлээр авах арга хэмжээ

№	Болзошгүй сөрөг нолохол	Үрьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ
1	Хаягдал дугуй	Автомашины хаягдал дугуйг ашиглан хийсэн резинэн хавтангаар амрагчдын чөлөөт цагаа ая тухтай өнгөрүүлэх спортын болон хүүхдийн тоглоомын талбайг тохижуулах бүрэн боломжтой. “Инахис” ХХК, 99008400, 98115097, www.mongolrubber.mn
2	Хаягдал гялгар уут, хуванцар	Хаягдал гялгар уут, хуванцарыг дахин боловсруулж хийсэн сандал, хогийн сав, явган хүний замын хавтан, автозамын хурд сааруулагч зэргийг ашиглан орчноо тохижуулах бүрэн боломжтой. “Сан-Оргиу” ХХК, 99093849, 95806849, www.mongolrubber.mn
3	Ашигласан моторын тос	Техникийн ажилласан хаягдал тосыг дахин ашиглаж Монгол эко тулиш, мазут үйлдвэрлэдэг тул автомашинаас хаягдах тосыг цуглуулж байгальд шууд хаялгүйгээр бүтээгдэхүүн болгох боломжтой, “Алтан оршихуй Групп” ХХК, 70005065, 99774277.
4	Ахуйн хаягдлаас органик хог хаягдлыг дахин ашиглах	Хоолны үлдэгдэл, хүнсний ногоо, жимс жимсгэний хальсыг ялгаж боловсруулан компост бордоо хийж ногоон байгууламжийт бордоход ашиглах боломжийг судлах: Ялзмаг бэлтгэх, компост биобордоог хийхэд зориулагдсан БИБ-1, БИО-АРИУС бүтээгдэхүүн, ШУА-ийн Ерөнхий болон биологийн сорилтын хүрээлэн, 99257129. Ялзмаг бэлтгэх, компост биобордоог хийхэд зориулагдсан ашигтай бичил биетний идэвхжүүлсэн биобэлдмэл EM-1, EMa, EM-5 бүтээгдэхүүн, Гарааны технологийн инкубатор ХХК, 99089698, 91138989, www.tech-inc.mas.ac.mn .



НЭГДСЭН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Байгаль орчин Ногоон хөгжлийн сайдын “Аргачлал батлах тухай” 2014 оны А-117 дугаар тушаалын 2 хавсралтын 3.7.2 хэсэгт зааснаар дүгнэлт хэсэгт байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний гол үр дүн буюу тухайн төслийг хэрэгжүүлэх явцад төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчин, нийгэм, түүх соёлын үнэт зүйлсүүдэд нөлөөлөх гол болон болзошгүй сөрөг нөлөөлүүд, тэдгээрээс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөг бууруулах, үр дагаврыг арилгах, нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгаалах чиглэлээр авч хэрэгжүүлэх гол арга хэмжээ, төслийн хаалтын үеийн зорилтууд, нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговор олгох, хяналт шинжилгээ хийх гол субъектүүд, түүнийг илтгэх үзүүлэлтуүдийг нэгтгэн дараах дүгнэлтийг хийж байна.

Үнд:

Дорнод бүсийн эрчим хүчний системийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний урт 2011 онд 3125.34 км байсан бол 2017 онд 3492.9 км болж 12%-иар өсөж, үйлдвэрлэлийн суурилагдсан хүчин чадал ашиглалт цахилгаанаар их ачааллын үед 100%-аас давж, 2015-2016 оноос эхлээд өвлийн их ачааллын хугацаанд ЦЭХ-ний хэрэглээг бүрэн хангах боломжгүй болсон тул Сүхбаатар аймгийн хэрэглэгчдийг ТБЭХС-д шилжүүлж, станцын үндсэн тоноглолууд бэлтгэлгүйгээр ажиллаж эхэлжээ. Цахилгааны оргил ачаалал суурилагдсан хүчин чадлаас давж 2017 онд 38.6 МВт хүрсэн ба цаашид бүс нутгийн ЦЭХ-ний өсөлтийг тогтвортой хангах боломжгүй болсон байна.

Энэхүү эрчим хүчний хэрэглээний огцом өсөлтийг хангах, эрчим хүчний найдвартай эх үүсвэрээр хэрэглэгчдийг хангах нь Зүүн бүс нутгийн эрчим хүчний хангамжийн тулгамдсан асуудал болж байна. Иймээс Монгол Улсын Засгийн газраас мөрийн хөтөлбөртөө эхний ээлжид богино хугацаанд хэрэгжих боломжтой хувилбар болох Чойбалсангийн ДЦС-ыг 50 МВт-аар өргөтгөх төслийг хэрэгжүүлэхээр техник эдийн засгийн үндэслэл боловсруулан Эрчим хүчний яамны Шинжлэх ухаан технологийн зөвлөлөөр хэлэлцүүлж дэмжигдсэн байна.

Чойбалсангийн ДЦС нь Чойбалсан хотын зүүн хэсэгт Хэрлэн голын хойно харьцангуй тэгш тохойд далайн түвшнээс 747.35-750.17 м өндөрлөгт нийт 25.76 га газрыг албан ёсоор эзэмших эрхтэй бөгөөд үүнээс 15.06 га газрыг одоогоор ашиглаж байна. Үлдсэн 10.7 га газрыг ашиглаагүй нөөц талбайтай байна.

Чойбалсангийн ДЦС-ын зүүн талд өргөтгөлийн барилга байгууламж барих хангалттай нөөц газар байгаа тул шинээр баригдах өндөр даралтын 50 МВт станцыг хуучин ДЦС-ын барилгыг зүүн тийш өргөтгөн залгуулж барих юм.

ДЦС-ыг 50 МВт хүчин чадлаар өргөтгөхөд 900 мян. м³ үнс агуулах багтаамжтай 4-р үнсэн санг шинээр байгуулах шаардлагатай байна. Дорнод аймгийн Засаг даргын захирамжаар 1, 2, 3 –р үнсэн сантай зэрэгцээ талбайд 4-р үнсэн сан байгуулахад зориулан 20.5 га газрыг “ДБЭХС” ТӨХК –д эзэмшүүлсэн байдаг. 4-р үнсэн сангийн талбайд 80-90 мян. м² талбайтай 2 үнсэн сан шинээр барих боломжтой.

Одоогоор ДЦС нь усан хангамжийг 4 гүний худгаас татдаг байна. Энэ нь өргөтгөлийн 50 МВт ДЦС-ын хэрэгцээнд шаардлагатай усаар бүрэн хангаж чадахгүй. Тиймээс өргөтгөх төслийн хүрээнд Турбин хими цехийн техникийн усан хангамжийг нэмэгдүүлэхийн тулд Хэрлэн голын хөндийд шинээр 5 ширхэг цооног өрөмдөн газрын гүний худаг гарган шийдвэрлэхээр ТЭЗҮ-д тусгасан байна.



ДЦС-ын үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд учирч болзошгүй нөлөөллийг тогтоохдоо энэ төслийн Байгаль орчны төлөв байдлын үнзлээний тайлан, байгаль орчны суурь нөхцөл, дүгнэлт, урьд өмнө хийгдсэн байгаль, нийгэм, эдийн засгийн холбогдолтой судалгааны материалууд, судалгаа явуулсан мэргэжлийн экспертуудийн дүгнэлтүүдийг үндэслэн матриц, магадлан жагсаах зэрэг аргыг ашиглан хийж гүйцэтгэлээ.

Матрицын аргаар үнэлсэн дүнгээс авч үзэхэд нийт нөлөөлийн дүнгээс төслийн төлөвлөлт 25 буюу 19.8%, нүүрсний агуулах, тээвэрлэлт 25 буюу 19.8%, үнсэн сан 22 буюу 17.4%, хатуу хог хаягдал 20 буюу 15.8% -ийг эзэлэж байна. Нөлөөллийн эрчмийн хувьд төслийн барилга байгууламж барих үйл явц болон нүүрс хадгалах талбай, үсэн сангаас үүсэх нөлөөлөл илүү эрчимтэй нөлөөлөхөөр байна.

Байгалийн бүрэлдэхүүн хэсэг болох хөрсөн бүрхэвчинд 15%, агаарын чанарт 17.5%, ургамлан нэмрөгт 15%, хүний эрүүл мэндэд 15% сөрөг нөлөөлөл үзүүлэхээр байна.

“Дорнод бүсийн эрчим хүчиний систем” ТӨХК-ийн ДЦС төслийн БОННҮ-ний тайлангийн ажлын хүрээнд хийгдсэн судалгаа, шинжилгээний ажлын үр дүнд тулгууралсан дараах зөвлөмжүүдийг үйл ажиллагаанд тусган ажиллах шаардлагатай. Үүнд:

- ✓ Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. эрүүл ахуй. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага, Хөдөлмөрийн хамгаалах хэрэгсэлд тавих ерөнхий шаардлага, Хамгаалалтын хувцас ерөнхий шаардлага, Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Ажлын байрны гэрэлтүүлгийн норм, хэмжих аргад тавигдах ерөнхий шаардлага гэх мэт хөдөлмөр хамгааллын хууль, дүрэм журам, стандартуудыг баримталж ажиллах хэрэгтэй.
- ✓ БОННҮ-ний ажилд тусгагдсан байгаль орчныг хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах, болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр өгөгдсөн заавар зөвлөмжийг мөрдөн ажиллах
- ✓ Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан байгаль орчныг хамгаалах чиглэлээр гүйцэтгэх ажлуудад шаардагдах хөрөнгө зардлыг жил бүрийн санхүүгийн төлөвлөгөөнд тусган зарцуулалтад хяналт тавих
- ✓ Хөрс, ус, агаарын мониторингийг орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт байнга тусган шинжилгээг тогтмол явуулснаар урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүсж болох эрсдэлийг бууруулах бүрэн боломжтой.
- ✓ Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10^1 -т заасны дагуу Байгаль орчны төлөвлөгөөт аудитыг 2 жил тутамд хийлгэж байх хэрэгтэй.
- ✓ Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх журамын дагуу Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг 5 жил тутамд хийлгэж байх хэрэгтэй.
- ✓ Цахилгааны зарцуулалт хамгийн багатай тоног төхөөрөмжүүдийг сонгож ашиглах, хөдөлгөөн мэдэрч асдаг гэрэлтүүлэг, лед гэрэл болон нарны толин гэрэлтүүлгийг боломжит хэсгүүдэд суурилуулж ашиглах, мөн нарны эрчим хүчийг ашиглах бусад боломжуудыг судлах
- ✓ Хог хаягдал ил задгай шатаахгүй байх, хориглосон, анхааруулсан самбар, хаяг хийж зохих газруудад байршуулах
- ✓ Ахуйн гаралтай хатуу хог хаягдлыг зориулалтын сав, цэгт хадгалах, зохих цэвэрлэгээ, халдвартайжүүлэлт хийх, барилгын гаралтай хог хаягдлыг орон нутгийн ЗДТГ-тай гэрээ байгуулан зайлзуулах.
- ✓ Хог хаягдлыг ангилан ялгаж, дахин ашиглах буюу дахин ашигладаг хувь хүн, албан байгууллагуудад нийлүүлэх
- ✓ Төслийн барилга байгууламж, зам талбайг тогтоосон зураг төслийн дагуу барьж байгуулах, тээврийн хэрэгслийн тогтоосон замаар явуулах



- ✓ Нүүрс буулгах талбай болон үнсэн сангийн талбайг тайланд тусгасан зөвлөмжийн дагуу хашаалах
- ✓ Дулааны цахилгаан станцаас гарч байгаа хаягдал үнсийг барилгын материал үйлдвэрлэдэг байгууллага аж ахуйн нэгжид ашиглуулахгүй байх
- ✓ Үнсэн сангийн орчмын үнсний хаягдаатай хэсгүүдийн хөрсийг цацрагийн дэвсгэр түвшний хэвийн нөхцөлийг хангаж ажиллах
- ✓ Станцын өргөтгелийн хүрээнд химиин бодисын агуулахыг MNS 6458 : 2014 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химиин хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлагын дагуу барьж байгуулах
- ✓ Авто тээврийн хэрэгсэл болон явган хүний зориулалтын зорчих зам, зогсоол байгуулах, олон салаа зам гаргахаас сэргийлэх, анхааруулсан тэмдэг, тэмдэглэгээ байршуулах
- ✓ Шугам хоолойг байнга шалгаж байх, эвдэрч гэмтсэн тохиолдолд нэн даруй засах арга хэмжээ авах
- ✓ Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн хуулийн хугацаа нь 5 жил /2023-2027/ бөгөөд цаашид хүчин чадал нэмэгдэх, технологи шинэчлэгдэх нөхцөлд уг тайланд дахин нэмэлт тодотголын ажил хийлгэх шаардлагатай.
- ✓ Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бусийн дэглэмийг мөрдөх журмыг баримталж ажиллах

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд тусгасан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зөвлөмж, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу ажиллавал тус төслийг хэрэгжүүлэх боломжтой гэж үзэж байна.



АШИГЛАСАН МЭДЭЭЛЭЛ, ЭХ СУРВАЛЖ

1. Байгаль Орчин, Аялал жуулчлалын Сайдын 2014 оны 04 сарын 10-ны өдрийн А-117 дүгээр тушаалаар батлагдсан “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал” 2014 он.
2. Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам. Байгаль орчны мэдээллийн сан, Тусгай хамгаалалттай газар нутгийн мэдээллийн сан. <http://www.eic.mn/spa/gis.php>;
3. ШУА, Газар зүйн хүрээлэн. Монгол улсын үндэсний атлас, 2009 он;
4. Газрын гадаргын хээрийн судалгааны бичиглэл, 2017.10 сар;
5. 1:100,000 масштабтай байр зүйн зураг;
6. Сансрин зураг (Google Earth);
7. Д.Доржготов. Монгол орны хөрс . УБ 2003 он.
8. “Монгол улсын үндэсний атлас”
9. А.Авирамд, “Монгол орны ойг нөхөн сэргээх, хамгаалах заавар, зөвлөмж”, УБ 2004
10. Нацагдорж Л. Монгол орны нутаг дэвсгэр дээрх ургамал ургалтын хугацааны хур тунадасны зарим онцлог, түүний өөрчлөлтийн тухайд- Монгол орны геоэкологийн асуудлууд , № 5, 2005, х. 157-177
11. Нацагдорж. Л. Гомболүүдэв П. Монгол орны салхины эрчим хүчний нөөцийн үнэлгээний асуудалд. -“Экологи, тогтвортой хөгжил” эмхтгэл, Дугаар 5, 1999 он.
12. Нацагдорж Л. Баясгалан Г. Гомболүүдэв П. Монгол орны нутаг дэвсгэр дээрх уур амьсгалын шинэхэн өөрчлөлтийн тухайд- ШУА-ийн мэдээ, 2005, Дугаар 178
13. Байгаль орчны төлөв байдлын үнэлгээний тайллан
14. Ш.Цэгмид. Монгол орны физик газарзүй УБ. 1967 он.
15. Өлзийхутаг Н, Монгол орны ургамлын аймгийн тойм УБ. 1989 он.
16. Д.Энэбиш, Д.Мягмарсүрэн “Монгол улсын тусгай хамгаалалттай газар н=утаг”
17. Өлзийхутаг Н. Монгол орны ургамлын аймгийн тойм. УБ. 1986 он.
18. Ус цаг уурын хүрээлэнгийн 2005 оны тайлангаас
19. ШУА-ийн Геоэкологийн хүрээлэн. Ногоон байгууламж байгуулах нь. УБ 2003 он.
20. www.1212.mn
21. www.wikipedia.org
22. www.google.com
23. www.eic.mn





“ДОРНОД БУСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ
СИТЕМ” ТӨХК-Д

**МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ**

Засгийн газрын II байр, Нагдсон Үндэстний гудамж 5/2,
Чингалтэй дүүраг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 19 66, Факс: (976-51) 26 61 71.
Цахим шуудан: contact@met.gov.mn,
Цахим хуудас: www.met.gov.mn

2022.06.28 № 12/3668

танай _____ -ны № _____ -т

Ерөнхий үнэлгээний дүгнэлт
хүргүүлэх тухай

ТхАна -Тогтолцоо

Борчир
VII/07

Танай байгууллагаас ирүүлсэн Дорнод аймгийн Хэрлэн сумын нутагт хэрэгжиж буй “Дулааны цахилгаан станц”-ийн төслийн байгаль орчны төлөв байдал болон бусад материалтай танилцаж Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, Засгийн газрын 2013 оны “Журам батлах тухай” 374 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх журам”-д заасан аргачлалын дагуу байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийлгээ.

Ерөнхий үнэлгээний дүнгээр уг төсөлд батлагдсан аргачлалын дагуу байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэх шаардлагатай гэж үзэв.

Ерөнхий үнэлгээний гүйцэтгэлийн хуудаст заасан нарийвчилсан үнэлгээний явцад тодруулах асуудлууд, онцгойлон анхаарах чиглэлийг үндэслэн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар хийлгэж 2022 оны 4 дүгээр улиралд багтаан тус яаманд ирүүлэхийг үүгээр мэдэгдье.

Ерөнхий үнэлгээний гүйцэтгэлийн хуудсыг хавсаргав.

Хавсралт ... хуудастай.

ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ

ГЭНХМӨНХ



**ҮНЭЛГЭЭНИЙ ХҮСЭЛТ, БАРИМТ БИЧИГ
ХҮЛЭЭН АВАХ МАЯГТ**

Төсөл хэрэгжүүлэгчийн нэр, хаяг: "ДОРНОД БУСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИТЕМ"
ТӨХК, Дорнод аймаг, Чойбалсан хот, 21065

Холбоо барих утас, И-мэйл хаяг: 70584545

Төслийн нэр: Дорнод аймгийн Хэрлэн сумын нутагт хэрэгжиж буй "Дулааны цахилгаан станц"-ийн төсөл.

Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, байршил: Дорнод аймгийн Хэрлэн сум.

Баримт бичгийн нэр	Шаардлагатай зөсж	Шаардлагатай хангасан зөсж	Тайлбар
Төсөл хэрэгжүүлэгчийн ерөнхий үнэлгээ хийлгэх тухай хүсэлт /албан бичиг/	Тийм	+	
Эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан ТЭЗҮ, зураг төсөл	Тийм	+	Эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан зураг төсөл хийлгэсэн.
Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө, хөтөлбөрт тусгагдсан зөсж /газрын зөвшөөрөл, ТХГН-т байрлах бол Хамгаалалтын захиргааны санал/	Тийм	+	
Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчны төлөөв байдлын үнэлгээний тайлан	Тийм	+	"Эко Ти Эс Би" ХХК боловсруулсан.
Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчны төлөөв байдлын тодорхойлолт	Үгүй		
Төсөл хэрэгжих орчны тойм зураг (топо, сансрын)	Тийм	+	
Тухайн сум, дүүргийн Засаг даргын тодорхойлолт	Тийм		Сумын засаг даргын 2022.04.25-ны өдрийн 01/304, дугаар албан бичиг.
Аж ахуйн нэгжийн гарчилгээний хуулбар /нотариатаар батлуулсан байх/	Тийм	+	
Тусгай тэмдэглээ: "ДОРНОД БУСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИТЕМ" ТӨХК-ийн төслийн "Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан"-т Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын "Аргачлал батлах тухай" 2014 оны А-117 дугаар тушаалтын дагуу хийлгэх шаардлагатай гэж үзлээ.			
Ерөнхий үнэлгээ хийлгэх хүсэлт, материалыг хянасан: БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМНЫ ШИНЖЭЭЧ			 O.AMARSANAА

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

**ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН
ХУУДАС**

2022 оны 06-р сарын 27

Улаанбаатар хот

Дугаар 2022/ОА-90

Төсөл хэрэгжүүлэгчийн нэр, хаяг: "ДОРНОД БУСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИТЕМ" ТӨХК, Дорнод аймаг, Чойбалсан хот, 21065

Холбоо барих утас, И-мэйл хаяг: 70584545

Төслийн нэр: Дорнод аймгийн Хэрлэн сумын нутагт хэрэгжиж буй "Дулааны цахилгаан станц"-ийн төсөл.

Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, байршил: Дорнод аймгийн Хэрлэн сум.

Санал: Сумын засаг даргын 2022.04.25-ны едрийн 01/304, дугаар албан бичиг, И-Монгол цахим системийн О99-2205-000295 дугаар хүснэгтийг тус тус үндэслэв.

Беренхийн үнэлгээний төл шалгуурчилж	Нийцээн Нийцэгүүл	Чарширчилжье үнэлгээний шаврдлагатам	Үндэслэль тийнээр
Байгаль орчныг хамгаалах хууль тогтоомжийн нийцэл	Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа байгаль орчныг хамгаалах болон байгаль орчинд нөлеөлөх байдлын үнэлгээний тухай хууль тогтоомжийн холбогдох заалт	Тийм	Нарийвчилсан үнэлгээний явцад хууль тогтоомжийн нийцлийг нарийвчлан тодорхойлох
Төрийн бодлого, шийдвэрийн нийцэл	Төрөөс баримтлах бодлогын баримт бичиг, Стратегийн үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийн холбогдох заалт	Тийм	Нарийвчилсан үнэлгээний явцад хууль тогтоомжийн нийцлийг нарийвчлан тодорхойлох
Төслийн байршил, түүнтэй холбогдох шалгуурууд	Газрын тухай хууль тогтоомжид нийцсэн эсэх	Тийм	Нарийвчилсан үнэлгээний явцад хууль тогтоомжийн нийцлийг нарийвчлан тодорхойлох

Теслийн байгаль орчны нелөөллийн урьдчилсан үнэлгээ	Тесөл хэрэгжих нутаг дэвсгэр нь хүний нелөө, байгаль цаг уурын өөрчлөлтөд эмзэг, мэдрэмтгий эсэх			Тийм	
	Тесөл хэрэгжих нутаг дэвсгэр, түүний ойр орчимд улс, орон нутгийн хэтийн хөгжилд ашиглахаар төлөвлөсөн, серөг нелөөлөлд өртөж болзошгүй газар байгаа эсэх			Тийм	
	Болзошгүй хуримтлагдах нелөөлөл үүсгэх эсэх			Тийм	
	Агаарын чанар				
Теслийн байгаль орчны нелөөллийн урьдчилсан үнэлгээ	Бохирдуулагч болон аюултай, хортой бодис агаар мандалд ялгаруулах, эсэх			Тийм	
	Дуу чимээ, доргио чичиргээ, гэрлийн болон дулааны нелөөлөл, цахилгаан соронзон цацраг үүсэх, эсэх			Тийм	
<ol style="list-style-type: none"> 1. Теслийн явцад орчны бохирдол, тоосжилтыг тооцож, үйл ажиллагаанаас агаарт үзүүлж болзошгүй нелөөллийг тодорхойлох, 2. Теслийн үйл ажиллагаанаас гарах хатуу, шингэн хог хаягдлын байгаль орчинд үзүүлэх серөг нелөөллийг тогтоож, арилгах, бууруулах, байгаль орчинд халгүй аргаар зайлцуулах арга хэмжээг төлөвлөх, 					

Усан орчин				
Гадаргын болон газрын доорх усны нөөцийн хомдол үүсэх, эсэх			Тийм	
Цэнгэг усны нөөцийг ашиглах, эсэх			Тийм	
Гадаргын болон газрын доорх усанд бохирдол үүсэх, эсэх			Тийм	
<p>1. Газрын доорхи болон гадаргын усны нөхцөл байдлыг тодорхойлж, төслийн үйл ажиллагааны явцад ашиглах усны эх үүсвэр, хэмжээг тодорхойлж, түүнтэй уялдуулан нарийвчилан тооцох;</p> <p>2. Төслийн үйл ажиллагаанаас усны нөөц, горим чанарт үзүүлэх нөлөөллийг тогтоож, түүнд тавих хяналт, хугацаа, хөрөнгө зардлыг нарийвчилан тооцох;</p> <p>3. Усны алдагдлыг багастах, усыг хэмнэлттэй ашиглах технологийн хувилбарыг судалж, тайланда тусгах;</p> <p>4. Ахуйн бохир усны хэмжээ, найрлагыг нарийвчилан тогтоож, түүнийг байгаль орчинд халгүйгээр зайлцуулах арга хэмжээ, түүнд шаардагдах зардлыг тооцох;</p> <p>5. Усны тухай хууль, тогтоомж болон бусад хууль тогтоомжоор хориглосон хязгаарласан бусийн дэглэмийг зөрчихгүй байх талаар зөвлөмж боловсруулж тайланда хавсаргах;</p>				
Хөрсөн бүрхэвч				
Хөрсөн бүрхэвч эвдрэх, эсэх			Тийм	
Хөрс бохирдуулах эсэх			Тийм	
Хөрс доройтох, цөлжих эсэх			Тийм	
<p>1. Төслийн үйл ажиллагааны явцад хөрс, газрын хэвлийд үзүүлэх серег нөлөөлөл, түүнийг багасгах, арилгах, цөлжилт, хөрсний эвдрэлээс урьдчилан сэргийлэх арга зам, түүнд шаардагдах хөрөнгө зардлыг төлөвлөх;</p> <p>2. Хатуу, шингэн хог хаягдал, техник технологийн ашиглалтын явцад хөрс бохирдуулахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөх;</p> <p>3. Олон салаа зам гаргах, хөрс бохирдох, эвдрэхээс сэргийлэх, тогтсон нэг орц, гарцыг тогтоох;</p> <p>4. Эвдэрсэн газрыг нөхөн сэргээх төлөвлөгөөг холбогдох зураг төслийн хамт болоасруулж, тайланда хавсаргах;</p>				
Ургамлан нэмрэг				
Ургамлан нэмрэг, ой мод ертөх эсэх			Тийм	Ургамлан нэмрэг ертөнө.

	Ховор, нэн ховор ургамлын төрөл зүйлс өртөх, эсэх			Тийм	Нарийвчилсан үнэлгээгээр тодорхойлох
1. Төслийн үйл ажиллагаа явуулахад өртөх талбайн ургамлын нэр төрөл, тархалтыг тогтоох, ховор болон нэн ховор ургамал байгаа эсэх талаар дүгнэлт гаргаж, хэрэв тэдгээр нь төслийн үйл ажиллагааны явцад өртөхөөр байвал түүнийг хамгаалах, болон шилжүүлэх арга хэмжээ, түүнд шаардагдах харенгэ зардлыг төлөвлөх;					
2. Эдэлбэр газар, орчныг тохижуулах, ногоон байгууламж байгуулах талаар мэргэжлийн түвшний зөвлөмжийг шаардагдах зардлын хамт боловсруулж, тайланд тусгах;					
3. Төслийн үйл ажиллагааны улмаас сөрөг нэлэөлөлд өртөх болзошгүй биологийн төрөл зүйлийн бүрэлдэхүүнийг нарийвчилан тогтоож, хамгаалах арга замыг цогц байдлаар шийдэхэд заавар, зөвлөгөө өгөх, тайланд тусгах;					
Амьтны аймаг					
	Зэрлэг амьтдын амьдрах орчинг доройтуулах, эсэх			Тийм	
	Ховор, нэн ховор амьтан өртөх, эсэх			Тийм	
Нийгмийн нэвээллийн урьдчилсан үнэлгээ	Нутгийн оршин суугчид				
	Газар эзэмших, ашиглах эрх зөрчигдэх, эсэх	Тийм			
	Нутгийн оршин суугчдын нийгмийн байдалд сөрөг нэлэөлөлтэй, эсэх			Тийм	
	Нэлэөлөлд өртөх болзошгүй төв, суурин газар байгаа, эсэх			Тийм	
	Нүүлгэн шилжүүлэх асуудал үүсэх, эсэх			Тийм	
Түүх, соёлын биет өв					
	Сөрөг нэлэөлөлд өртөх түүх,			Тийм	

	соёлын үнэт зүйлс бий эсэх				
Хүний эрүүл мэндэд нөлөөлех нөлөөлөл					
	Нутгийн иргэд, оршин суугчдын эрүүл мэндэд сергээр нөлөөлөх эсэх			Тийм	
	Төслийн бүх үе шатанд хүний эрүүл мэнд, амь насанд эрдэл үүсэх эсэх			Тийм	
	1. Төслийн үйл ажиллагаа болон байгалийн гамшигаас үүдэн гарч болзошгүй ослын үнэлгээ хийж, ослоос сэргийлэх, түүнийг багасгах, арилгах арга хэмжээг тодорхойлж тайланд тусгана.				
Нэгдсэн дүгнэлт: Ерөнхий үнэлгээний гүйцэтгэлээр уг төсөлд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны "Аргачлал батлах тухай" А-117 дугаар тушаалтын хавсралтын дагуу хийлгэн, нарийвчилсан үнэлгээний тайланг тус яаманд 2022 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлж, шүүмжхийлгэн, шийдвэр гаргуулах шаардлагатай гэж үзлээ.					
Онцгойлон анхаарах зүйлс:					
<ol style="list-style-type: none"> 1. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг батлагдсан аргачлалын дагуу боловсруулах, тухайн багийн ИНХ-аар хэлэлцүүлэх 2. Дулааны цахилгаан станцын хаягдлын сангаас үүсэх нөлөөллийг нарийвчлан тооцож тайланд тусгах. 3. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэгт "Төсөл хэрэгжүүлэгч нь холбогдох эрх бүхий байгууллагаар баталгаажсан техникийн застийн үндэслэл..."-ийг бүрдүүлнэ гэсний дагуу ТЭЗҮ боловсруулж баталгаажуулан, БОННҮ-нд хавсаргах 4. Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх аливаа серег нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг тусгасан Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулж, түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг нарийвчлан гаргах; 5. Төслийн үйл ажиллагааны явцад унд ахуйд ашиглах цэвэр усны хэрэглээний хэмжээг эх үүсвэртэй уялдуулан, түүнээс гарах ахуйн бохир усыг тус тус нарийвчилан тооцох, түүнчлэн хог хаягдлын менежментийн асуудлыг бүлэг болгон байгаль орчинд халгүйгээр зайлуулах аргыг нарийвчилан тодорхойлох; 6. БОННҮ-нд байгаль орчинд ээлтэй, олон улсын стандартад нийцсэн технологийг ашиглах талаар заавар, зөвлөмжийг боловсруулах; 7. Байгаль орчныг хамгаалах тухай хууль болон холбогдох бусад дүрэм, журамд заасны дагуу Байгаль орчин, аялал жууулчлалын сайдын 2010 оны 156 дугаар тушаалаар батлагдсан "Байгаль орчны хохирлын үнэлгээ, нөхөн төлбөр тооцох аргачлал"-ын дагуу төслийн үйл ажиллагаанаас ургамал, хөрс, ус, амьтан, агаар орчинд учруулах хохирлыг байгалийн бурэлдэл тус бүрээр тогтоож, улмаар тухайн газрыг эвдрэлд оруулснаар учирч болох хохирлыг урьдчилан тооцож нийлбэр үнэлгээ гарган төслийг хэрэгжүүлэх байгаль орчны хариуцлагын болон эдийн засгийн үндэслэлийг тодруулж дүгнэлт гаргах; 					

8. Төслийн үйл ажиллагааны явцад баримтлах хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгаа, ажиллагсадын эрүүл мэнд, ажлын байрны эрүүл ахуйн талаар зөвлөмж, дүгнэлт боловсруулах;
9. Нарийвчилсан үнэлгээ хийх явцдаа төслийн байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлж болзошгүй сөргөт нөлөөллийг тогтоон, түүнээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний талаар зөвлөмж боловсруулан тайланд тусгах;
10. Байгаль орчны хамгаалах тухай хуулийн 10¹ дүгээр зүйлд заасны дагуу байгаль орчны төлөвлөгөөт аудитыг 2 жил тутамд төслийн үйл ажиллагаанд хийх асуудлыг холбогдох зардлын хамт тайланд тусгах;
11. Төслийн хүрээнд баригдах дэд бүтцийн барилга, байгууламжийн батлагдсан зураг төслийг тайланд хавсаргах бөгөөд ариун цэврийн байгууламжийн шийдлийг зайлшгүй тусгах шаардлагатай ба халаалтын асуудлыг байгаль орчинд ээлтэй аргаар шийдвэрлүүэн тусгах шаардлагатай;
12. "Тэрбум мод" хөтөлбөрийн хүрээнд төслийн хүчин чадалтай уялдуулан тарих модны тоо, төрөл зүйлийг тайланд тодорхой тусгах.
13. Төслийн үйл ажиллагаанаас суурьшлийн бүсэд нөлөөлж байгаа эсэхийг нарийвчлан тооцож тайланд тусгах.
14. "Химиин хорт болон аюултай бодисын тухай" хуулийн 8, 9, 10, 12, 13, 14, 17, 18 дугаар зүйл, заалтуудыг тогтмол мөрдөж ажиллах;
15. Химиин хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журмын 2.3, 3.1 дэх заалтыг тайланд тусгах;
16. "Химиин хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулахын /Ерөнхий шаардлага/ MNS 6458:2014/ стандарт"-ыг баримтлах, тайланд тусгах;
17. БОНХ-н сайд, Эрүүл мэндийн сайд, Онцгой байдлын ерөнхий газрын даргын хамтарсан 2012 оны А-50\378\565 дугаар тушаалаар батлагдсан аргачлалын дагуу Химиин бодисын эрсдэлийн үнэлгээг хийх;
18. Хог хаягдлын тухай хууль, тогтоомжийг мөрдеж

Заавал хэрэгжүүлэх шаардлагатай дээр дурдсан арга хэмжээг цаг хугацаанд нь ханган биелүүлээгүй тохиолдолд ерөнхий үнэлгээний дүгнэлтийг хүчингүй болгохыг мэдэгдэж байна.

Бусад зүйлс:

1. Хууль тогтоомжийг биелүүлэх, мөрдэх, төслийн үйл ажиллагаатай холбогдуулж орон нутгийн засаг захиргааны болон байгаль орчны хяналтын байгууллагаас тавигдах нэмэлт шаардлагыг цаг тухай бүрт нь ханган биелүүлж байх;
2. Нарийвчилсан үнэлгээний тайланд шүүмж хийлгэн дүгнэлт, шийдвэр гаргуулах асуудлыг ерөнхий үнэлгээгээр тогтоосон хугацаанд хэрэгжүүлэх;
3. Ерөнхий үнэлгээнд заасан чиглэл, нөхцөл, болзоос өөр үйл ажиллагаа явуулах болон төсөлд өөрчлөлт орох, эсхүл өргөтгөх, шинэ тоног төхөөрөмж, технологи нэвтрүүлэх бүрт Ерөнхий үнэлгээнд хамрагдаж байх;

Ерөнхий үнэлгээ хийсэн:
**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ЯАМНЫ ШИНЖЭЭЧ**

О.АМАРСАНАА

Ерөнхий үнэлгээний үр дүнг зөвшөөрсөн:
**"ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИТЕМ"
ТӨХК -НИЙ РҮҮЦЭТГЭХ ЗАХИРАЛ**



Г.ОТГОНБААТАР

--- ооо ---

ДОРНОД АЙМАГ
ХЭРЛЭН СУМЫН ЗАСАГ ДАРГА

21060, Чойбалсан, Дорнод аймаг


Утас: 7058-4556, 7058-4283

2022. 04. 25 № 1/304

танай _____ -ны № _____ -т

Г 7
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ЯМАНД

Тус сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа ДБЭХС ТӨХК нь байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд тодотгол хийлгүүлэхээр хүсэлт гаргасан тул дэмжиж уламжлав.



00622242

ХЭРЛЭН СУМЫН // ДҮГЭЭР БАГИЙН ИРГЭДИЙН НИЙТИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ.

Ийдэ он 10 сар 16. өдөр

№ 03 Чойбалсан хот


ТӨСӨЛ ДЭМЖИХ ТУХАЙ

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.8 дахь хэсэг, Байгаль орчин нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.8 дахь хэсгийг үндэслэн Хэрлэн сумын 1-р багийн ИРГЭДИЙН НИЙТИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДЭС ТОГТООХ нь:

1. Тус багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй "Дорнод бүсийн эрчим хүчний систем" ТӨХК-ийн "Дулааны цахилгаан станц" төслийн байгаль орчинд нөлөөлөх нарийвчилсан үнэлгээ гаргуулахыг дэмжсүгэй.
2. Төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу байгаль орчныг хамгаалах, үнэлгээгээр тогтоогдсон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах урьдчилан сэргийлэхэд анхаарч иргэдийн саналыг харгалzan үзэхийг "Дорнод бүсийн эрчим хүчний систем" ТӨХК-ний захирал Г.Отгонбаатарт уламжилсугай.
3. Хэрлэн сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага аж ахуй нэгжтэй багийн тохижилт, нийтийг хамарсан их цэвэрлэгээ, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил болон холбогдох хууль тогтоомж, журмын хэрэгжилтийг хангулж ажиллахыг багийн Засаг дарга Р.Энхцэцэгт үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Ш.ЁЛ



ХЭРЛЭН СУМЫН 1 ДҮГЭЭР БАГИЙН ИНХ-ЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Хэрлэн сум

2022-10-06

БИНХ-ЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛ 2022 ОНЫ 10 ДУГААР САРЫН 06 НЫ ЕДЭР 11 ЦАГТ БАГИЙН ЗАСАГ ДАРГЫН ӨРӨӨНД ЯВАГДСАН. ХУРАЛД БАГИЙН ИРГЭДИЙН НИЙТИЙН ХУРАЛДААН ДАРГА Ш.ЁЛ, ТЭРГҮҮЛЭГЧ Л.ОЮУНБИЛЭГ, Θ.ОЮУНЧИМЭГ, Ц.МӨНХСАЙХАН БАГИЙН ЗАСАГ ДАРГА Р.ЭНХЦЭЦЭГ, НАР ОРОЛЦОВ. ХУРЛЫН ИРЦ 80%-ТАЙ БАЙЛАА.

Хурлаар хэлэлцэх асуудал:

- Цахилгаан дулааны эрчим хүч үйлдвэрлэн түгээх үйл ажиллагаа явуулдаг "Дорнод бусийн эрчим хүчиний систем" ТӨХК-ийн "Дулааны цахилгаан станц" төслийн байгаль орчны нэлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгүүлэхийг дэмжиж өгөхийг хүссэн хүсэлтийг хэлэлцэн шийдвэрлэх тухай.
- Хэлэлцсэн нь:
